

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-80

1.Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох 5-35

2.Хаврын тариалалтын бэлтгэл ажил, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох 35-49

3.Махны экспортын асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох 49-67

4.Барагшуны нөөц, ашиглалтын талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох 67-80

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
04 дүгээр сарын 08-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 58.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 15 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: П.Батчимэг, Г.Ганбаатар, С.Ганбаатар, С.Лүндэг, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, Б.Найдалаа, Н.Наранбаатар, Р.Сэддорж;

Нэг.Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Уянга, М.Ганхүлэг, Ж.Чинбүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат, Б.Заяабал, З.Мэндсайхан нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг хуралдааныг 15 цаг 08 минутаас 15 цаг 20 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ж.Батжаргал, С.Замира, М.Мандхай, Р.Батболд нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан үг хэлэв.

Б.Бейсен: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 7

Бүгд: 15

53.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хаврын тариалалтын бэлтгэл ажил, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтөгтох нар байлцав.

Хаврын тариалалтын бэлтгэл ажил, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Идэрбат, С.Замира нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, С.Замира, Ц.Идэрбат нар үг хэлэв.

Хаврын тариалалтын бэлтгэл ажил, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Махны экспортын асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Махны экспортын асуудлын талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, Б.Уянга, С.Замира, М.Мандхай, М.Ганхүлэг нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хуралдааныг 17 цаг 23 минутаас 17 цаг 31 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Замира, М.Ганхүлэг, Б.Бейсен нар үг хэлэв.

Махны экспортын асуудлын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 18 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Барагшуны нөөц, ашиглалтын талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга П.Цогтсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Барагшуны нөөц, ашиглалтын талаарх мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, Б.Бейсен нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, С.Замира, Ж.Чинбүрэн, Б.Бейсен нар үг хэлэв.

Барагшуны нөөц, ашиглалтын талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 18 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 33 минут үргэлжилж, 24 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 18 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 15 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 54.2 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Ирцийг танилцуулъя.

Буланы Бейсен 3 дугаар тойрог ирсэн байна. Очирбатын Амгаланбаатар 2 дугаар тойрог ирсэн байна. Тилеуханы Аубакир 3 дугаар тойрог ирсэн байна. Жигжидийн Батжаргал 5 дугаар тойрог ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн 6 дугаар тойрог ирсэн байна. Сонгобайгийн Замира жагсаалтаар ирсэн байна. Мэндбаярын Мандхай жагсаалт ирсэн байна. Загджавын Мэндсайхан 2 дугаар тойрог ирсэн байна. Агваанлуvsсангийн Ундраа гишүүн, жагсаалт ирсэн байна. Болдын Уянга гишүүн жагсаалт ирсэн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн 8 дугаар тойрог ирсэн байна.

Хэлэлцэх асуудал танилцуулъя.

1.Улсын Их Хурлын 2024 он 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох.

Хоёрдугаар асуудал. Хаврын тариалалт, бэлтгэл ажил, Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох.

Гуравт, Махны экспортын асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох.

Дөрөвт, Барагшуны нөөц ашиглалтын талаарх Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу?

Саналтай гишүүн байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Ажлын хэсэг оруулъя. Сайдыг дуудсан уу?

Улсын Их Хурлын 2024 он 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох.

Хэн байна? Мэдээллийг сайд танилцуулна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ажлын хэсэг танилцуулъя. Ж.Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Дондогдорж Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилт зохицуулалтын зохицуулах газрын дарга, Есөн-Эрдэнэ Газар тариалангийн бодлогын хэрэгжилт зохицуулалт газрын дарга.

Сайдын мэдээллийг сонсьё. 6 номер.

Ж.Энхбаяр: Байнгын хорооныхоо гишүүдийн амрыг эрье. Презентац тавиадхаарай. Танилцуулгыг файлаар өгсөн байгаа. Бүх гишүүдэд тарсан уу ажлын албаныхан?

Монгол Улсын Их Хурал 2024 онд малын гаралтай түүхий эдийг боловсруулах, үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээний тухай 63 дугаар тогтоолыг батлагдсан. Энэ маань Цагаан алт гэсэн ийм нэр томъёотой үндэсний хэмжээний хөдөлгөөн болж хэрэгжиж байна. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, үүн дотроо арьс шир, ноос, ноолуур, тэмээний ноос, сарлагийн хөөврийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, нөгөө талаас аж үйлдвэрлэлийнхээ салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар үйлдвэр эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх энэ зорилгоор хөтөлбөр хэрэгжиж байна. Үндсэндээ хэрэгжээд бодлогын төсөв батлагдсантай холбоотойгоор тодорхой хэмжээний эх үүсвэр нийт 58, нийт 66 тэрбум төгрөгийн хүүгийн татаасны эх үүсвэр улсын төсөвт батлагдсан.

Энэтэй холбоотой энэ хүүгийн татаасаар дамжуулан нийт салбарт 800 орчим тэрбум төгрөгийн зээл очихоор арилжааны 10 банк, Монголбанктайгаа гэрээ байгуулаад ингээд зээл олгох үйл ажиллагаа дөнгөж эхэлж байна. Танилцуулга хаана байна? Танилцуулга болтол би ярьж л байя.

Ер нь текстил буюу ноос ноолуурын ер нь нарийн ширхэгт гэж ярьдаг ширхэгт материалын зах зээл дэлхий дээр 116 сая тонн хэрэгтэй байдаг юм байна. Үүнээс амьтны гаралтай нь 1.6-хан хувийг эзэлж байгаа. Тэгэхээр 1.6 хувь нь өөрөө энэ дэлхийн их текстилийн салбарын их үнэтэй бүтээгдэхүүн болдог. Үүн дотор Монгол Улс ноолуур дээр үндсэндээ 40 гаруй хувийг Монгол Улс бэлтгэн нийлүүлж байгаа. Бараг сүүлийн тоогоор бараг 50 хувь хүрч байгаа.

Нөгөө талаар Монгол Улс дэлхийд хамгийн их хоньтой 14 дэх оронд орж байгаа. Энэ ноос, ноолуурын энэ зах зээл нэлээн дэлхийд нэлээн эрэлттэй, өсөлттэй ийм зах зээлийн хандлага, судалгаанууд явагдаж байгаа.

Зөвхөн ноолуур дээр гэхэд 2029 он хүртэл 4.3 тэрбум долларын ийм зах зээл үүсгэх ийм тооцоо гарч ирж байна. Өнөөдрийн байдлаар 23 оны жилийн эцсийн тооцоогоор бид 404 сая долларын экспорт хийж энэ зах зээлд манайх өрсөлдөж байгаа. Тэгэхээр цаана нь ямар их нөөц байгаа нь эндээс харагдаж байна.

Ноосны зах зээл 2029 он гэхэд 45.6 тэрбум долларт хүрэх ийм тооцоо гарч байна. Тэгэхээр бид жилдээ 30 мянган тонн орчим хонины ноос бэлдэж байгаа. Ноосныхоо боловсруулалтын түвшнийг сайжруулахад бас энэ бас нэлээн томоохон боломж бас бидний Монгол Улсад байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Арьс ширний зах зээл мөн байнгын өсөлттэй явж байна. 29 он гэхэд 376 тэрбум долларын арьсны зах зээл дэлхийн хэмжээнд үүсэхээр байна. Ялангуяа арьсан эдлэл дээр хамгийн том зах зээл Европ байна. Мөн сүүлийн үеийн байдлаар Зүүн өмнөд Азийн зах зээл бидний оршиж байгаа бүс нутаг нэлээн идэвхжиж байгаа. Ийм байдалтай.

24 оны мал тооллогоор 57.7 сая мал тоологдсон. Үүнээс бид нар 8.5 мянган тонн ноолуур, 34.2 мянган тонн хонины ноос, 1.9 мянган тонн тэмээний ноос, 397.6 тонн сарлагийн хөөвөр, 17.2 сая ширхэг арьс шир бэлтгэх ийм боломж манай мал аж ахуйн салбарт байна.

Б.Бейсен: Наад ажиллахгүй байна уу? Та яриад явж бай сайд аа.

Ж.Энхбаяр: Ярьж л байя даа. Тэгээд улсын хэмжээнд ноос ноолуур боловсруулах 173 үйлдвэр яг одоо үйл ажиллагаагаа явуулж байна. Ингээд угаах хүчин чадал 76.4 мянган тонн, хялгас ялгах хүчин чадал 13.1 мянган тонн, ноолуур дээр ээрэх хүчин чадал 2978 тонн, ноосон дээр 2110 тонн, нэхэх ноолуур дээр 2512 мянган метр, хивс дээр 1600 мянган м2, сүлжих дээр 5.2 сая ширхгийг үйлдвэрлэх хүчин чадал суурилагдсан.

Улсын хэмжээнд арьс боловсруулах 27 үйлдвэр байгаагаас Улаанбаатар хотод 24 үйлдвэр, Дархан-Уул аймагт 2 үйлдвэр, Өвөрхангай аймагт 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа. Ийм мэдээлэл байна.

Манай улс ноолуур боловсруулах салбарын хувьд угаах, самнах хүчин чадал түүхий эдийнхээ нөөцөд тулгуурлан 100 хувь суурилагдсан буюу бид 100 хувь угааж, самнах хүчин чадалтай ийм аж үйлдвэрлэлийн түвшин маань энэ байна.

Ээрэх, нэхэх, сүлжих хүчин чадал дөнгөж 20-30 хувьтай байгаа. Тэгэхээр хэрэгжүүлж байгаа Цагаан алт хөтөлбөрийн гол зорилго энэ ээрэх, нэхэх, сүлжих энэ хүчин чадлуудыг нэмэх, боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх зорилгоор хөтөлбөр хэрэгжиж байна.

Ноосны салбарын тухайд угаах хүчин чадал мөн адил 100 хувь суурилагдсан. Ноосон дээр самнах, ээрэх, нэхэх, сүлжих хүчин чадал 20 орчим хувь их дутагдалтай байгаа.

Арьс ширэн дээр хүчин чадал, хагас боловсруулах хүчин чадал үндсэндээ энэ 17.2 сая арьс нэхий, арьс нэхийгээ 100 хувь боловсруулах хүчин чадал суурилагдсан. Гүн боловсруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын хүчин чадал дөнгөж 20 хувьтай байгаа юм. Ийм учраас бид энэ дэлхийн зах зээлийн хандлага, манай улсынхаа түүхий эдийн нөөц, боломж, нөгөө талаар бүсчилсэн хөгжлийнхөө төвлөрөл зэрэг бодлого дээрээ тулгуурлаад Ерөнхийлөгчийн санаачилсан энэ Цагаан алт үндэсний хөдөлгөөнийг улс даяар хэрэгжүүлж байна. Энийг Монгол Улсын Их Хурал 24 онд 63 дугаар тогтоол батлан баталгаажуулсан. Тавигдаж байгаа зорилт бол ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг 20-40 хувь буюу сүлжих хүчин чадал гэсэн үг шүү дээ. Сүлжих, ээрэх эцсийн бүтээгдэхүүн хүчин чадлаа 20-40 хувь хийе. Ноосон дээр бүрэн боловсруулалтын түвшнийг 25-50 хувьд хүргэе. Арьс ширний гүн боловсруулалтын түвшнийг 30-50 хувьд хүргэнэ гэсэн ийм зорилт тавьж ажиллаж байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Цагаан алт хөдөлгөөн, салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог дэмжих, үйлдвэрлэл, борлуулалт, экспорт нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх, хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах гэсэн гол үндсэн 4 чиглэлээр 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ингээд бодлогын төлөвлөлтийн арга хэмжээ хийгдэж байгаа.

Бид өнөөдрийн байдлаар арьс шир ноос ноолуурын салбар 3.1 их наяд төгрөгийн үйлдвэрлэл, 831 сая долларын экспорт, 25.8 мянган ажлын байр нэмэгдүүлнэ гэсэн ийм тооцоо, судалгаа гарсан явж байна.

Энэ үйлдвэрлэл, борлуулалт, экспорт нэмэгдүүлэх, энэ зах зээлийг тэлэх чиглэлээр энэ жил хэрэгжиж байгаа эргэлтийн болон хөрөнгө оруулалтуудын зээлийн мэдээлэл байна.

Нийт эргэлтийн зээлд 2 жилийн хугацаатай, 10 хувийн дэмжлэгтэй аж ахуйн нэгжид үндсэн 6-8 хувийн, 7 хувийн хүү төлөх ийм бодлогын арга хэмжээнүүд явагдаж байна. Хөрөнгө оруулалт дээр 4 жилийн хугацаатай, мөн аж ахуйн нэгжүүд дээр 6-8 хувийн ачаалал үүсэхээр ийм тооцоонууд явагдаж байна.

Энэ жилд байгаа зээлийн хүүгийн дэмжлэг байгаа 66 сая төгрөгөөр бид 800 орчим тэрбум, 788 олж болж байна уу? 800 орчим тэрбум төгрөгийн зээл аж ахуйн нэгжүүдэд очихоор ингэж гэрээлэгдээд арилжааны банкин дээр сонгон шалгаруулалтууд хийгдэж байна. Энэ арга хэмжээгээ холбогдох арьс ширний ноосны, ноолуурын холбоотойгоо хамтарч бүх үйлдвэрүүдийн технологийн өнөөгийн байдал, боловсруулах түвшнийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын шаардлага, гаднаас авах тоног төхөөрөмж, чанар стандарт, технологийн түвшин гээд бүх олон үзүүлэлтээр нарийвчилсан судалгаа хийгдээд ингээд арилжааны 10 банк дээр дамжуулаад энэ зээл олгогдож байгаа. Өнөөгийн байдлаар нийт эргэлтийн хөрөнгө дээр 315, хөрөнгө оруулалт дээр 262 аж ахуйн нэгж зээлийн хүсэлт ирүүлээд арилжааны банкнуудаас судлагдаж байгаа ийм мэдээлэл байна.

Энэ эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн явц байна. Идэвхтэй явагдаж байна. Аж ахуйн нэгжүүдээс хүсэж байгаа хүсэлт бол эргэлтийн зээлийг нэмэгдүүлэх, эх үүсвэрийг шийдэж өгөх гэдэг ийм хүсэлт байна. Нийт 230 тэрбум төгрөгийн ноолуур бэлтгэл дээр аж ахуйн нэгжүүдэд гаргаж байгаа. Нийтдээ энэ жилийн ямааны тоон дээр тооцоод үзэхэд 8500 орчим тонн ноолуур энэ жил малчдаас үйлдвэрүүдэд нийлүүлэгдэнэ. Энийгээ өнөөдрийн авч байгаа 150-160 мянган төгрөгийн ханшаар бодоод үзэхэд 1.3 гаруй их наяд төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа. 230 тэрбум төгрөгийн эх үүсвэр энэ Цагаан алт бодлогын хүрээнд гарсан. Хэрвээ цаашид эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой бол энэ нь өөрөө нэг талдаа малчдын орлогыг дэмжих, нөгөө талдаа маш сайн валютын нөөцийг нэмэгдүүлэхэд томоохон бодлогын үйл ажиллагаа болж болох бололцоотой гэдэг нь гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Гэхдээ энэ бол Улсын Их Хурлаар батлагдсан төсвийн хэмжээнд бид тэр 66 тэрбум төгрөгийг зээлийн хүүгийн татаас болгосноор ийм боломж 800 тэрбум орчим төгрөг аж ахуйн нэгжүүдэд очих бололцоо бүрдэж байгаа, явагдаж байгаа.

Энэ зээлийн мэдээ байна. Аж ахуйн нэгжүүдээрээ арилжааны банкнуудаараа ингээд судлагдаж байгаа байдал явцын мэдээллүүд байна. Энэ

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

авч байгаа аж ахуйн нэгж болгон дээр яам арилжааны банк, аж ахуйн нэгжүүдийн хамтарсан хяналтын гэрээнүүд хийгдэж байгаа. Зээлийг зориулалтын бус ашиглах, өөр чиглэлд хөрөнгө оруулалт оруулахгүй байх тал дээр маш сайн хяналт тавигдаад ингээд ажил явагдаж байна. Одоо ид ноолуур бэлтгэл эхэлж байгаа тул ноолуурын үйлдвэрүүд эргэлтийн болон хөрөнгө оруулалтын ажил идэвхтэй явж байна. Ноос бэлтгэл болоогүй, бэлтгэл ажил буюу үйлдвэрүүд ялангуяа самнах чиглэл дээрээ нэлээн ачаалал өгөөд хөрөнгө оруулалтынхаа ажлууд явагдаж байна.

Арьс шир бол мөн адилхан сезоны үндсэндээ арьс ширний салбар 8 сараас хойш арьс ширний бэлтгэл явагдана. Эхний үйлдвэрүүд нь хөрөнгө оруулалт үйлдвэрээ өргөтгөх ажлууд хийгдээд явж байгаа. Үндсэндээ зээлийн хүсэлт ирүүлсэн байршлууд энэ дээр байна. Аймгаараа мэдээллүүд байна. Энд нэг гишүүдийн анхаарлыг татах ноолуурын салбарын техникийн зохицуулалт гэж нэг зүйл улсуудын анхааралд орж ирээд байх шиг байна. Бид дотооддоо 100 хувь ноолуураа угаах хүчин чадал суурилагдсан. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд самнах чадавхыг дотооддоо нэмэгдүүлэх бодлого хэрэгжсэн. Үр дүнд нь бид 13 мянган тонн буюу нийт угаасан ноолуурыг үндсэндээ 200 хувь угаах хүчин чадал суурилагдчихаад байна. Одоо техникийн зохицуулалт хэрэгжсэнээр Монгол Улс ноолуураа 100 хувь угаадаг, 100 хувь самнадаг ийм боломж бүрдсэн байна. Зөвхөн энэ технологийг нэвтрүүлснээр Монгол Улсад үлдэх санхүү 250 сая доллар буюу 700-800 тэрбум төгрөгийн нэмүү өртөг Монгол Улсын аж ахуйн нэгж, үйлдвэрүүдэд цалин, татвар, нийгмийн даатгал болон бусад хэлбэрээр үлдэж олон мянган ажлын байрыг бий болгох. Нөгөө талаас дэлхийн ноолуурын бараг 50 хувийг нийлүүлж байгаа Монгол Улс өөрөө энд ноолуураа дэлхийн гол зах зээл болсон Европ Америкийн зах зээлд гаргах, үнэд хүргэх их томоохон бололцоо бас давхар бүрдэж байгаа.

Энэ гишүүдэд танилцуулсан паркийн мэдээлэл үндсэндээ Ховдын үйлдвэрлэл, технологийн пар энэ жилийн хөрөнгө оруулалтаар ажлаа эцэслэхээр бүтээн байгуулалтын ажил явагдаж байна. Ирэх жил 2027 он гээд Цагаан алт хөтөлбөртөө хамрагдаад баруун бүс 5 аймгийн түүхий эдийг боловсруулах энэ бодлого нэлээн хэрэгжээд эхэлнэ.

Зүүн болон говийн бүсэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай үйлдвэрлэл, технологийн парк хийх ТЭЗҮ-үүд боловсруулагдаж байгаа. Ийм байдалтай.

Улаанбаатар хотод байгаа арьс ширний 24 үйлдвэр нэгдэж, Улаанбаатар хотын төвлөрөл, төлөвлөлтийн дагуу Эмээлт аж үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркттай төвлөрөн үйл ажиллагаа явуулахаар нийслэл хотоос дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийгдээд явж байгаа.

Төвийн бүсийн буюу Дархан хот дахь үйлдвэрлэл технологийн парк улсын төсвийн хөрөнгө оруулалтаар технологийн паркийн дэд бүтцийг хийх ажил ид эхэлж байна. Энэ жил улсын төсөвт батлагдсан хөрөнгө оруулалт 7.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан. Ингээд холбогдох сонгон шалгаруулалт гүйцэтгэлийн ажлууд эхэлж байна. Ингээд цагаан алттай холбоотой мэдээллийг дууслаа.

Мах махан бүтээгдэхүүний экспортын талаарх мэдээллийг

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бейсен: Тусдаа 2 дахь асуудал дээр. 3 дээр.

Ж.Энхбаяр: Тус тусдаа явах уу?

Б.Бейсен: Тийм. Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу эхний асуудлаар? Нэрсээ өгөөрэй.

Идэрбат, Чинбүрэн гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Тэгэхээр 63 дугаар тогтоолын хэрэгжилт орж ирж байгаа юм. Энэ яах аргагүй мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулалтын түвшин ахиулах, Цагаан алт хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлэх зорилготой ийм тогтоол, төлөвлөгөө батлагдсан. Хийгдэж явж байгаа ажлууд гайгүй үр дүнтэй юмнууд байгаа. Гэхдээ энэ жилийн хувьд нэлээн онцлогтой байна. Монголын нийт нутаг хардуу орчихсон. Тийм учраас энэ ноолуурын чинь үнийн асуудал дээр асуудал үүсээд байгаа юм уу гэж харагдаад байгаа. Шороо харвалттай гэдэг үүднээс гаднын импортлогч нар учиргүй мөнгөө бариад ороод ирчихгүй байгаатай холбогдоод ноолуурын борлуулалтын асуудал дээр жоохон төвөгшил үүсэж байгаа юм байна. Улсын хэмжээнд 1.3 их наяд төгрөгийн ноолуур бид татан төвлөрүүлэх ёстой үүнээс 230 тэрбумыг нь эргэлтийн хөрөнгийн зээлээр гаргаж байгаа юм байна, 3 сарын 31-ний байдлаар энэ зээлийн 32 хувийг л гаргасан байна.

Тэгэхээр үндсэндээ эргэлтийн хөрөнгийн гэдэг юм уу мөнгөжүүлэлт дутчихаад байгаа юм байна. Энэнээс болоод энэ ноолуурын чинь борлуулалт, үнэ ханшинд нөлөө үзүүлээд байгаа юм байна. Энэ тал дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам маань өнөө банкнуудтай байгуулсан гэрээнийхээ хүрээнд энэ технологийн гэдэг юм уу, цаг үеийн цаг хугацаатай энэ асуудлууд руу гол анхаарлаа төвлөрүүлж, маш яаралтай энэ үндэсний үйлдвэрүүдээ мөнгөжүүлэх, эргээд энэ ноолуурын үнэ ханшийг тогтвортой байлгах тухай асуудал байна.

Дээр нь энэ дээр давхар орж ирчхээд байгаа юм бол яах аргагүй улс үндэстэн гэж байвал энэ аж үйлдвэрийн салбараа хөгжүүлэе, боловсруулалтын түвшнээ ахиулъя, ажлын байраа нэмэгдүүлэе, орж ирэх, дотоошлох валютынхаа нөөцийг нэмэгдүүлэе гээд, самнаж байж гаргая гэдэг ийм төрийн шийдвэр гарчихсан. Тийм учраас үүнийг бас тийм оновчтой шийдвэр байгаагүй гэдгийг иргэд малчдад ташаа ойлголт өгөх гээд санаатайгаар ийм юм яваад байгаа юм биш биз дээ? Тийм учраас төр нэгэнтээ ийм у улс үндэстнийхээ эрх ашгийг хангасан том шийдвэр гаргасан бол энийгээ дагуулж хөрөнгийнхөө асуудлыг тодорхой шийдэхгүй энэ эргээд бас нэлээн тийм яриатай байх нь.

Ер нь манай малчид тогтвортой бас өссөн үнээр ноолуураа нийлүүлнэ л гэвэл дотооддоо бид энэ боловсруулалтынхаа түвшнийг ахиулаад байх тусам л малчдын ноолуур, бүтээгдэхүүний үнэ өсөх ёстой юм. Тэгээд үүнийг нь хэдүүлээ бүрэн ойлгуулж чадалгүй эхний юман дээр нь бас унагачих бий. Үүнийг анхаараач. Энэ дээр ямар бодол чиглэл байна вэ? Үүн дээр би тодорхой.../минут дуусав./

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 6 номер, сайд хариулъя.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ж.Энхбаяр: Ноолуурын үнийн хувьд үйлдвэрүүдэд худалдан авалт хийж байна. Яг өнөөдрийн мэдээгээр 600 тонн орчим ноолуур худалдан авагдсан байна. Үндсэндээ Дорнод аймагт 163 мянгаас 165 мянган төгрөгөөр, Сүхбаатар, Хэнтий аймагт 155-аас 158 мянган төгрөгийн үнэтэйгээр худалдан авалт хийгдэж байна. Нэг зүйлийг гишүүд ээ анхаараарай. Ер нь дэлхий нийтээрээ тарифын томоохон дайн явагдаж байна худалдааны. Харилцан том том томоохон тариф тавигдаж байна. Энэ үед харин манай нүүрстэй харьцуулахад ноолуур үндсэндээ маш бага 5 хувийн мэдрэг чанартай л хөдөлгөөн үйлдэгдэж байгаа.

Яагаад гэвэл ноолуурын маань өөрөө зах зээлийн төлөв байдал эвт эвтэйхэн байна. Монгол Улсын том ноолуурын тоог голлох нийлүүлэх орны хувьд бид энэ энэ цаг үеийг ашиглаж дотоодын үйлдвэрлэх чадавхаа яаралтай босгох нь Монгол Улсад том хожил авчирна. Зөвхөн самнах, угаахын хооронд 200 гаруй сая доллар, 700 тэрбум төгрөг, 800 тэрбумын өртөг, нэмүү өртөг Монгол Улсад үлдэж байгаа юм. Татвар болж, цалин болж, нийгмийн даатгал болж, цахилгаан, дулаан болж Монгол Улсад шингэж байна. Энд мэдээж өмнө угаагаад шууд Хятадын үйлдвэрүүдэд нийлүүлдэг байсан ченжийн тогтолцоо нэлээн сөрөг нөлөөлж байгаа. Тэр талаас нэлээн зохион байгуулалттай арга хэмжээ хийгдэхийг үгүйсгэхгүй.

Гэхдээ гол нь бид яг энэ дэлхийн улс орон болгон энэ тарифаа босгож дотоод үйлдвэрлэлээ хамгаалж босгож байгаа энэ цаг үед ноолуурын хувьд алтан үе шүү. Ноолуурынхаа үйлдвэрүүдийг, ноосныхоо үйлдвэрүүдийг, энэ хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн түүхий эдийг боловсруулалтыг босгож авах том ийм боломж бас давхар үүсэж байна. Үнийн хувьд боломжийн байна. Сүүлийн 20 онд 5 жилийн дунджаар аливаа түүхий эдийн үнийг хардаг. 20 он гэхэд ноолуур 50-аас 60 мянган төгрөгийн л үнэтэй байсан ноолуур шүү дээ. Өнөөдөр 150-аас 160 мянган төгрөг дээр дотоодын үйлдвэрүүд маань бас Улсын Их Хурлын баталсан бодлогын дэмжлэгийг аваад бас ингээд идэвхтэй авч байна. Нэг зүйл байгаа юм. Манай салбараас 130 тэрбум төгрөгийн төсөв хасагдсан. Батлагдсан төсөв. Уг нь яг энэ 1.3 их наядын ноолуурыг дотооддоо 100 хувь аваад, дотооддоо техникийн зохицуулалтаа 100 хувь хийчхээд Монгол Улсад орох өгөөж их өндөр байсан юм. Тэгээд бид батлагдсан эх үүсвэр маань 66.4 тэрбум шүү дээ. Энэ 66-г харин хүү, татаас болгож аж ахуйн нэгжүүдэд 800 тэрбум болгож нэмэн өсгөж зах зээлийг одоод идэвх.../минут дуусав./

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Гаалиас авсан мэдээгээр 2023 онд 279, 24 онд 154 тонн ноолуур импортолсон байх юм. Энэ яадаг учиртай юм болоо. Нэг.

Хоёрдугаарт, бид энэ ноолуур бэлтгэлийн цаг хугацаа маш давчхан. Тийм учраас энэ рүү онцгой анхаарах ёстой, зээлийг гүйцэд гаргая. Дээр нь энэ үндэсний үйлдвэрүүдтэйгээ уулзалт юмнуудаа хийж өөрсдийнхөө хөрөнгөөр авах чадамж нь ямар байгаад байгаа юм? Дээр нь энэ үйлдвэрүүдээс чинь дутахааргүй хэмжээнд ноолуур бөөгнүүлээд, угаагаад, самнаад гаргадаг бүхэл бүтэн хуучин бидний ярьж хэлснээр ченж гэж яриад байдаг бараг одоо нөхөрлөлийн гэдэг юм уу, хоршооны журам руу шилжчихсэн хэсэг улсууд байна. Энэ улсуудтайгаа уулзаж энэ ноолуурынхаа борлуулалтын асуудлыг анхаарахгүй бол энэ жилийн ноолуур дээр нэлээн асуудал үүсээд.../минут дуусав./

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бейсен: 6 номер, сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Батжаргал гишүүн их чухал асуудал хөндлөө. Тэр импортолж байгаа ноолуурын статистик чинь бидний нөгөө гүйцээн боловсруулах чадавх сул байгаа болохоор үйлдвэрүүд маань бэлэн утас очоод гадагшаа явуулаад будаг будуулаад нарийн боловсруулалт хийсэн утас авчрах бусад эцсийн бүтээгдэхүүнийг хийх хольцоо оруулж ирээд байгаа нь тэр.

Нөгөө талаас энэ дундын энэ гол ноолуур авч байсан улсуудад яг энэ бололцоо, ашгаа хэлэхэд Монгол улсад угаах, самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 200-аас 300 хувь бүрэн суурилсан. Одоо Монголдоо үйлдвэрлэ ээ. Алийн болгон бусдын түүхий эдийг бэлдэх вэ, энэ байгаа дэлхийд өрсөлдөх чадавхтай энэ 10-хан мянган тонн ноолуураа бид нар 100 хувь угаагаад 100 хувь самначихъя. Тэгээд цагаан буюу тэр самнасан ноолуур гэдэг бол Европ, Америкийн хамгийн үнэтэй зах зээлд Монгол Улс энэ том салбарт том байр суурьтай том тоглогч болж байгаа.

Ж.Энхбаяр: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Гаалийн мэдээгээрээ угаасан ноолуур орж ирээд байгаа юм шүү. Тэрнээс бүтээгдэхүүн, үндсэн түүхий эд орж ирэхгүй байгаад байгаа юм. Би гайхаж байгаа ний нуугүй үнэнийг хэлэхэд. Монголын ноолуур бол хамгийн дээд зэргийн ноолуур. Тийм учраас энэ ноолууртай бас тодорхой хэмжээнд хутгах ноолуур оруулж ирээд байгаа юм биш биз дээ та минь. Үүнийгээ нэлээн нягтлахгүй бол болохгүй байна. Ер нь манай ноолуурыг угаалгаад авах сонирхол дэлхийд байгаад байгаа нь өөрийнхөө чанар муутай ноолуурт чанар сайжруулагчаар л ашиглах гээд л оролдоод байгаа ийм л үйл явц шүү дээ. Ний нуугүй яг үнэнийг хэлэхэд. Бид хэд самнах хүчин чадал сайн хийсэн гэж яриад байгаа боловч яг үндэсний шинж чанартай самнах чадал л нь 2000 гаран тоо тонн байгаад байгаа юм шиг байгаа юм. Бусад нь урд айлын хүчин чадал энд бий болчихсон, мөнгө нь түүнийгээ дагаад бий болчихсон. Тэгээд энэ нөхдүүд чинь үнэ дээр тоглох тоглолт хийх гээд ингээд болж өгөхгүй байна. Тийм учраас би Хөдөө аж ахуйн яамыгаа, тэр Тогтвортой ноос ноолуурын холбоо энэ үндэсний үйлдвэр энэ тэртэйгээ нэлээн сайн.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер хариулъя. Сайд.

Ж.Энхбаяр: Тэр бас импортод орж ирсэн ноолуур дээр Казахстан улсаас орж ирсэн ноолуурын тодорхой хэмжээ байгаа юм байна. Манай зарим иргэд Казакаас ноолуур оруулж ирээд Монголд угааж боловсруулаад Хятад руу экспортолсон ийм статистикууд явагдаж байгаа юм байна.

Үнэхээр дотоодын үйлдвэрлэлээ унагаачих юм бол яг л арьс, ноос жалганд хаягддаг үйл явдал. Энэ ноолуур дээр бид нар үйлдвэрлэлийнхээ чадавхаа нэмээд байсан болохоор ингээд үнэ цэнд ороод байна. Ер нь үйлдвэрлэх боловсруулах түвшнээ л нэмээд байх тусам л цааш цаашдаа малчдын орлого маань улам л үнэ цэнтэй болно. Ноолуур маань улам л үнэ цэнтэй болно.

Яагаад гэвэл ноолуур өөрөө дэлхийн энэ текстилийн салбарын дөнгөж 1.3-хан хувь нь мал аж ахуйн гаралтай. Үүн дотор ноолуур маш том байр суурь эзэлдэг. Энэ үнэтэй хэрэглэл дотор Монгол өөрөө ноолуур нийлүүлж байгаа

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

цөөхөн орны нэг. Энэ ерөөсөө л алт. Гулуузалсан алт л гэсэн үг. Угаагаад, самнаад тавьчихвал гулуузалсан алт.../минут дуусав./

Б.Бейсен: Сайд гүйцээж хариулъя. 6 номер байна.

Ж.Энхбаяр: Тэгэхээр энэ бэлэн валют юм шүү. Үнэхээр цагаан алт. Тэгэхээр бүгдээрээ энэ ноолуураа эцсийн бүтээгдэхүүн рүү л яаж ийгээд боловсруулсан түвшнийг ахиулъя. Их Хурлын тогтоол 63 дугаар тогтоолын гол үүрэг, даалгавар бол тэр. Одоо 100 хувь угааж байгаа бол одоо 100 хувь самна. Дараа нь 100 хувь ээрч утсаа хийцгээе Монгол Улс. Тэгээд утсаа хийх юм бол бид нар тэр 4.7 тэрбум долларын ноолуурын зах зээлийн 50 хувийг барилаа л гэсэн үг. Зөвхөн ноолуур 2 тэрбум долларын экспорт хийх бололцоотой. Одоо бид нар дөнгөж 404 сая доллар дээр гацчихаад байна шүү дээ.

Тэгэхээр угаагаад одоо самнахаар бид нар энэ жил гэхэд хамгийн багадаа 600 сая доллар, 800 сая доллар руу үсэрнэ. Утас хийдэг хүчин чадлаа үүгээрээ нэмээд гаргахад бид нар 2 тэрбум доллар руу үсэрнэ. Үүний цаана чинь нөгөө малчдын амьдрал маань, мал маллах ахуй сонирхол маань улам л идэвхтэй, сонирхолтой, үр өгөөжтэй болох бололцоо байгаа юм. Үүнийгээ хийж чадаагүйгээс болоод арьс шир яаж унав, ноос яаж унав, тийм биз? Эцсийн эцэст жоохон үнэтэй аваад үүлдрийг нь унагаачхаад тэгээд сүүлдээ үнэ цэнгүй болгочихдог ийм л бодлого бид нар сургамж шүү дээ. Өнгөрсөн 30 жилийн сургамж.

Тэгэхээр ноолуур бол ахиад хэлье алт, бэлэн алт, валют. Тэгэхээр үүнийгээ бид нар үнэхээр чулуу болгох ийм цаг байгаа юм. Өнөөгийн яах вэ өнөөдрийн 5, 10 мянган төгрөгийн үнийн уналт, наалт энэ дээр улсууд янз янзаар тоглож, улс төржих, мэдээж гар, хөл болж дайрах довтлох юм гарч л.

Гэхдээ бид бодлогын хувьд энэ үйлдвэржилтийнхээ бодлогыг аваад гаръя. Дэлхийгээрээ тарифаараа дотоод үйлдвэрлэлээ хамгаалж байна. Үйлдвэрлэлээ дотоодынхоо чадавхыг бэхжүүлэхийн төлөө улс орон болгон анхаарал тавьж байгаа гэдгээ та, бид юу эс андах вэ. Тэгэхээр энэ дээрээ тогтвортой 1 жил энэ бодлогоо явуулъя. Мэдээж Байнгын хорооноос надаа дэмжлэг үзүүлээд энэ Монголбанканд энэ валютын нөөц бүрдүүлэх бодлогын хүрээнд энэ ноолуурыг анхаараач гэж. Ноолуур бол жилдээ бэлтгэгдээд жилдээ 100 хувь экспортод гарч байгаа, 100 хувь валют болж байгаа ийм зүйл. Заавал нүүрс, алт, тэр валют болоод байгаа нь зүйл биш шүү дээ. Тэгэхээр ийм том бас бололцоо мал аж ахуйн гарлын түүхий эд дээр байна шүү л гэж.

Б.Бейсен: Уянгаа гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Өдрийн мэнд хүргэе. Цагаан алт үндэсний хөдөлгөөний хүрээнд олгож байгаа зээлэн дээр л төвлөрөөд таны танилцуулгыг сонсож байлаа. Тэгэхээр аж ахуйн нэгжийн төлөх хүү нь болохоороо эргэлтийн хөрөнгө дээр 7, хөрөнгө оруулалт дээр 8-аас 9, ногоон зээл дээр зургаа гээд. Засгийн газраас хариуцсан төлөх хүү нь 10 хувь байхаар ийм байдалтайгаар төлөлт явагдах юм байна. Одоогоор эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар санал ирүүлсэн 315 аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалтын зээлд хамрагдахаар нийт 262 аж ахуйн нэгж гээд танилцуулгаас ойлгож авлаа л даа.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Асуух гээд байгаа зүйл маань болохоороо энэ зээл өгөх аж ахуйн нэгжүүдийг энэ банкууд хэрхэн сонгож байгаа юм болоо? Өмнө нь огт зээл авч байгаагүй шинэ компаниудаа зээлээр хэрхэн дэмжиж байгаа вэ? Энэ дээр танай яамнаас анхаарал хандуулж байна уу, эсвэл аж ахуйн нэгжүүд банктай хоорондоо харилцаад энэ асуудалд нь зээл авах эрх нь нээгдээд ингээд явна гэж орхиж байна уу? Нэлээн их тийм нөгөө зээл авахын тулд зөндөө их шаардлагыг хангуулж байна гэдэг шүүмжлэл ирээд байдаг. Энэ дээр сайдын байр суурийг сонсьё.

Хоёрдугаарх нь болохоороо танай танилцуулга дээр энэ Цагаан алт үндэсний хөдөлгөөний хүрээнд олгогдож байгаа зээл болохоор Улаанбаатар хотод, Дархан-Уул, Орхон аймгуудад зээл олгогдоод байна гээд танилцуулга дээр биччихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр бусад аймгууд яах билээ? Тэгээд бас тайлбар нь цаашаагаа үргэлжлээд явахдаа нөгөө хүн амын нягтаршил, дэд бүтэцтэй холбоотой ингээд зээл өгөгдөж байна гэсэн байдлаар танилцуулж байна л даа. Ер нь эдгээр 3 газраас Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймгуудаас өөр газар үйлдвэр хөгжих ийм боломж байна уу? Байхгүй гэж үзэж байна уу? Ер нь яамнаас танай яамнаас ямар арга хэмжээг нийт улсыг хамрах хүрээнд нь авч хэрэгжүүлж байна вэ?

Б.Бейсен: Хэдэн номер хариулах уу? 6 номерт сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Цагаан алт-ын маань зорилго арьс шир, ноос, ноолуурын боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх. Боловсруулах үйлдвэрүүд маань яг саяын дурдсан аймгуудад л байгаа юм. Жишээлбэл арьс ширний үйлдвэрүүд улсын хэмжээнд 27 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна, 24 нь Улаанбаатар хотод, 2 нь Дархан-Уул аймагт, 1 аж ахуйн нэгж Өвөрхангайд. Ноолуур үндсэндээ 99 Улаанбаатарт. Ноос мөн адил.

Тэгэхээрээ ингээд гол байрлалаа дагаад нөгөө үйлдвэрлэлийн дэд бүтэц, үйлдвэрлэлийн уур, үйлдвэрлэлийн бохир гэдэг тэр техникийн нөхцөл хангачихсан гол бүс нутаг маань өөрөө энэ төвлөрсөн энэ газар л бий болоод, болчихсон. Энэ дээр гол ажил явж байгаа.

Зээл олголт дээр холбоонууд, ноосны холбоо, ноолуур, арьс ширний холбоодтой яамны ажлын хэсэг бүрэн технологи дүгнэлт хийгээд байгаа аль нөөцийг аль үйлдвэр дээр ямар технологи нэвтрүүлэх вэ, алийг нь сайжруулах вэ гэдэг дээр л маш сайн ажилласан. Тэгэхээр зориулалтын бус ашиглах бололцоо хязгаарлагдмал.

Хоёрдугаарт дотоод сонгон шалгаруулалтуудаа холбоонууд хийж байгаа. Ноолуурын холбоо, ноос, ноолуурын холбоо, арьсны холбоо. Өөрсдөө мэдэж байгаа шүү дээ. Хоорондоо өрсөлдөж, шаардлагагүй хүчин чадлыг нэмж суурилуулахгүй гэсэн бодлоготой. Жишээлбэл, ноолуур дээр угаах, самнах дээр 1 төгрөг ч өгөхгүй ноосон дээр. Энэ бол хангалттай суурилчихсан. Зөвхөн ээрэх, сүлжих, утсаа будах, эцсийн бүтээгдэхүүн хийх буюу ахисан түвшиндээ гол хөрөнгийг зориулж байгаа гэсэн маягаар бодлого тэгээд гарсан. Нэгэнт хүчин чадал суурилчихсан 200-аас 300 хувийн хүчин чадал суурилчихсан байхад шаардлагагүй талд хөрөнгө оруулалтууд хийхгүй. Нөгөө талаас одоо байгаа үйлдвэрүүдийнхээ боловсруулалтын чадавхыг сайжруулах ийм бодлого явж байгаа.

Б.Бейсен: Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Таны сая одоогоор зээл авах хүсэлтээ ирүүлсэн байгаа гээд аймгууд дээр гаргасан мэдээлэл дээр жишээ нь Өмнөговь дээр 15 аж ахуйн нэгж зээл хүссэн байсан. Дорноговь дээр 1, Дундговь дээр бас 1 байсан. Тэгэхээр чинь тэнчээ үйлдвэрүүд байхгүй юм байна шүү дээ. Тэгэхээр тэрний зээлийнх нь хүсэлтэд нар нь ер нь яаж шийдэгдэх бол?

Б.Бейсен: 6 номер, сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Зээл улс орны хэмжээнд хэрэгжиж байгаа. Үнэхээр аймгуудын түвшинд юмаа хангасан, цэвэрлэгээ хийсэн бас маш цөөн тооны аж ахуйн нэгжүүд энд орж чадаж байна. Ихэнх нь шинээр байгуулна, шинээр угаана, шинээр боловсруулна гэсэн асуудлууд. Яагаад гэвэл энэ арьс шир, мал аж ахуйн гаралтай хүүхдийн боловсруулалт маш их химийн бүтээгдэхүүнтэй, нөгөө л байгаль орчны цэвэрлэх байгууламжийн асуудал хөндөгддөг тул хязгаарлагдаж байгаа. Харин Ховдод хийж байгаа үйлдвэрлэл, технологийн парк яг энэ боловсруулах чиглэлээр бэлтгэгдэж цэвэрлэх нь байгуулагдаж байгаа болохоор баруун 5 аймгийн боловсруулах том ажил, түүхий эдийн боловсруулах ажил үндсэндээ Ховд руу ирэх жилээс нэлээн төвлөрч хүчин чадал нэлээн өргөтгөх байх.

Ж.Энхбаяр: Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Цаг үеийн нэлээн чухал асуудал бас яригдаж байна. Гишүүдийн бас асууж байгаа асуултуудтай санал нэг бас байна гэж. Тодруулаад хэд хэдэн зүйлийг бас асууя. Цагаан алт хөтөлбөрийн энэ концепц үйл ажиллагааг бас бүрэн дэмжиж байгаа. Мөн дээрээс нь энэ ноолуурын самнах дамжлага руу шилжих энэ шилжилтийн үеийг бас бас дэмжиж байгаа. Энэ утгаараа бид бүхэн бас тактикийн хувьд, бодлогын хувьд бас нэлээн өмнөх үеүдээс арай өөр тактикуудыг хийж хэрэгжүүлэх ёстой гэж ингэж хараад байгаа.

Гэтэл одоо яг явж байгаа үндсэндээ бодлого, үйл ажиллагаа маань өмнөх жилүүдтэйгээ яг адилхан байдалтай бас байгаад байгаа нь энэ ноолуурын тодорхой үнэ, ханш руу буухдаа тодорхой хэмжээний үндсэндээ үнэ буух байдалтай бас ажиглагдаад байна уу даа гэсэн ийм үндсэндээ таамаглал байна. Түүхий эдийн хувьд ноолуурын энэ салбар энэ өөрөө, зах зээл бол монголчууд бидний хувьд хамгийн том давуу талтай салбар. Мал аж ахуйн орон, түүхий эдийн энэ экспортлогч орон болохын тулд номер нэгд бид нар энэ ноолуурын давуу талаа бид бүхэн ашиглах ийм боломжууд бид бүхэнд байгаа гэж хараад байгаа. Тэгэхдээ нэг л бүрэн дүүрэн чадахгүй ийм нөхцөл байдалтай байгаад байна. Дэлхий дээрх ноолууран 2 цамц тутмын 1-ийг нь бид түүхий эдээрээ хангаж үйлдвэрлэж байгаа хэр нь өнөөдөр бид бусдаас хараат байгаа байдлаа засах гээд байгаа энэ байдлыг бүрэн дэмжээд байгаа юм. Тэгээд энэ асуудалд битгий уначхаасай. 2, 3 удаа энэ техникийн зохицуулалт үндсэндээ бид бүхэн ухарсан. Энэ удаад бас ухрахгүй байгаасай гэдэг ийм байр суурьтай байгаа.

Гэхдээ үндсэндээ бид бүхэн энэ угаасан ноолуураар бид нар жилдээ 300 сая долларын ийм орлогыг олдог байсан бол самнахаараа бид нар 600 сая болоод 2 дахин өсөх юм байна. Гэхдээ энэ өртөг, энэ нэмүү өртөг нь яагаад яг анхан шатны энэ малчид дээрээ очихдоо ийм бууралттай байдлаар ингээд яваад байгаа юм бэ? Энэний яг ялгааг л малчид бүрэн дүүрэн бас ойлгохгүй байгаад

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байна. Тодорхой хэмжээнд энэ өсөлт бий болж байгаа бол ялгаагүй аль аль шатдаа үндсэндээ энэ үр дүн нь ингээд харагдаад явдаг ийм байдлаар л үндсэндээ байж байж энэ салбарын байдал цаашдаа тогтвортой явах юм.

Тийм учраас энэ талаас нь арай өөр энэ техникийн зохицуулалт мөрдөгдөж байгаатай холбогдолтой ийм зохицуулалтуудыг бид бүхэн яаж хийж байгаа вэ? Өнгөрсөн жил бид нар 200 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн татаасыг аж ахуйн нэгжүүддээ олгосон. Энэ жил бид нар 30 тэрбумаар л тэрийгээ ахиулсан байна. Энэ нь нийт үндсэндээ 8500 тонн энэ ноолуурын 18 хувийг л авах хэмжээний эргэлтийн хөрөнгө байгаад байна. Энэ техникийн зохицуулалт мөрдөгдөж эхэлснээрээ дотоодын аж ахуйн нэгжүүд бид нар өөрсдөө бие даах ийм л сонголт руу орж байгаа.

Гэтэл бид нар 18 хувийг авах хэмжээний эргэлтийн хөрөнгөөр үлдсэн энэ үндсэндээ хэсгийг хаанаас, ямар мөнгөөр үндсэндээ авах вэ гэдэг энэ байдлаас болоод үнийн асуудал бас яригдаад байна. Энэ дээр яг нарийн.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер, сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Үнэн эх үүсвэр хязгаартай. Уул нь яг 1.3 их наядынхаа ноолуурыг авчихъя гээд бид нар төсвөө батлуулсан. Харамсалтай нь Их Хурал төсөв задалсан. Буцаагаад 130 тэрбум хасчихсан. Тэр хасагдсан 130 тэрбум чинь энэ 1.3 их наяд буюу ноолуураа 100 хувь аваад, 100 хувь угаах, самнах бодлого байсан юм л даа. Харин харьцангуй гайгүй. Энэ өнөөдрийн 150-аас 160 мянган төгрөгийн үнэ маш боломжийн шүү. Зөвхөн тариф дээр гэхэд Америк, Хятадын 36 хувийн тарифын татварын хязгаарлалт тавьж эхэлж байна шүү дээ. Тариф.

Гэтэл бид нар түүхий эдийнхээ энэ чинь 80 хувь нь тэр урд зүгийн үйлдвэрт зориулчихсан байсан үйлдвэр маш хүчтэй уналт авах байсан. 36 хувиар унах байсан. Харин энэ дээр бид нар Цагаан алт бодлого оруулснаараа бид үйлдвэрүүдээ бэхжүүлэх, энэ самнах техникийн зохицуулалтыг хийснээрээ бид нар 5 хувийн уналтыг хийгээд дотоодын үйлдвэрүүдээ босгоод авч байгаа. Салбарын хувьд Алтан үе. Ноолуурын үйлдвэрлэлийнхээ түвшнийг сайжруулах алтан үе, боломж байна. Энийг тэгж ойлгооч. Ахиад хэлье наддаа ирсэн хүч хэрэгсэл ердөө тэр 60 тэрбум төгрөгийг л хөдөлгөж байгаа. Уул нь тэр жоохон эх үүсвэр нэмээд одоо Монголбанкнаас жоохон мөнгө нэмж өгөөд энэ эргэлтийг нь жоохон хүчтэй дэмжээд өгөхөд малчдаар очиж байгаа үнийн уналт байхгүйгээр явчих бололцоо байна. Одоо 5 хувийн уналттай ноднинтой харьцуулахад шүү дээ. 20 онтой харьцуулах юм бол 50, 60 мянга байсан ч харьцуулахад 3 дахин өсчхөөд байна. 150, 60 мянган төгрөг болчихоод байна. Муу биш байна. Зах зээл нь боломжийн байна, үйлдвэрлэлүүд нь овоо хөрөнгө оруулалт хийгээд овоо хөдлөөд эхэллээ. Ганц юун дээр алдсан гэвэл ноолуур авах эргэлт дээрээ бид нар эх үүсвэрийг нь Их Хурал хасчихсан. Тэн дээр л бид нар алдчихаж байгаа юм. Гэхдээ энийг нөхөх бас бололцоо байгаа шүү дээ .../минут дуусав./

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

Ж.Энхбаяр: Тийм яг зөв. энэ асуудал дээрээ яг ингээд пойнтлоод өнөөдөр Байнгын хорооноос тодорхой бас чиглэл, саналууд нь гараад яваасай гэж бодож байгаа. Цаг хугацаатайгаа уралдаж байгаа. Үндсэндээ зүүн аймгуудын хувьд

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үндсэндээ энэ ноолуураа бүрэн дүүрэн өгөөд дуусчихсан байдаг энэ цаг хугацаанд 50 хувьдаа хүрсэн, хүрээгүй гэдэг ийм байдалтай үндсэндээ байгаа.

Бид нар үнийн хувьд ахих ёстой, ахих ёстой. 5 жилийн дундаж байдаг юм уу, тодорхой асуудлыг инфляц болон яг энэ амьжиргаатай нь харьцуулаад ингээд харахаараа бас энэ чинь болохгүй асуудлууд бас ингээд байна малчдын хувьд. Тийм учраас энэ Шинэ хоршоо хөдөлгөөн, Цагаан алт хөдөлгөөн, Хүнсний хувьсгал гээд энэ хөдөө аж ахуйн салбар руу маш их эргэлтийн хөрөнгийн энэ боломжуудыг өмнөх өмнөх жилүүдээс олгоод байхад үндсэндээ энэ салбарын энэ тодорхой энэ байдлууд үндсэндээ яг эцсийн энэ бүлэг дээрээ түүхий эд бэлтгэж байгаа анхан шат дээрээ ахиад л явах ёстой. Бид нар энэтэй эвлэрч ер нь боломжийн байна гэдэг энэ байдлаар хандаж болохгүй ээ. Шаардлагатай бүх арга хэмжээг авах хэрэгтэй. Эргэлтийн хөрөнгийн энэ.../минут дуусав./

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн үг хэллээ. Чинбүрэн гишүүн асуулт асууя.

Ж.Чинбүрэн: Би бас өмнөх үг хэлсэн гишүүдтэйгээ, асуулт асуусан гишүүдтэйгээ бас санал нэг байгаа. Энхбаяр сайд бас зөв юм хэлж байна. Ер нь энэ геополитикийн, үнэ тарифын энэ зөрчилдөөнд Монгол Улсад бас илүү давуу боломж гарч байна гэж хараад байна. Тэгэхлээр энэ алтан боломжийг ашиглах тал дээр бид Их Хурал, яам, мэргэжлийн яам, Засгийн газар энэнтэйгээ уялдуулаад маш шуурхай арга хэмжээ авах нь бид их чухал байна. Ер нь тийм динамик байхгүй бол тэгээд л 26 оны төсөв, дараагийн төсөв ингэсээр байтал цаг хугацаа алддаг, боломжуудаа бид алдах ийм нөхцөл байдал үүсгэхгүй, үүсгэх вий гэдгээс болгоомжилж байна.

Дээрээс нь зөвхөн БНХАУ-д гэхэд л 34 хувийн татвар, дээрээс нь ахиад 54, дээрээс нь бүүр 100 хувь хүртэл нэмнэ энэ тэр гэсэн энэ Трампын мэдэгдлүүдийг бид харж байна. Энэ болгон бидэнд бас нөгөө талаасаа их том давуу тал үүсэж байгаа гэдгийн бас нотолгоо шүү дээ. Тийм учраас бид давуу тал болгож ашиглах чиглэлд үнэхээр бас бүх боломжуудаа дайчлан ажиллах, энэ боломж олгосон энэ Цагаан алт хөтөлбөрөө улам цааш нь эргэлтийн санг нь нэмэгдүүлэх талд өнөөдөр бид бас Байнгын хороогоороо ярилцаад цаашид юу хийх ёстой вэ гэдгээ шийдвэр гаргаад, Энхбаяр сайд бас өөрөө саналаа бас энэ дээр тодорхой хэлээд Байнгын хорооны гишүүд бид ойлгож байна. Өнөөдөр бид байгалиас өөрөөс нь бий болж байгаа дундаршгүй энэ сайхан баялгаа зөв ашиглах, үүнийг бүтээл, үнэ цэнд хүргэх энэ боломж бас үнэхээр том боломж гэж би яг геополитик сонирхдог хүний хувьд тэгж харж байна.

Тэгэхлээр энэ татварын дайн Монгол Улсад илүү боломж гарч байна гарч байна. Үүнтэй холбоотой дараа дараагийн алхмууддаа ч гэсэн бас Энхбаяр сайд бас бодож байгаа байх гэж бодож байна. Ер нь бид үйлдвэрлэгч байх, бүтээдэг байх, зүгээр л түүхий эдээ гадагшаа цацаад байдаг биш байх энэ том бодлогын хөгжил нь бас үйлдвэрийн тэлэлтийн асуудлууд. Арилжааны банкнуудыг өөрсдийг нь бас идэвхтэй оролцох боломжийг бас энд гаргаж өгөөсэй. Энэ дээр бодлогын бас том дэмжлэгүүдийг арилжааны банкнуудад бас Монголбанкаар дамжуулаад хийх энэ нөхцөл боломжууд юу байдаг юм? Энэ талаас нь бас та бас хараасай. Энэ дээр бас арилжааны банкнууддаа бас уриалж оролцуулах, нэмэгдүүлэх, Монголдоо авдаг, гаднаас хөрөнгө оруулж, манай ноолуурыг цуглуулдаг биш, монголчууд бид өөрснөө цуглуулж чаддаг, түүнийгээ боловсруулж, угааж бүтээгдэхүүн болгож чаддаг ийм байгаасай гэж бодож байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Жишээлбэл, дэлхий даяар кашмерин пальто Монгол Улсад ямар аятайхан хямдхан байна. Миний таньдаг гадаад найз нар ирэхлээрээ Монголд кашмерин пальто авах гэж ирлээ гэж ярьдаг шүү дээ. Тэгэхлээр энэ болгон бидэнд том боломжоо гэж харж байна. Дэмжиж байна.

Б.Бейсен: Үг хэллээ. Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Цагаан алт-тай холбоотой асуудлууд маань яригдаж байна. Нэгдүгээрт ноолуур, арьс шир тэгээд ноос гэсээд л энэ 3 хүрээнд явагдаж байгаа шүү дээ.

Тэгэхээр хамгийн түрүүнд яг дэлхийн зах зээл рүүгээ гарсан байгаа, эргэлтэд орсон байгаагийн хувьд ноолуураа бид нар нэн тэргүүнд урдаа бас нүүр царай болгоод тавих нь зүйтэй. Энхбаяр сайдын хувьд бол бодлого бол нэг байна. Ярьж байгаа зүйлүүд чинь болж байна. Яг бодлогын хүрээнд бол жишээ нь энэ ноолуурыг бол гаргах, дээрээс нь дэлхийн ноолуурын нийт зах зээлийн 50 хувийг, дэлхийн нийт ноолуурын бараг 50 орчим хувийг бид нар чинь гаргаж байгаа шүү дээ. Яг энэ утгаараа бол том амбицтай орох хэрэгтэй байна. Өөрийн чинь ярьж байгаа шиг. Дэлхий нийт энэ бүтээгдэхүүний, ноолууран бүтээгдэхүүн Дэлхийн банкны тооцоо байдаг 20 тэрбум долларын эргэлт байдаг гэсэн ийм тооцоо байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар тэр 20 нь байг, ямар ч л байсан 50 хувийн эргэлт, 50 хувийн оролцоог бид нар хангах нэлээн том амбицтай бол хөдлөх нь зүйтэй байх. Яг өөрийн чинь ярьж байгааг бол үнэндээ дэмжиж байна.

Тэгээд үүнийг хийхийн тулд хэд хэдэн асуудлуудыг шийдэх хэрэгтэй байна. Одоо бол ямар ч л байсан урьд өмнө бас нэг зүйлийг хэлэх нь зүйтэй байх. Урьд өмнийн сайд нарын амнаас гарч байгаагүй зүйл өнөөдөр таны амнаас гарч байна. Яг энэ салбарыг үнэн, бодитоор нь бас харж байна гэж үнэлж байгаа шүү. Тэгэхээр одоо бодитой л юм хиймээр байна.

Энэ техникийн зохицуулалтыг энэ чинь 22 онд шүү дээ. Энэ Батжаргал гишүүн бид хэд Үйлдвэржилтийн байнгын хороон дээр л анх санал гаргаж байгаад л энийг батлуулаад л, 22 онд хийчихье гэсэн зөвшөөрөхгүй 23 руу хойшоо татсан, 23-аас эхэлнэ гэж байтал хойш нь 2 татаад хойшлуулаад л 25 оноо дөнгөж сая 2 сарын 1-нээс эхэлж энэ чинь хэрэгжиж байна шүү дээ.

Өөрөөр хэлбэл, монгол ноолуураа урьд өмнө нь 80 хувийг нь угаагаад зүгээр май гээд л урд хөрш рүүгээ гаргаад тэгээд энэ дэлхийн тоглолт цаашаа бол борлуулаад дэлхийд борлогдоод явчихдаг байсан бол одоо бид нар үндсэндээ бол наанадаж самнаж гаргадаг больё, түүхийгээр нь буюу зүгээр угаагаад урагшаа гаргадгаа больё гэсэн энэ техникийн зохицуулалтыг оруулж ирсэн. Одоо энэ 25 оны 2 сарын 1-нээс эхлээд хэрэгжээд дөнгөж эхэлж байна.

Нэгдүгээрт, 1.3 их наяд буюу 100 хувь энэ ноолуураа дотооддоо авдаг энэ бололцоог нээмээр байна. Энэ дээр бүүр Засгийн газар нь том бодлого гаргаж ирмээр байна.

Хоёрдугаарт, ээрэх хүчин чадлаа 100 хувь руугаа бас шахмаар байна. Энэ дээр бас дахиад мөнгөний асуудлууд, хөрөнгийн асуудлууд гарч ирэх байх. Энэ дээр бүүр том бодлого авах хэрэгтэй байна шүү дээ. Бүүр үндсэндээ томоор нь

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бодлогоор оруулах л хэрэгтэй байна. Тэгж байж бид нар л гарах ёстой дэлхийн зах зээл рүү гарна.

Тэгээд дэлхийн зах зээл рүү гарах одоо бол үндсэндээ Монголын өнөөдрийн 20-оод хувийг л бид нар 20 хүрэхтэй үгүйтэйг л самнаж байгаа шүү дээ. Энэ самнаж байгаа ноолуур чинь тэр чигээрээ Европ руу гарч байгаа. Хэрвээ бид нар ингээд 2 сарын 1-нээсээ авхуулаад ингээд самнаад явах юм бол бид нарын урагшаа гардаг зах зээл чинь .../минут дуусав./

М.Ганхүлэг: Нэмэлт 1 минут авъя.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгэхээр бид нар хэрвээ ноолуураа самнаад гаргах юм бол самначихсан ноолуурын чинь зах зээл чинь автоматаар Европ руу шилжиж байгаа шүү дээ. Тэр чигээрээ Европын зах зээл рүү орж ирж байгаа байхгүй юу даа. Урд зах зээлээс ерөөсөө хараат бус болчихож байгаа юм бид нар. Тэгэхээр дэлхийд энэ тоглолтынхоо баталгааг хангаад дэлхийн 1 тоглогч нь болоод, самнаад гаргадаг энэ зүйл рүүгээ л ормоор байна. Ийм байдал руугаа л ормоор байна.

Жишээ нь, бид өөрсдөө дотооддоо бүх энэ 50 хувийнхаа дэлхийн нийт ноолуурын 50 орчим хувийг боловсруулдаг болчих юм бол гадагшаа бид нар юунд санал болгох вэ гэхээр үндсэндээ бол ээрсэн утсаа нийлүүлье л дээ, бэлэн бүтээгдэхүүн нийлүүлье. Хэрвээ өөрсдөө тэр ноолуураа худалдаж аваад гаднынхан өөрсдөө бүтээгдэхүүн хийнэ гэж байгаа бол тэгвэл манай самнасан ноолуур тэд, 100 зуугаа хэд байдаг юм, хамгийн багаар бол 105-аар бол гэрээ хийгдээд л явж байсан шүү дээ самнасан ноолуур. Хамгийн багаар. Тэгэхээр энэ бүтээгдэхүүнээ үнэд оруулах асуудал нэн тэргүүнд орох.

М.Ганхүлэг: Энхбаяр сайд хариулъя. 6 номер.

Ж.Энхбаяр: Үнэхээр санал нэг байна. Байнгын хорооноосоо Засгийн газарт тогтоол гаргаад, чиглэл гаргаад эх үүсвэрээ ноолууран худалдан авалт дээр гээд аж ахуйн нэгжүүд эргэлтийн хөрөнгөөр дэмжих арга хэмжээ ав гэдэг ийм дэмжлэг үзүүлээч. Ер нь Монголбанк, арилжааны банкнууд дээр 11 гаруй их наяд төгрөгийн эх үүсвэр ашиглалтад орохгүй байгаа. Энэ чинь төгрөгөөрөө ард түмэндээ ноолуур, ард түмнээс ноолуур аваад энэ чинь буцаагаад валют болно. Нөгөө их олон зүйлдээ эерэг нөлөөлөл үзүүлэх боломж байгаа юм. Үнэхээр бид нар ноолуураа 100 хувь самнаад ямар их өгөөж өгөх вэ. Тэгээд 100 хувь утас хийдэг бол утас хийсний дараа бид нар үнэхээр дэлхийн ноолуурын гол тоглогч Монгол Улс. Манай утсаар дэлхийн брэндүүд утсаа аваад түүхий эд, эцсийн бүтээгдэхүүнээ сүлждэг, төрөл төрлөөр нь хөгжүүлдэг л болно шүү дээ.

Тэгэхээр энэ зорилгын төлөө ухасхийдэг бас гадаад орчин их бүрдчихлээ. Өмнө их амаргүй байсан шүү бас боломжгүй. 36 хувийн тариф тавиулсан, ахиад 50 хувь тавиулж байгаа энэ үед хэрвээ бид энэ бодлого Цагаан алт бодлого хэрэгжээгүй байсан бол юу болох байсан гэж та нар бодож байна? Манай энд ноолуур чинь үндсэндээ 40, 50 мянга руу уначих хэмжээнд байхгүй юу даа. Нэгэнт тэнд экспортын тарифын өндөр босготой болсон Хятадын үйлдвэрүүд манайхаас үнээ дарна. Өмнө нь манай арьс шир ингэж л унасан. Ноос ингэж л унасан. Тэгэхээр үйлдвэрээ босгоод авчихсан цагт үнэ унадаггүй, ард түмэн сэтгэл хангалуун, тэр мал аж ахуй эрхлэх орлоготой байх бололцоо чинь тэр үйлдвэртэй холбоотой байдаг гэдгийг л их маш сайн ухамсарлан ойлгомоор байгаа юм.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

М.Ганхүлэг: Энхбаяр сайд тэр аягүй чухал асуулт асуусан. Бүрэн өөрсдөө дотооддоо авдаг болох түүнтэй холбогдолтой томоохон хэмжээний хөтөлбөр, агуулгыг яаж хийх вэ гэдэг тухай асуусан. Та тэр дээр.

6 номерыг өгөөрэй.

Ж.Энхбаяр: Цагаан алт хөтөлбөрт маань гол зорилгууд нь үндсэндээ тусчихсан. Боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх. Үүнийгээ л бид нар хараад л явчихад болно. Гол зүйл мэдээж төсөв, дэмжлэг, хөрөнгө оруулалтын л асуудал шүү дээ. Мэдээж энэ хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулж байгаа үйлдвэрүүдтэй үйлдвэрүүдийн татварын НӨАТ-тай холбоотой, цалинтай холбоотой, тэр ийм татварын өөрчлөлт зайлшгүй байгаа. Тэрийг бид бас бэлдээд энд холбогдох Сангийн яам, Төсвийн байнгын хороо, бусад Эдийн засгийн байнгын хороо, Хөгжлийн яамнуудад хүргүүлсэн байгаа. Зайлшгүй бас татварын орчинд нэлээн томоохон өөрчлөлт хийх шаардлага бас байгаа.

М.Ганхүлэг: Бат-Эрдэнэ гишүүн нэмж тодруулна.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгэхээр энэ бас сайд ч санал хэлж байх шиг байна. Ер нь миний агуулга бол ерөөсөө энэ том хөтөлбөрөө боловсруулж гаргах хэрэгтэй байна. Тэгээд шахъя хэдүүлээ. Энэ Байнгын хорооноос урьд өмнө ч бид нар гаргаж байсан шүү дээ ер нь Монголбанк, Засгийн газар руугаа нэлээн том хөтөлбөрийн тийм саналыг бол оруулмаар байна. 2026 оноос эхлээд наанадаж хэрэгжүүлэх ийм боломж, бололцоог нь бол нээсэн ийм юу гэдэг юм албан бичиг бодлогын чанартай зүйлийг бол явуулах нь зүйтэй байх.

Хоёрдугаарт нь бас бид нэг зүйлийг бодох хэрэгтэй. Бид нар хэрвээ үйлдвэрлэлээ хөгжүүлээд цаашаагаа экспортоо нэмэгдүүлэх юм бол энэ малчдынхаа 150 мянгатай, 160 мянгатай ноолууртай ноцолдоод байх шаардлагагүй болох байхгүй юу даа. Урагшаагаа харж ноолуур юу доллар олдог, урагшаа гарч валютаа олж ирдэг ийм зүйл байхад энэ малчдын маань үнэ бол тогтворжих ёстой юм шүү дээ.

Хоёрдугаарт, нэг зүйлийг ярихад гадаад экспортоо нээх тал дээр нэлээн том шоу үзүүлбэрийн асуудлуудыг төсөвтөө суулгаач гэсэн ийм хүсэлтийг тавьж байна сайд аа. 2026 оны

М.Ганхүлэг: Бат-Эрдэнэ гишүүнд дахиад нэмэлт минут өгье.

Ж.Бат-Эрдэнэ: 2026 онд зохион байгуулагдах энэ жилийн төсөв мөнгө нь ч хасагдсан юм байгаа биз, 25 оных нь яадаг юм байгаа юм. 25 он болоод 26 он, цаашдаа цаашдаа бүх энэ гадаад экспортыг нээх тал дээр тэр шоу хөтөлбөрүүдэд оролцдог, бодлогоороо оролцдог, тэнд сурталчилгаа хийдэг, аж ахуйн нэгжүүддээ тусалдаг, дэмждэг ийм зүйлүүдийг бүр бодлогоор гаргаж өгөх хэрэгтэй байна. Энэ улс орнууд чинь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ зүгээр май гээд ингээд дэлхийн зах зээлд гаргачхаа шүү дээ. Энэ чинь өөрсдөө бас төр нь дэмжлэг үзүүлж байж, төр нь санхүүгийн болон нийгмийн ийм том дэмжлэг үзүүлж байж энэ эргэлтэд оруулсан ийм түүхтэй байгаад байгаа шүү дээ. Тийм болохоор энэ дээр яамнаас тийм бодлого хэрэгжүүлээч ээ гэж хүсэж байгаа шүү.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

М.Ганхүлэг: 6 номер.

Ж.Энхбаяр: Мэдээж тэгэлгүй яах вэ гадаад зах зээл, гэрээ хэлэлцээр, тэр протоколууд, хорио цээр бүгдийг нь цэгцлэхийн төлөө бид ажиллаж байна. Ялангуяа энэ 10 сард болно Ром хотод дэлхийн хөдөө аж ахуйн байгууллагын 80 жилийн түүхт ой болно. Энэ хүрээнд Монголын хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтын чуулга уулзалтыг Монголд зориулж зохион байгуулах ийм шийдвэр гарсан байгаа. Энэ их бид нарыг дэмжиж байгаа их том бодлогыг нь дэмждэг. Энд бид нар манай хөнгөн, хүнсний, хөдөө аж ахуйн салбар хөрөнгө оруулалтынхаа бодлогыг, хөгжлийнхөө бодлого, хөтөлбөрүүдээ сайн танилцуулах арга хэмжээ энэ дээрээ бүгдээрээ Байнгын хороо гишүүдтэйгээ хамтдаа яваад зөвхөн уул уурхайн хөрөнгө оруулалт ордог биш бас хөдөө аж ахуйн салбар, хөнгөн үйлдвэрийн салбар чинь хөрөнгө оруулалт татах бололцоотой байдаг, экспортын чиглэлээр хөгжиж болдог гэдгийг бас харуулах их том боломж, орон зай үүсэж байгаа шүү. Энд идэвхтэй оролцоорой. Сурталчилгааны зардал дээр.../минут дуусав./

М.Ганхүлэг: Энхбаяр сайдын микрофоныг дахиад өгье.

Ж.Энхбаяр: Бид байгаа нөөцийн хэмжээнд ЖДҮ үндэсний үйлдвэрлэгчдийн зах зээлтэй нь холбох, уях чиглэлийн ажлуудыг л нэлээн л хийж байгаа. Дотооддоо Алтан намар, Сар шинийн худалдаа, энэ Намрын өдрүүд эд нарыгаа хийдэг. Мөн энэ Хятад-Монголын экспо гээд энэ 10 сард хийнэ уламжлалтаараа. Манай аж ахуйн нэгжүүд маш их том гэрээ, хэлцэл, экспортынхоо боломжийг олж авдаг. Энийг бас 10 сард зохион байгуулна. Дэлхийн том том гол хотуудад бас made in Mongolia буюу Монголд үйлдвэрлэсэн бараануудын нэрийн дэлгүүрүүдийг байгуулах энэ ажлыг манай ЖДҮ-ийн газрынхан бас нэлээн зохион байгуулаад 4, 5 нэгж дээр томоохон ийм нэгж байгуулаад бас ажлууд нь овоо, борлуулалт нэлээн идэвхжиж байгаа байдлууд байна.

Ер нь тэгээд л тэр борлуулалт, сурталчилгаа дээр тавигдсан төсөв болгон л хасагддаг. Хөдөө аж ахуйн гэхээрээ энэ гадаад бодлогын асуудал биш, гадаад харилцааны асуудал биш, гадаад асуудал тийм гэж ойлгодоггүй ерөөсөө. Хөдөө аж ахуй чинь өөрөө ерөөсөө л гадаад харилцаа.

М.Ганхүлэг: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Та бүхний амрыг эрье. Энэ Цагаан алт хөтөлбөртэй холбоотой асуудал дээр ер нь тэгээд өөрсдөө бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх гэдэг энэ төрийн бодлогыг дэмжилгүй яах вэ. Хэдий болтол түүхий эд бэлтгэх ч байх вэ. Гэхдээ яг нөгөө бэлтгэж байгаа тэр хүмүүс маань тэнд асар их бухимдалтай байгаад байгаа байхгүй юу. Малчин ердөө өнөөдөр малаас гулууз махыг нь хавартаа ноолууртайгаа л ингээд мөнгө олдог. Тэгээд энэ маань ингэчихлээ гээд иймэрхүү байгаад байгаа юм. Тэгээд би салбарын бодлого 3 жил хойшилж хойшилж энэ жил ингээд нөгөө хөдөлж эхэлж байгаа. Гэхдээ эндээс би таны юунаас самнах хүчин чадал 100 хувь байгаа юм байна. Сайн зүйл. Худалдан авах хүчин чадал гэж хаана, юу байна вэ? Одоо ингээд үндэсний үйлдвэрүүд нь 2000 тонныг авчихаар цаана нь 6500 тонн ноолуурыг нь хэн авах вэ, яаж боловсруулж, яаж зах зээлд оруулах вэ, үнэ нь ямархуу байдалтай байх болов уу?

Нөгөө талдаа таны үгээр ингээд төсвийн тодотгол хийгээд төсөв хасагдсан. Түүнээс болоод бид бүтэн авч чадаагүй гэсэн ийм тайлбар хэлж байна л даа.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Гэтэл таны танилцуулга дээр 230 тэрбум төгрөг эргэлтийн хөрөнгийн зээл олгочхоод байхад ердөө тэгж 21.3 хувь нь гараад байна шүү дээ. Тэгэхээр яг одоо энэ үндэсний үйлдвэрүүд худалдан авах эх үүсвэр байхгүйдээ авахгүй ч байгаа юм уу тийм хүчин зүйл нөлөөлөхгүй байгаа юм биш үү? Тэгэхээр би энийг яагаад яриад байна вэ гэхээр энэ ноолуур энэ удаа савлалаа гэхэд цаашид ингээд тогтвортой байдаг малчин хүн ноолуураа хэдэд өгөх вэ гэж санаа зовохгүй болгох ийм юм руугаа л Монгол Улс явах гээд байгаа учраас эхнээс нь энийгээ их зөв тавиад явахгүй бол ингээд мөнгө тавьж өгөөд байхад авахгүй, яг амьдрал дээр ноолуурыг нь авахгүй байгаа ийм нөхцөл байдал урьд өмнө нь гарч байгаагүй учраас малчид энэ дээр маш их бухимдалтай байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ хавар гэдэг чинь малчдын хувьд нэлээн онцлогтой, 2 давхар зээл төлнө, Шинэ хоршоогоо төлнө, үндсэн нөгөө малчны зээлийнхээ 1 жил хойшлуулсныг төлнө гээд ингээд энэ болгон чинь л ингээд нийгэмд жоохон тийм яриа үүсгээд байгаа болохоос биш төрийн бодлогоо эсэргүүцээд байгаа юм байхгүй шүү дээ.

Гэтэл яг өнөөдөр Хэнтий аймагт ноолуур нь байгаад байдаг авдаг хүн байдаггүй. Нөгөө үндэсний үйлдвэрүүд маань яагаад авахгүй байна? Би наашаа орж ирэхдээ мэдээлэл аваад л орж ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр Улсын Их Хурлын танхимд бид бас ингээд яг малчдын ярьдаг, хэлдэг зүйлийг бас дамжуулах үүрэгтэй ийм хүмүүс. Тэр утгаараа бас би энийг асууж байгаа юм.

Цагаан алт-тай холбоотой дараагийнх нь энэ арьс ширний үйлдвэрийн асуудал байгаа. Дарханд хийх байсан маань жоохон бүтэлгүйтсэн. Одоо Эмээлтэд гэж ярьж байгаа. Зөвхөн нийслэл л энийг яриад байгаа. Тэгээд Хөдөө аж ахуйн яам энэ дээр ер нь ямар анхаарал хандуулж байгаа вэ? Энэ ер нь хэзээ ашиглалтад орох вэ? Мэндсайхан сайд 3 жилийн өмнө 20 сая арьс гэж ярьж байсан. Үүнийхээ бид нар хэдийг нь боловсруулдаг болгох вэ? Энэ бас л малчдын байнга асуудаг зүйл. Тийм.../минут дуусав./

Б.Бейсен: 6 номер, сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Ноолуур авагдаж байгаа. Одоогоос л эхэлж байна шүү дээ 155-аас 165 мянган төгрөгийн хооронд ноолуур авагдаж байна. Бид нар өдөр болгон үйлдвэрүүдийн ноолуурын мэдээ байгаа. Яг одоо 500 гаруй тонн ноолуур яг худалдан авагдаад наашаа дав Улаанбаатар хотод үйлдвэрүүдээр ирчихсэн байна. Ийм л технологийн жоохон зөрүү байгаа юм. Угаах амархан. Өнөөдөр аваад өнөөдөр үйлдвэрт угаагаад маргааш пресслээд шууд экспортод гаргачихдаг. Самна гэдэг маань авсан ноолуураа аваад самнах үйлдвэрлэлийн дараагийн шинэ процедур, процесс явагдана шүү дээ. Тэнд хугацаа орно. Мэдээж энэ жоохон хугацааны хувьд сунжирна. Ноолуур бол тасралтгүй ингээд хавар, зун, намар боловсруулалт хийгдэнэ л гэсэн үг. Тэрийг их ойлгох хэрэгтэй. Тэрнээс угаагаад шууд гаргадаг шиг ийм авлаа, өглөө буюу тийм хурдан ченжийн ийм орлого, зарлага бас боломжгүй. Бодит байдал.

Эргэлт дээр байгаа 230 тэрбум төгрөг юунд ч хүрэхгүй байгаа. Гэхдээ энэ хэмжээнд үйлдвэрүүд авч байна, дээрээс нь өөрсдөө эх үүсвэр авч байна, гадаад зээлээ хийгээд мөнгөө валютаа татаж оруулж ирээд авч байна. Дөнгөж эхэлж байна шүү дээ ноолуур гараад. Тэгээд жоохон харах, хүлээх хэрэгтэй байна. Яаран дүгнэлт хийх болоогүй байна. 1 жилийн хугацаа хэрэгтэй байна бид нарт. Үр дүн гарна. Ноолуурын үйлдвэрлэл дээр манай хөнгөн үйлдвэрийн өсөлт 50, 60 хувиар өсөж, олон мянган ажлын байр, нэмүү өртөг Монголд хэдэн зуун тэрбумаар

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үлдээд ирэхээр бид хаана хаанаа ойлгох байх. Алийн болгон бусдын аманд багтаж яаруу сандруу хөдлөх вэ дээ гэж. Ингэж явсаар байгаад л арьс ширээ үнэгүй болгочихсон, ноосоо үнэгүй болгочихсон шүү дээ.

Тэгэхээр үйлдвэрлэл босгоод авах нь их чухал байна гэж. Арьс ширний 27 үйлдвэрийн 24 нь Улаанбаатар хотод байна. Өөр үйлдвэр алга. Нэмэгдсэн үйлдвэр алга байна. 24 үйлдвэр 24-үүлээ бид Дарханд нүүхгүй ээ гэдгээ албан ёсоор илэрхийлсэн. Бид Дарханы Эмээлт технологийн паркт нүүж шилжээд тэндээ үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг явуулна гэдэг шийдвэрээ Арьс ширний холбоо албан ёсоор яамандаа бодлогоо, мэдээллээ өгсөн.

Баруун бүсэд Ховдын үйлдвэрлэл, технологийн парк орсноор баруун 5 бүсийн арьс шир баруун талдаа төвлөрөх буюу боловсрох ийм болно. Шинэ бололцоо бий болно оо. Гол ажил гол бодитой явж байгаа ажил тэр байна. Тэгэхээр бид ноолуурын авч байгаа мэдээнүүдийг өгөөд байя. Одоо мөнгөний нийлүүлэлт дээр жоохон Монголбанкны бодлогын арга хэмжээ аваад засгаар бид нар асуудал оруулаад шийдүүлчихвэл явчихаар л байна. Би хэлээд байгаа шүү дээ үнэхээр харамсалтай шүү тэр яг ноолуур авах энэ эх үүсвэрийг Их Хурал танаад багасгачихсан байна. Тэгээд юмны бодлого гэдэг чинь ингээд ингээд цөмлөөд байхаар дараа дараа юмандаа ингээд нөлөөлөөд байдаг. 1 жил тэсээдхээрэй л гэж гуйж байна даа бүгдээрээ.

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя .

Ц.Идэрбат: Тийм ээ энэ үгүй ээ тэгээд таны ярьж байгаа бодит байдал 2 чинь зөрөөд байх юм. Тэгээд Их Хурал ингээд мөнгийг нь танаснаас болоод ноолуураа авч чадахгүй байгаа юм шиг. Гэтэл 230-ийг баталж өгчхөөд байхад үйлдвэрүүд чинь 21-хэн хувьтай зээлээ аваад байдаг нь ямар учиртай юм? Цаана нь дахиад 60 гаран хувийн зээл нь үлдчихээд байгаад байгаа юм биш үү? Зээл авахад боломжтой байгаад байгаа юм биш үү? Тэгэхээр яагаад энэ үндэсний үйлдвэрүүд маань 230 тэрбум төгрөгийг өнөөдөр дуустал авчихсан ноолуур руугаа яагаад орохгүй байгаа юм бэ? Үгүй ээ таны өгсөн дээр л би ярьж байна шүү дээ энэ дээр. Үндэсний үйлдвэрүүд эргэлтийн хөрөнгийн 21.9 хувийн зээл авсан байна. Тэгэхээр цаана нь энэ чинь 60 гаран хувийн зээл нь байгаад байдаг. Гэтэл таны тайлбар болохоор эх үүсвэр нь хүрэхгүй байгаа учраас ноолуур авахаа зогсчихлоо гэсэн юм яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр би нөгөө таны өгсөн юун дээр л яриад байгаа юм.

Б.Бейсен: 6 номер, сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ мэдээлэл Байнгын хорооноос өгсөн үүрэг даалгаврын дагуу 3 сарын 31-ний мэдээлэл шүү дээ. Аягүй юм хурдтай явж байна. 230 тэрбумын энэ асуудал бүх авах эзэн тодроод үйлдвэрүүд нь гарчихсан явж байгаа ажил байхгүй юу даа. Ахиад мөнгө хэрэгтэй байгаа юм. Тийм мөнгө хэрэгтэй байна. Тэгвэл улам л сайн байна. Гол нь энэ моментыг л Монгол Улс алдмааргүй байна шүү дээ. Гадна талд тарифын хөдөлгөөн үүсчихсэн үед дотоодоосоо түүхий эдээ бэхжүүлээд үйлдвэрлэлийнхээ чадавхыг босгоод ирье дээ. Олон мянган ажлын байр, олон зуун тэрбум эх үүсвэр Монгол Улсад үлдэх гээд байна шүү дээ гэж. Амархан шүү дээ энэ техник зохицуулалтыг хүчингүй болгочих шиг амархан.

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ц.Идэрбат: Тэгвэл одоо хэдүүлээ тэгвэл ноолуурын энэ эргэлтийг өшөө сайжруулахын тулд, сайжруулахын тулд өнөөдрийн энэ хурлаас бас ямар үр дүн гаргах ёстой юм бэ? Одоо эх үүсвэрээ хаанаас гаргах юм бэ гэдэг энэ талынхаа юмыг хэдүүлээ бас ярих нь зөв юм биш үү би. Яагаад гэвэл ноолуур хурдан борлогдоосой, тэр үйлдвэрүүд нь түүхий эдтэй болоосой гэсэн ийм л зүйл байгаад байгаа байхгүй юу. Яг амьдрал дээр болохоор ноолуур авдаг хүн байхгүй болчихлоо гээд. Би уржигдрынхаа Хэнтий орсон. Зүгээр дэлгүүрээр ороод гарахад 3 хүн зүгээр ноолуур авах уу гээд утасдаад өнөөх нь авахгүй гэж байгаа бололтой л байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр хэрвээ энэ мөнгө нь дуусчхаад ингээд ноолуур авахгүй байгаад байгаа бол хурдан эргэлтийг нь нэмэгдүүлэх тал дээр энэ Байнгын хороо ч тэр, яам ч тэр тэгвэл хамтраад ингээд ямар ч байсан л эргэлтэд оруулаад авъя л даа. Тэгвэл тийм.

Б.Бейсен: 6 номер, сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Тэгэхээр Монголбанк, Их Хурлын байгууллага, Их Хурал тайлангаа тавьдаг. Байнгын хорооноос ийм бодлогын чиглэл бас дэмжлэг хэрэгтэй л байна. Нийт гаргасан эх үүсвэр 230 тэрбум төгрөг нийт энэ жил бий болж байгаа 1.3 их наядын ноолуурын дөнгөж 20 хувийг худалдан авахад хүрэлцэж байна. Цаад 80 хувийг авахад эх үүсвэр гаргаад валют, нөөц бүрдүүлэх бодлогын хүрээнд ноолуурыг валют гэж хараад ийм арга хэмжээ аваад явбал болохоор байгаа юм. Яам бид нар болохоор улаан буудайг стратегийн бүтээгдэхүүн гэж үзэж стратегийн нөөцийг бүрдүүлээд зохицуулалт хийгээд явдаг шүү дээ. Түүнтэй адилхан ноолуур дээр гол нь жил жилдээ 1 их наядыг гаргаад ноолуурын нөөцийг бүрдүүлээд байхад их л тогтвортой байдлыг малчин талдаа ч тэр, үйлдвэр талдаа ч тэр их чухал боломж байгаад байгаа юм. Тэгэхээр миний хувьд яах вэ батал.../минут дуусав./

Б.Бейсен: Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Баярлалаа. Тэгэхлээр малчид баруун аймагт амьдарч байгаа малчин түмэн надаас асуулт асуугаад байгаа юм. Өдөр, шөнөгүй над руу мессеж бичиж байна. Өглөө хүртэл 2, 3 хүмүүстэй ярилаа. Тэгээд өнөөдөр бид нар монгол төрийн бодлого малчдаа дэмжье, төвлөрлийг сааруулъя, малчин түмэн маань залуу халаа байхгүй боллоо, малчид цөөрлөө гэдэг ийм асуудлууд яриад байдаг.

Гэтэл нөгөө талдаа малчдыгаа орлоготой байлгах бодлогыг төр ерөөсөө ярьдаггүй. Орлоготой байх юм бол малчин түмэн чинь угаасаа өөрсдөө малч удамтай хүмүүс. Хэн ч очоод малаа маллаад амьдрах ийм ёс, уламжлалаа сурчихсан ийм хүмүүс. Өнөөдөр тэнд амьдрах боломж орлогын хэмжээ нь бага учраас өнөөдөр төвлөрсөн газар руу энэ малчид чинь нүүгээд байна шүү дээ. Тэгээд өнөөдрийн малчдын яг авч байгаа гол орлого нь юу юм? Ноолуурын орлого, махны орлого. Арьс шир нь үнэгүй хаягдчихсан. Төрийн буруу бодлогоос болоод өнөөдөр арьс шир гудамжинд, гуу жалганд хаягдал болгоод хэвтэж байгаа. Өнөөдөр яг тойргийн малчдаас над руу ярьж байна шүү дээ. Яг арьс ширийн энэ алдаа дахиад ноолууран дээр явах гээд байх шиг байна, та энэ дээр анхаарч өгөөч ээ гээд над руу ярьж байна. Малчдын ганц авч байгаа 2 гол орлогын малынх нь асуудал нь ингээд улсаас стратегийн хүнс гэдэг юманд оруулаад төрийн зохицуулалттай квот гээд ингээд хаячихсан. Саяхан хүртэл экспортыг түр хугацаанд бас хязгаарлаад авах шиг боллоо.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Дээрээс нь ингээд ноолуурын асуудал байна. Бид нар угааж, самнаад гаргаад 250 сая доллар үлдэнэ, энэ ашигтай бизнес болно л гээд яриад байна. Тэгсэн мөртөө банкнууд д нь зээл өгдөггүй, төсвөөс мөнгө гаргаж өгөөч ээ гэдэг зүйлийг салбарын сайд нь яриад сууж байна. Үнэхээр ашигтай тийм бизнес 250 сая долларын ийм ашигтай бизнес юм бол яагаад арилжааны банк энэ дээр зээл гаргаж, мөнгө гаргаж болохгүй байгаа юм? Тэгээд танаас би тодорхой асуумаар байна одоо. Өнгөрсөн жил 100кг ноолуур 170-аас 185 мянгаар авч байсан. Тэр үед өнөөдөр баруун аймагт 130-аас 140 мянга, доошоогоо ч орж байсан. 120 мянга руу ч орж байсан. Одоо төвийн бүсэд зарагдаж байгаа, авч байгаа энэ 150 мянгаар авч байгаа ноолуур чинь баруун бүс дээр очиход 100 мянга болчих гээд байна. Малчдын орлого буурах гээд байна. Сая Идэрбат гишүүний хэлдэг малчид чинь 2 зээлтэй байна шүү дээ. Хойшлуулсан зээл байна, Шинэ хоршоо хөтөлбөрийн зээл байна. Энэ 2 зээлийгээ яаж төлөх юм бэ гэдэг ийм асуудлууд байгаад байгаа юм. Тийм учраас танаас та тодорхой хэлж өгмөөр байна. Баруун бүс нутагт ноолуурыг хэдэн төгрөгийн ханштай авах юм бэ энэ жил? Өнөөдөр та сая зүүн бүсээс 600 тонн ноолуур авлаа гэж байна. Статистикийн мэдээгээр энэ чинь Зүүн бүсийн бэлтгэдэг ноолуурын 50 хувь ч хүрэхгүй.../минут дуусав./

Б.Бейсен: Заяабал гишүүн гүйцээж асууя. Сайд хариулъя. Дараа нь гүйцээж асууя. 6 номер.

Ж.Энхбаяр: Таны яриад байгаа мал маллах хүнгүй боллоо. Хүндрээд байгаа асуудал чинь үйлдвэрүүдээ л унагаасантай холбоотой байхгүй юу даа. Мал аж ахуйн гаралтай түүхий эд чинь үйлдвэрлэл дээр очиж байгаад л өртөг өсөж байж, баялаг болж байж л дараа дараагийн тогтвортой байдлыг л хангаж байгаа шүү дээ. Бидний алдаа тэр шүү дээ. Ингэж явсаар байгаад бусдын түүхий эдийг бэлддэг болчихсон. Тэдний эдийн засгийн савлагааг дагаж ноос, ноолуур, арьс шир нь унадаг. Саяын хэлдгээр гуу, жаланд хаягдаж байгаа чинь энэтэй л холбоотой. Зүгээр өдөр тутмынхаа ахуйдаа хөтлөгдөж өдөр тутмын бодлого дагаж гаргасаар байгаад энэ. Ер нь үйлдвэрлэлээ босгож байж л улс орон хөгжинө шүү дээ. Хөдөө аж ахуй чинь ч хөгжинө. Хөдөө хүн ажиллах, амьдрах, ашиг орлоготой байх гол бодлого чинь үйлдвэрлэл дээр л тулгуурлаж явагдана. Махан дээр нэлээн бодлого сайн явж байгаа. 30 жил чадаагүй ажлыг сүүлийн 2 жил Хөдөө аж ахуйн яам хийсэн. 300 сая доллароос буухаа больсон. Экспорт хийж. Энэ бүх мөнгө малчид дээр очиж байгаа.

Ноолуур маш өндөр түвшин, боловсруулалтын түвшин сайжрах тусам үнэ өсөж байгаа. Нүүрсний үнэ чинь яаж унаж байгаа харж байгаа биз дээ? Гэтэл ноолуур 5-хан хувийн хэлбэлзэл хийгээд тэгээд тогтвортой байдлаа хангах бололцоо үүсэж байна шүү дээ. Тэгэхээр энийг яагаад жадлаад байна.

Сүүн дээр татаас өгч байгаа юм. Үйлдвэрт тушаасан сүү литр тутамд 1000 төгрөг өгөөд сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж байгаа юм. Тэгэхээр ажил хийдэг хүнд боломжийн орлого бүрдэх бололцоо, бүрдүүлэхийн төлөө бид ажиллаж байгаа. Үгүйсгэж болохгүй. Ахиад хэлье малчдыг яагаад орлоготой байлгах гол юм бол үйлдвэрлэлээ дэмжиж байж л явна гэдгийг л 30 жилийн түүх шүү дээ харлаа шүү дээ. Гангаа үйлдвэрлэж байж л нүүрс чинь үнэд орох юм байна шүү дээ дотооддоо. Бусдын түүхий эд бэлдээд байвал тэгээд л хил худалдаа, хэд нь гарсан нүүрсний машин, тоо тоолохоос өөр аргагүй л сууж байна шүү дээ. Тэгээд л улс орноороо дагаж саваад л, хэлбэлзээд л больё л доо. Одоо жоохон чаддаг

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хэдхэн зүйлээ чаддаг больё, үйлдвэрлэе. Би хэлж байна шүү дээ хугацаа орно 1 жил байна тэсэх хэрэгтэй. Гадаад таатай нөхцөл үүсчихлээ. Үйлдвэрээ босгоод авъя. Ядахдаа ноолуураа босгоод авъя л даа. 100, 100-н тэрбум Монголд үлдэх нь байна шүү дээ. Энэ чинь малчид маань дараа нь нөгөө ноос унадаг шиг, арьс шир үнэгүй болдог шиг эрсдэлд орохгүй болчихлоо гэсэн үг байхгүй юу даа. Энэ бололцоог бид нар бодлого гаргаад базаад авах хэрэгтэй байна шүү дээ. Одоо энэ явж байгаа бодлогыг таныхаар хойшлуулаад ингээд хаячихъя л даа. Хятадын ченжүүдэд өгнө. Та үнэ өснө гэж бодож байна. Үгүй шүү дээ тэнд чинь 36, нэмэх нь 50 хувийн тарифын зөрүүнд орчихсон. Тэр эрсдэлийг бид нар дээр буулгачихна. Түүхий эд дээрээ л буулгана шүү дээ. Энийг ойлгох хэрэгтэй шүү дээ та чинь өөрөө санхүүгийн хүн мөн биз дээ?

Махан дээр ямар хязгаарлалт хийгдээгүй. Монгол Улс гэрээгээр хүлээсэн бүх махаа экспортод амжилттай гаргаж чадсан. Одоо ч гаргаж байгаа юм. Ямар их үнэ, ямар их ажил хийж байж арайхийж тэр махны зах зээлийг нээв. Арабын орнууд, зүүн өмнөд Азийн орнууд, Төв Азийн орнууд, Ойрх Дорнодын орнууд. Зөвхөн нэг газраас хамааралтай байсан мах өнөөдөр олон зах зээлтэй болоод идэвхтэй явагдаж байна шүү дээ. Махны үйлдвэрүүдээ босгож чадсан болохоор махны үйлдвэрт болохоор бид нар чинь экспорт хийгээд эхэлж байгаа байхгүй юу үйлдвэрүүд. Би яаж мэдэх юм айн? Би хэлж байна шүү дээ дэлхийн зах зээлээ хар, ноолуурын үнэ 94-өөс 97 доллароор самнасан ноолуур тогтож байна. Үнэ, ханш, чанар, ширхэг, ноолуурын бусад хольц олон зүйл үйлдвэрийн үнийг тогтооно шүү дээ. Тэрийг сайд тогтоогоод тэд байдаг гэж хэлэх бололцоо байхгүй шүү дээ. Зах зээлийн хандлага боломжийн байна, чамлахаар чанга атга.

Б.Бейсен: Заяабал гишүүн тодруулаад асуулт асууя.

Б.Заяабал: Зах зээлийн зарчмаар хааж боогоод үйлдвэрлэл хөгжих тийм онол байхгүй. Та нар хааж боогоод тэр арьс ширнийхээ үйлдвэрлэлүүдийг хар. Хааж боогоод ямар үйлдвэрлэл хөгжих юм бэ? Өнөөдөр үндсэндээ түүхий ноолуураа зарахаа болиод бүгдээрэнг нь угаана гээд, 1 жил тэсээрэй гээд ингээд аль малчдыг өр, зээлийг нь хүнд байх, өнгөрсөн жилийн зудынхаа хүнд байдлаас гаргах яг ийм үе дээр нь дахиад 1 жил тэсээрэй гээд ингээд бага үнэтэй ноолуурыг нь авах ийм бодлого явна гэдэг юмыг та хэлээд сууж байна. Энэ чинь болохгүй байна. Та өөрөө намайг эдийн засагч гээд сая ярьж байна. Өнөөдөр Америк, Хятад хоёрын хоорондын тариф энэ ноолуурт падлийгүй. Америк өнөөдөр Хятадаас зөвхөн ноолуур авдаг юм биш. Трампын тэр тарифын бодлогыг өнөөдөр бүх юмтай, бүх төрийн бодлоготой хольж ярьдаг болж байна. Энэ ямар ч хамаагүй шүү дээ. Хятадууд хаашаа ноолуураа зардаг юм? Та тэрийг нь судал л даа. Америк руу тийм бүх.../минут дуусав./

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Одоо юу гэж ч хариулмаар юм бэ дээ. Тэгээд үйлдвэрүүд ноолуураа авч байна. Бид байгаа нөөцийн хэмжээнд эх үүсвэрийг нь бэлдэж өглөө. Бусад эх үүсвэрээ дайчлаад ноолууруудаа авна. Монгол Улс зөвхөн самнасан ноолуур гаргана буюу нэмүү өртгөө дотооддоо үлдээнэ. Ажлын байраа бий болгоно, үйлдвэрлэлээ нэмэгдүүлнэ, эцсийн бүтээгдэхүүн үнэтэй болно. Үүнээс олох орлого Монгол Улсад нэмэхээр тусна. Ийм л бодлого шүү дээ. Үгүй ээ наадхаа боль, хямдхан аваачиж ченжүүд өгөөд гарга гэж байвал Их Хурлын л бодлого шүү дээ. Эцсийн эцэст бид бодлогыг л хэрэгжүүлж байгаа шүү дээ.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Яаралтай үйлдвэрийн түвшнээ сайжруул, боловсруулалтаа сайжруул, Цагаан алт хөтөлбөр гээд Их Хурал батлаад өгсөн. Тэр хэмжээнд би ажиллаж байна шүү дээ. Тийм бол тэр манай төсвийг хасаж байхын оронд тэрийг үлдээхгүй яасан юм. Тэгсэн бол ийм асуудал байхгүй тун эвтэй.../минут дуусав./

Б.Бейсен: Заяабал гишүүн тодруулъя.

Б.Заяабал: Та ер нь зах зээлийн эдийн засгийн талаар ойлголт маш тун багатай хүн юм байна. Зах зээлийн эдийн засгийн талаар та жоохон судал. Төрөөс бүгдийг авдаг юм тийм юм байдаггүй юм. Та Шинэ Зеланд, тэр бусад Европын орнуудын хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн тэр хөгжил, өсөлт хөгжилтийг нь судал. Бүгдийг төрөөс төсвийн мөнгөөр авдаг тийм зүйл байхгүй. Энэ төсөв чинь дийлэхгүй байна шүү дээ асуудлаа. Иргэд чинь татварынхаа хувийг бууруул гээд байна шүү дээ. Та эсрэгээрээ нэмэх юм яриад сууж байх юм. Ийм бодлого байж болохгүй ээ. Цагаан алт хөтөлбөрийг би дэмжиж байгаа. Цагаан алт хөтөлбөр дээр юу гэж байгаа вэ гэхлээр ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг 20-оос 40 хувь хүртэл нэмэгдүүл гэж байгаа. Тийм, бүгдийг нь хааж байгаад бүх бүх ноолуурыг угаа гэсэн тийм юм руу, угааж самна гэсэн тийм юм байхгүй. Та бас энэ бодлогуудаа зөв яриарай. Тэгээд эргээд би дахиад асууя баруун бүс дээр ноолуур 1кг ноолуур хэдээр авах вэ та тэрийг тодорхой хариулт өгчих.

Б.Бейсен: Энхбаяр сайд тодорхой хариулаарай. Тодорхой асуултаа асуулаа.

Ж.Энхбаяр: Үйлдвэрлэлийн түвшнийг 20-оос 40 хувь, угаах 100 хувь суурилчихсан, самнах 100 хувь суурилчихсан. Одоо дараагийн үйлдвэрлэл юу байдаг вэ гэвэл ээрэх. Дөнгөж бэлэн ноолуурынхаа бид нар 20-хон хувийг ээрч байгаа тул энийгээ 40 хувь болгоё гэдэг л бодлого шүү дээ. Нэгэнт самнах хүчин чадал суучихсан байхад энийгээ хийе. 250 саяас багагүй доллар Монгол Улсад үлдэх нь. Энэ маань тогтвортой байдлыг хангах нь. Одоо цамнах дээр хөрөнгө оруулалтууд үйлдвэрүүд маань хийж байна. Утсаа хийх үйлдвэрлэлүүдээ хүчин чадлаа нэмж байна. Нэг.

Чөлөөт зах зээл, зах зээл гээд 90 оны үр дүнд манайх бүх хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдээ 100 хувь боловсруулаад экспортод гаргадаг байсан бүх үйлдвэрүүдээ л унагаасан шүү дээ. Одоо босгох гээд Цагаан алт гээд хөтөлбөр гаргаад, Их Хурал нь батлаад хэрэгжүүл гээд бид явж байна шүү дээ. Олон зүйл чадаж байгаа юм алга. Цөөхөн зүйл байна.

Б.Бейсен: Энхбаяр сайд тодорхой асуулт асуулаа шүү дээ. Баруун бүсэд нь 1кг ноолуурыг хэдээр авах вэ гээд тодорхой хариул даа.

Ж.Энхбаяр: Бейсен дарга би яаж мэдэх вэ. Дэлхийн зах зээлийн үнэ, төлөв байдлаа хар. Орц норм, бүдүүн ширхэг, хольц олон зүйл нөлөөлнө. Өнөөдөр 1кг самнасан ноолуур 100 орчим доллар дээр Европын зах зээл дээр байна. Ноолуур чинь 100 хувь самнагдсан ноолуур гол арилжааны бүтээгдэхүүн болж байна. Тэрүүнтэй зүйрлээд үзэхэд өнөөдрийн ханш 150-аас 160 мянган төгрөгөөр тогтох нь. Яг зах зээл, би тэгж хэлсэн ноолуур эхлэхээс өмнө хэлсэн. Одоо яг түрүүгээрээ л худалдан авалт хийгдэж байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Харин харьцангуй энэ дэлхийн энэ ойлгомжгүй, тогтворгүй байдлын үед ноолуурын энэ текстилийн салбар боломжийн буюу ноолуур боломжийн тогтвортой байна. Өнгөрсөн жилээс 5 хувийн үнийн хэлбэлзэл үүссэн байна.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн асуулт асууя.

3.Мэндсайхан: Цагаан алт хөтөлбөрийг санаачилж Их Хурлаар батлуулсан хүний хувьд хөдөө аж ахуйн салбарынхандаа, Энхбаяр сайдад бас баярлалаа гэж хэлье. Цаг хугацаа алдалгүй энэ том хөтөлбөрийг эхлүүлж чадсанд. Саяын гишүүдийн асууж байгаа асуултын ерөөсөө хариулт нь өөрөө энэ үндэс Цагаан алт хөтөлбөр л дөө. Энэ малын түүхий эд боловсруулах бүтээгдэхүүнүүд маань, үйлдвэрүүд маань хангалттай хүчин чадалтай байж чадахгүй байгаа учраас л малчдын маань орлого тогтворгүй, малчдын маань залган чулуу ховордох, хөдөө нутаг маань эзгүйдэх ийм л асуудал үүсээд байгаа юм.

Монгол Улсын Засгийн газраас Их Хурлаас 2 хөтөлбөр баталсан. Нэг нь малчдаа дэмжих буюу тэр мал аж ахуйг тогтвортой эрхлэхэд зориулсан энэ Шинэ хоршоо хөтөлбөр байгаа. Шинэ хоршоо буюу энэ мал аж ахуйг тогтвортой эрхлэхийн тулд бид юуг тэргүүн ээлжид авч явах вэ гэхээр ерөөсөө хөнгөн үйлдвэр буюу боловсруулах үйлдвэрүүдээ юм байгаа юм. Тэгэхээр цаг алдалгүй энэ хөтөлбөрийг Цагаан алт хөтөлбөрийг хэрэгжүүлж эхнээсээ үр дүнгээ өгч байна харж байгаа. Над руу энэ хөтөлбөрийг санаачлаад би хөнгөн үйлдвэрийнхэнтэй бүгдтэй нь уулзаад явж байсан учраас өнөөдөр над руу үйлдвэрүүд ярьж байна. Энэ бодлогоосоо битгий ухраарай Энхбаяр сайд аа. Самнах, самнаад гаргана гэдэг энэ салбарын бодлогын хүрээнд яаж байна вэ гэхээр хилийн цаана аваачаад самнаад цаашаа дэлхийн зах зээл рүү гаргадаг байсан Хятадууд буюу бидний ярьж заншлаар урд худалдан авагч ченжүүд маань өнөөдөр үндэсний үйлдвэрүүдтэй хэлцэл хийж эхэлж байна. Энийг үндэсний үйлдвэрүүд ярьж байна. Юу вэ гэхээр зэрэг нэгэнт бид нар боловсруулаад, угаагаад гаргахгүй болсон учраас, төрийн бодлого ийм байгаа учраас үндэсний үйлдвэрүүдтэй хамтарч ноолуур аваад танай үйлдвэр дээр угааж самнаад гаргая гэдэг энэ хэлцэл рүү явж байна. Энийг чинь дагаад мөнгөн урсгал орж ирж байна. Мэдээж ченжүүдийн зүгээс энэ бодлогыг үгүйсгэж байгаа асуудал байгаа. Тэгэхдээ бид нар 1 жил давчих хэрэгтэй байна, тэсэх хэрэгтэй байна. Тал талаасаа дэмжээд энэ хөтөлбөрийг зайлшгүй явуулах ёстой.

Нөгөө талдаа зээлийнхээ хэмжээг та нэмэгдүүлэх талд нь бас анхаараач. Ер нь жилдээ 200 орчим тэрбум төгрөг л гараад явчихдаг шүү дээ хөнгөлөлттэй ноолуурыг бэлтгэхэд.

Нөгөө талдаа давуу тал нь бид нарын ярьдаг энд ченжүүд маань Хятадуудтай хамтраад авдаг байсан бол тэр мөнгө чинь өөрөө манай үндэсний үйлдвэрүүд рүү өнөөдрөөс эхлээд, энэ сараас эхлээд хэлцэл хийгдээд үйлдвэрүүдээр бас дамжиж гарах тэр бололцоо нь гарч байна. Яагаад гэхээр бидэнд санах хүчин чадал нь 100 байгаа учраас.

Нөгөө талдаа би таныг бас нэг асуудлаас битгий буцаач ээ гэж хэлэх гэж байгаа юм. Евро Азийн тарифын хэлэлцээр дээр жоохон улс төр яваад энэ Оросуудтай нийлээд эх орноо будаа болгох гэж байна гэдэг яриа явангуут энэ яриа ингээд зогссон. Газар тариалан, хүнсний салбараасаа бусад зүйл буюу ялангуяа хөнгөн үйлдвэрлэлийн салбар дээр энэ Евро Азийн хэлэлцээр дээр

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хөдөө аж ахуйн яам санаачилгатай оролцох ёстой шүү. Тэр 40 хувиар нэмэгдүүлэх гээд, 20 хувийг 40-д хүргэх гээд байгаа ээрэх хүчин чадлын чинь том тэр зах зээл нь өөрөө манай хөрш ОХУ буюу Евро Азийн тэр.../минут дуусав./

Б.Бейсен: Мэндсайхан гишүүнд 1 минут.

3.Мэндсайхан: Энэ дээрээ би Энхбаяр сайдыг бас тууштай байгаад яг тэр хүнсний бүтээгдэхүүн, хүнсний дотоодын зах зээлээ хамгаалсан бодлогоо бариад хөнгөн үйлдвэрлэлийн салбар дээрээ та Евро Азийн хэлэлцээр дээр манлайлж оролцоорой. Энэ дээр би бас дэмжиж ажиллана.

Мөн Ховд үйлдвэрлэл технологийн парк, Завханд маань дулааны цахилгаан станц баригдсан. Энд бас үйлдвэрлэл, технологийн парк хөгжүүлэх боломж нь бүрдэж байгаа шүү. Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд энийг бас дэмжиж өгөөрэй гэж хүсэх байна.

Нэг хүсэлт байгаа нь дайвар бүтээгдэхүүн Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд банкны зээлийн жагсаалтад ороогүй байна. Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнүүд маань, үйлдвэрүүд маань хамгийн том экспорт хийх боломжтой өлөнгийн үйлдвэрүүд гээд. Энэ бол Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд зээлийн олгогдох ёстой, хамрагдах ёстой хүрээнд нь хамралгүй үлдсэн юм байна. Энийг та бас оруулж өгөх тал тал дээр нь анхаараач ээ салбарын сайдын хувьд.

Тэр Америкийн Ерөнхийлөгчийн тавьсан тарифтай холбоотойгоор хүмүүс их ярьж байна. Энэ чинь өөрөө их давуу тал болох гээд байгаа шүү. Манайх 10 хувийн л нөлөөлөлд орсон байгаа. Тэгэхээр манайхаар өмнө оёдлын үйлдвэрүүд дамжаад экспорт хийдэг байсан юм шүү.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Дэмжсэнд баярлалаа Мэндсайхан сайд аа.

Ховдынхоо паркийг оруулахаар баруун бүсийн арьс, шир, ноос ноолуур боловсруулалтад их томоохон ахиц гарчихна. Энэ бодлого ингээд явна. Одоо үйлдвэрүүд маань дэд бүтэц нь хийгдээд дуусахаар хувийн хэвшил маань хөрөнгө оруулалт буюу Цагаан алтанд хамрагдаад ингээд явах ёстой.

Ер нь энэ Цагаан алтанд батлагдаж байгаа эх үүсвэр 66 тэрбум төгрөг чинь л өөрөө ноолуурын зээл, хөрөнгө оруулалт, энэ үйлдвэрийн хүчин чадлыг нэмэх гээд энэ бүх зүйл рүү яагаад ч үнэхээр л хүрэлцэхгүй байна. Одоо 26 оны төсөв дээр анхаараад энэ үнэхээр хувийн хэвшил маань урам зориг ороод хөдлөөд эхэлчихсэн. Хүнсний хувьсгал дээр ямар их ололт, амжилт гарав. 30, 40 шинэ үйлдвэр орлоо, 300 гаруй шинэ төрлийн хүнсний бүтээгдэхүүн шинээр бий болж гарч ирж байна. Одоо энэ ноос, ноолуур, арьс ширээ хөдөлгөчих бололцоо бас таатай гадаад орчин үүсээд ирлээ. Атрын-4 дүгээр аян гээд газар тариалангаа дэмжих, мал аж ахуйн эрчимжсэн аж ахуйг дэмжих том бодлого эхэлчихлээ. Одоо энэ чинь ингээд бүгд хоорондоо хоршоо бодлоготойгоо нийлээд ингээд цогц болж хувирч байна шүү дээ. 4-н цогц бодлого. Энийг л алдахгүй бид нарт 3 жил байна. Ингээд явчихад 28 он гэхэд энэ хамгийн их ажлын байр олгож байгаа, хүн нутаг орондоо ажиллах, амьдрах орчныг бүрдүүлж байгаа энэ салбар хөөрхөн босчихно. Бодитой үр дүнтэй энэ чинь. Энэ чинь энэ хамтарч эвссэний гол үр дүн энэ салбар дээр их бодитой гарна шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгээд Завхан дээр бид нар ахиж судалгаагаа хийе. Үнэхээр Завхан дээр тэр уур, үйлдвэрлэлийн уурын бололцоо үнэ хөлс нь яаж гарч байгаа бол, тэн дээр та бололцоо гарвал бас энэ хүрээнд хамруулах бололцоотой. Энэ чинь 3 жил, 4 жил үргэлжлэх хөтөлбөр шүү дээ. Энэ дээр бүгдээрээ нэмээд нэмээд ингээд ингээд явчихъя. Тэр зээл нэмэх л асуудал бай.../минут дуусав./

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн тодруулъя.

З.Мэндсайхан: Тэр зээл нэмэх асуудал дээр та бас онцгойлон анхаарчих хэрэгтэй байна. Ядаж 400 тэрбумд хүргэмээр байна. Тэр Евроазийн хэлэлцээр дээр арьс ширний асуудал маань хаягдаж болохгүй, ноосны асуудал маань байгаа. Тэгэхээр бид нар энэ дээр Хөдөө аж ахуйн яам маань бүүр манлайлж оролцох ёстой шүү. Тэр Евроази энэ дэлхийн хооронд болоод байгаа дайн тулаан дуусна. Энэ хөрш маань мөнх байна. Энэ том зах зээлийг бид нар ийм цаг үеийн шинжтэй асуудал дээр урсгалаар хандаж энэ том боломжийг алдаж болохгүй ээ гэж хэлж дахин хэлмээр байна.

Юун дээр гурилын экспорт гэж юм байгаа. Бид нар газар Хятадуудтай тарифыг нь тохироод хорио цээрийн нөхцөлийг нь тохирчихсон. Энэ жил газар тариалангаа дэмжихийн тулд улаан буудайн тогтвортой үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд энэ гурилын экспорт талдаа та бүгд маань бас бэлэн тэр шийдсэн гарцаа ашиглаач. Тариалалтаа нэмэгдүүлэхэд дагаад экспорт маань нэмэгдэх. Бид хүнсээ экспортолмоор байна шүү дээ. Энэ дээр би бас сайдыг анхаараач ээ гэж хүсэх байна. Өөр зүйлгүй.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Ойлголоо Евроазийн холбооны хөнгөн үйлдвэрийн салбарын боломж дээр нэлээн сайн ажиллаж байгаа.

Гурилын асуудал буюу улаан буудайн асуудал сезон эхэлсэн. үндсэндээ ингээд 14 хоногийн дараа тариалалт эхэллээ. Бейсен дарга бодлого тодорхойгүй байна, тариаланчид хүлээж байна. Улаан буудай тарих уу, тарихгүй юу. Дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадал 100 хувь тарьж 100 хувь дотроо хангадаг байсан одоо 60 хувь болсон. 40 хувийн уналт хийсэн. Энэ бодлогын асуудлыг шийдэхгүй бол ахиад уналт хийнэ. Ийм нөхцөл байдлын эсрэг бид бусад таримал, бусад шинэ таримлууд, экспортын үр тарианы асуудал дээр нэлээн ажлууд гэрээ, хэлцлүүд хийж байна. Улаан буудай стратегийн бараа шүү. Дэлхийн улс орон болон яг хүнсэндээ анхаарч, нөөц дээр бодлого төвлөрүүлж байгаа энэ цаг үед бид.../минут дуусав./

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя. 6 номер.

Ж.Энхбаяр: Онцгой цаг нь тулчхаад байгаа улаан буудайн энэ тариалалтын асуудал дээр бодлогын шийдлийг яаралтай гаргаж өгмөөр байна Бейсен даргаа. Намар өргөн барьсан одоо болтол таг. Сая сар гаруй хүлээлээ хойшлоод л байна. Хугацаа алдвал нөхөж болдоггүй хугацаа. 5 сарын тариалалт алдвал 6 сар тарина гэж байх бололцоогүй ингээд дуусаа. Намар бид нар бусдаас гурил, улаан буудайгаа гуйна гэсэн үг. Хүнсээ бусдаас гуйна гэдэг чинь нөгөө аюулгүй байдал, тусгаар тогтнол маань суларна л гэсэн үг шүү дээ. Дэлхийгээрээ хүнсэнд анхаарч

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байна. Энэ дээр Байнгын хороо онцгой асуудал тавьж шийдэл гаргаж өгөөч ээ, авч хэлэлцээч ээ. Яагаад саатуулаад байгаа юм бэ, яагаад энэ хойшлуулаад байгаа юм бэ? Тариаланчид хүлээж байна шүү дээ. Улаан буудай тарих уу, болих уу гэж.

Евроазийн хэлэлцээр дээр улаан буудайг татвартай байх нь гэдэг дээр 2 талд тохирсон ийм сурагтай байна. Гэтэл бид яагаад ийм байдалтай байгаа вэ?

Б.Бейсен: Улаан буудайн асуудал 2 дахь асуудал дээр ярина. Тэгэхдээ бид түрүүн Дарханд очоод тариаланчидтайгаа бас уулзсан, Хөдөө аж ахуйн яамныханд уулзсан. Тэр тариалалт буурчихсан, гурилын импортын татвартай холбож ярьж байгаа. Гэтэл би энд ирээд даргын дэргэдэх зөвлөлийн хурал дээр бас танилцуулсан. Одоо ингээд Байнгын хороон дээр танилцуулж байна. Тариалалт 57 хувиар буурчихсан гээд яриад байгаа.

Нөгөө талаар тариаланчид маань бас гурилын үйлдвэр 10 хэдэн гурилын үйлдвэрээс 6, 7 нь ажиллаж байгаа юм. Бусад нь хаалгаа барьсан гээд ярьж байгаа. Энэ асуудлыг бас бид дахиж Их Хурлын юун дээр танилцуулж ярина.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Батжаргал гишүүн, Замира гишүүнийг нэмье. Мандхай гишүүнийг бас нэмье. Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Тийм ээ энэ Цагаан алт хөтөлбөрийг бид амжилттай хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Тэгэхдээ хэрэгжүүлэхдээ хэдүүлээ энэ нөхцөл байдлуудаа нэлээн сайн судалж, эрсдэлээ тооцож, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдээ авмаар байна. Тэгж байж энэ том бодлого нэлээн үр дүнтэй хэрэгжих ёстой. Улс орны эрх ашигт гэдэг юм уу, энэ үндэсний аюулгүй байдал талдаа яах аргагүй бид өөрийнхөө бий болгож чадаж байгаа тэр бүтээгдэхүүнүүдийг эцсийн бүтээгдэхүүн болгох тал руугаа чиглэж байж л сая анхдагч салбар, боловсруулах салбар 2 маань зэрэгцэж нэг нэгнийгээ нөхөж урагштай хөгжих бололцоо нь бүрдэх юм. Тэгээд энэ тал руугаа явах ёстой.

Гэхдээ бид том бодлого хэрэгжүүлж байгаа улсууд. Өмнөх нөхцөл байдлыг санагалзсан гэдэг юм уу тийм том нөлөөлөл байгаа гэдэг юмаа харгалзаж энэ дотоод эх үүсвэрийг маань нэмэгдүүлэх ёстой. Тийм учраас би Монголбанк, Засгийн газарт өнөөдрийн хуралдаанаас энэ валютын дотогшилтыг нэмэгдүүлэх, үнэ цэнтэй энэ бүтээгдэхүүнээ бүрэн хумьж авч, тэгээд боловсруулалт хийгээд экспортлох боломжоо хангасан хөрөнгийн эх үүсвэрээ нэмэгдүүл гэдэг юмыг л тов тодорхой өгмөөр байна. Энэ маш яаралтай шийдэх ёстой асуудал. Энэ бас тийм хүлээгээд байдаг зүйл биш.

Ер нь яг нарийндаа манай ноолуурыг угаалгаж аваад гаргаад өөрсдийнхөө эрх ашгийн төлөө тодорхой боловсруулалт хийгээд гаргаад байсан улсууд өөрсдөө боловсруулалт хийгээд эхлэхээр зэрэг жоохон дургүй нь хүрээд энэ шийдлийг жоохон буруу ойлголт өгүүлэх гээд оролдоод байгаа юм байгаа юм билээ. Би тэгж хараад байгаа юм. Тийм учраас энэ рүүгээ бид өөрсдөө онцгой анхаарч ажиллах ёстой. Европын холбоотой буюу тэр том үйлдвэрүүдтэй тэр тогтвортой ноос ноолуурын холбоогоор нь дамжуулж маш сайн ажиллах ёстой.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгж байж хэдүүлээ энэ бүтээгдэхүүнээ тэр рүү чиглэсэн тэр урсгалыг нь улам нэмэгдүүлэх ёстой гэдэг ийм байр суурьтай байна.

Хоёр дахь зүйл бол яах аргагүй энэ улаан буудайн асуудал дээр бид тодорхой шийдэх шийдэл байгаад байгаа. Тэр ноднин гурил тэжээлийн импортын гаалийн татвар тэглэхсэнтэй холбогдоод тариалалт чинь 20 гаруй хувиар буугаад, үйлдвэрлэл чинь бараг 30-аад хувиар буурчихсан ийм л дүр төрх байгаа. Энэ жил цаашаагаа нэлээн өргөжөөд явчхаж мэднэ.

Тийм учраас үүнийг хэдүүлээ засаж авах ёстой. Засгийн газар албан ёсоор өргөн барьчихсан юм билээ. Тийм учраас Төсвийн байнгын хороо, Хөдөө аж ахуйн байнгын хороо 2 энэ рүүгээ гол анхаарлаа хандуулж, энэ асуудлыг шуурхай хэлэлцэж, нэг талд нь гаргаж авч энэ тариаланчдыг ямарваа нэгэн тийм хүлээлт гэдэг юм уу, тодорхойгүй байдалтай нүүр тулгахгүйгээр урам зоригтой хаврынхаа тариалалтын ажил руу орох бололцоо, боломжийг нь бүрдүүлмээр байна. Хөдөө аж ахуйн яам маань энэ үрийн хангалт тал дээрээ нэлээн анхаарах ёстой гэж ойлгоод байгаа би. 295 мянган га-гийн тарих үр л бидэнд байгаад байна шүү дээ. 360 мянга хүргэж тарина гэж ярьцгаагаад байгаа. Тийм учраас энэ 70 орчим мянган га-д тариалалт хийх үрийнхээ хангалтыг хиймээр байна.

Дээр нь тэжээлийн тариалалт 140 хэдэн мянган га-д тарина гээд байгаа. Энэ чинь 24 орчим мянган тонн үр хэрэгтэй. Тэгээд одоо бидэнд байгаа үр чинь ер нь нэлээн бага л байгаад байна шүү дээ. Тэгээд хэдүүлээ үүнийгээ яаж бүрэн нөхөх вэ гэдэг асуудал. Тийм учраас тэр ашигт таримлыг нэмэгдүүлэх асуудал бол бидний хамгийн гол зүйл. Гэхдээ баталгаатай үрийн хангалтын асуудлаа бүрэн шийдэх ёстой. Энэ талынхаа асуудлыг би Хөдөө аж ахуйн яамыг гол анхааралдаа авч, зохицуулалт юмнуудаа хийгээрэй гэж.../минут дуусав./

Б.Бейсен: Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Баярлалаа. Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Энэ Цагаан алт хөтөлбөрийг дэмжиж байна л даа. Харин 2 асуудал дээр анхаарах хэрэгтэй байна.

Нэгдүгээрт малчдын гарт байгаа түүхий эдийг, ноолуурыг зах зээлийн ханшаар авах ёстой. Яагаад гэвэл 1 жилийн дотор ингээд өр, зээлд, малчид зохих хэмжээгээр өр, зээлд баригдсан байдаг шүү дээ. Тэрийг тэрүүгээр хаадаг юм. Тийм учраас тэрийг сайн судлаад баруун бүсэд ямар ханшаар юугаа авах юм, зүүн бүсэд ямар ханшаар ноолуур цуглуулах юм гээд энэ дээр баримжаалал байх ёстой байх яаман дээр. Энэ дээр энийг анхаарна уу сайд аа.

Хоёрт болохоор манай Монгол орны ноолуурын үйлдвэр маш сайн хөгжсөн байгаа. Утас болгоод, ээрмэл болгоод ингээд гадаад руу экспортлох биш эцсийн бүтээгдэхүүн гаргаад тэрийг экспортод гаргах тал дээр анхаарах зүйтэй. Тэгвэл бүр таны хэлснээс 10 дахин үнээр бид нар улс эх орноо валютаар хангах боломж олдоно.

Гуравдугаарт ингээд газар тариалангийн үе эхэлж байна. Улаан буудайн асуудлыг яаралтай шийдэх хэрэгтэй. Техникийг өнөө маргаашдаа хийгээд суух

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шаардлага байхгүй. Энийг Их Хурал, Байнгын хороо анхааралдаа авч энийг яаралтай шийдэж өгөх нь зүйтэй. Баярлалаа. Амжилт хүсье.

Б.Бейсен: Мандхай гишүүн үг хэлье.

М.Мандхай: Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан 42 дахь, 42 дугаар ажлын хэсгийн хүрээнд бас яг энэ хөдөө аж ахуйн бас чухал асуудал болох энэ Цагаан алт хөдөлгөөн угаасаа бас бид манай ажлын хэсэг бас хариуцаад үйл ажиллагаанд нь эрчимжүүлэхэд бас дэмжиж ажиллаж байгаа. Тийм учраас энэ Цагаан алт хөдөлгөөнийг явуулах нь зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа. Ер нь дэмжиж ажиллаж байгаа.

Гэхдээ яг энэ ажлын хэсгийн хүрээнд ч гэсэн уулзалтаар ингээд холбогдох байгууллагуудаас мэдээлэл авахлаар ерөөсөө хамгийн чухал асуудал бол энэ одоо хэрэгжиж байгаа төслүүдийнхээ уялдаа холбоог хангаач ээ гэдэг асуудлыг зайлшгүй тавьж байгаа. Тэрний нь 1 болохоор энэ байгуулагдчихсан байгаа 6300 хоршоо, 22 мянган бараг энэ малчин өрх хоршооноос зээл аваад хамгийн гол асуудлын нь бид нар арьс шир, ноос, ноолуураар ингээд бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэхээр зээл аваад явж байгаа. Бид нарт зах зээлийг нь нээж өгөх шаардлага байна гэж байгаа.

Тэгэхээр зах зээл нь өөрөө дараагийн энэ Цагаан алт хөтөлбөрийн дараагийн дамжлага өөрөө байгаад байгаа юм. Гэтэл энэ энэ хөдөлгөөн маань 2 өөр байгууллага дээр харьяалагдчихсан. Ингээд уялдаа холбооны асуудал удаашралтай яваад байгаа учраас бие биеийгээ дэмжсэн ийм нэг нь түүхий эдээ бэлддэг, нөгөөх нь цааш нь аваад үйлдвэрлэдэг, тэгээд цаашаагаа зах зээлээ тэлдэг ийм ханган нийлүүлэлтийн дамжлагыг уялдаа холбоотойгоор хийхгүй бол ерөөсөө энэ хөдөө аж ахуйн салбарын чинь энэ хөдөлгөөн яваад, зээл яваад ер нь үр дүн байхгүй байгаад байгаа юм. Тэгэхлээр энэ хэрэгжиж байгаа энэ Шинэ хоршоо, Цагаан Алтын хоорондын уялдаа холбоог маш нягт болгож өгөөч ээ. Дараагийнх нь Хүнсний хувьсгал гээд том бас Атрын-4дүгээр аян гээд гэх мэтчилэн ингээд хөдөлгөөнүүд гараад эхэлчихлээ.

Хоёрдугаарт зах зээлийг нээж өгөөч ээ гэж байгаа юм. Өнөөдөр бас ч гэсэн уулзалтаар явж байхад ерөөсөө манай нийт энэ Цагаан алт хөдөлгөөний хамгийн чухал асуудал бараг 40-өөс 50 хувь нь зах зээл энэ борлуулалт, борлуулалтын асуудал байгаад байна. Би яаж энэ олон улсад гарч байгаа энэ загварын шоунд манай өөрийн гаргаж байгаа энэ бүтээгдэхүүнээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн өөрөө гардаг болох юм бэ? Бид яаж өөрийнхөө бүтээгдэхүүнийг олон улсад зах зээлд гаргадаг болох юм бэ гэхлээр ялт ч үгүй нөгөө олон улсын түвшинд Засгийн газар хоорондын худалдаа хэлэлцээрээр буюу энэ Евроази шиг энэ хэлэлцээрүүдээр зах зээлүүдийг нээж өгмөөр байгаад байгаа юм. Хэрэв зах зээлийг нь бид нар нээгээд өгөх юм бол яг энэ стандартад нь дагуу үйлдвэрлэл, технологийн паркууд болон одоо байгаа үйлдвэрүүд өөрсдөө хүчин чадлаа энэ зээлээрээ дамжуулж аваад ингээд энийг нь түүхий эдийг нь бэлдэж өгдөг тогтвортой нийлүүлэлтийг хийх боломж нь өөрөө шинэ хоршоогоор дамжих боломж байгаад байгаа юм. Гол нь гарц байгаа юм.

Тэгэхлээр энд нэгэнт эхэлчихсэн байгаа хөдөлгөөнүүдийг уялдаа холбоог нь хангая. Хоёрт нь бид нар зах зээлүүдийг нь маш сайн тэлж өгөх хэрэгтэй байна. Тэгээд энэ үйлдвэрлэл, технологийнхоо паркуудыг яаравчилж энэ дээр яам бүр

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бас үнэхээр хариуцаж ажилламаар байгаад байгаа. Жишээлбэл, Нийслэл рүү Эмээлт нь оччихсон байдаг. Дэд бүтцийг нь их хэмжээний бараг 70-аад тэрбум төгрөгөөр дэд бүтцийг нь байгуулах ингээд нийслэлийн асуудал болчихсон. Бусад ингээд технологийн паркууд нь бас яг яам дорвитой хариуцаад ажиллаж байгаа юм уу? Энийгээ ингээд нээгээд ажиллах юм бол энэ Цагаан алт хөтөлбөрийн чинь олгогдсон зээл өөрөө үр дүнтэй болно. Илүү эрчимжих ийм гаргалгаа харагдаад байгаа гэдгийг хэлмээр байна. Тэгээд энэ уялдаа холбоог сайн анхаарч ажиллаарай. Зах зээлүүдийг тэлж ажиллаарай тэгээд Байнгын хороотойгоо бас хамтраад бид нар бас энэ гадагшийгаа гарах зах зээлүүд дээр нэлээн боломжуудыг бас хамтарч хайхад бас дэмжиж ажиллахад бэлэн байна гэж хэлмээр байна. Баярлалаа.

Б.Бейсен: Батболд гишүүн үг хэлье.

Р.Батболд: Байнгын хорооны дарга би гол нь ганц 2 асуулт асуугаад хариулт авчих гэсэн юм болж байна уу болох уу? Та түрүүн хэлээд байсан шууд хаачихлаа. Би энэ Цагаан алттай холбоотой л ганц, хоёрхон асуулт асуучих гэсэн юм. Та шууд хаачихлаа шүү дээ наадхаа. Асуулт асууж болох уу?

Б.Бейсен: Үгээ хэлж байгаад асуулт яачих.

Р.Батболд: Юу яриад байгаа юм бэ би асуучхаад гарах гээд байхад чинь. Үгүй ээ би, бид нар чинь Хөдөө аж ахуйн яаман дээр очоод ажилласан юм. Тэгээд тухайн үед би асууж байсан энэ яах вэ үйлдвэрлэлээ хөгжүүлэх гээд байна. Цагаан алт хөтөлбөрийг дэмжиж байгаа. Үйлдвэрлэлээ хөгжүүлэх ёстой, бид нар боловсруулах ёстой. Тэгэхдээ эргэлтийн хөрөнгийн зээл аваад байгаа энэ аж ахуйн нэгжүүд чинь дахин давтан зээл аваад байгаа байх. Эднийхээ санхүүгийн боломжийг нь сайжруулах энэ тал дээр ер нь ямар ажил хийгээд байгаа юм бэ гэж би асуусан. Тэр судалгааг нь ирүүлье гэсэн одоо хүртэл л байхгүй байгаа. Тэгээд хэчнээн үйлдвэр ер нь энэ түүхий эд бэлтгэхэд зориулаад эргэлтийн хөрөнгө аваад байгаа юм? Энэ хэчнээн хэмжээний зээл гараад байгаа юм? Одоо бид нар чинь зээлийн хөнгөлөлт гэж энэ зүгээр татвар төлөгчдийн мөнгийг л өгч байгаа шүү дээ. Энэ ер нь нийтдээ хэчнээн төгрөг гарчхав аа? Энэ 17, 8 оноос явсан ажил байгаа байх. Ер нь яг хэчнээн төгрөг бид нар зээлийн хүүгийн зөрүүнд өгчхөөд байгаа юм? Тэгээд энэ эргэлтийн хөрөнгө авч байгаа аж ахуйн нэгжүүд чинь ер нь санхүүгийн хувьд өөрсдөө ч гэсэн сайжирчихъя гэж бодож байгаа юм уу, бодохгүй байгаа юм уу? Энэ зээл өгөхдөө ч гэсэндээ энэ ирэх жилээс 5 хувь бууруулна шүү, 10 хувь бууруулна шүү гэдэг юм уу ийм бодлоготой ийм зээлийн гэрээ хийдэг юм уу, үгүй юү? Энийг хариулаад өгөөч.

Б.Бейсен: Асуулт, хариултыг түрүүн тасалсан болохоор Энхбаяр сайд албан ёсны бичгээр Батболд гишүүнд хариу өгөх үү?

Р.Батболд: Яаманд яаман дээр ингэж хэлээд л явсан шүү дээ. 10 хоног хаана байгаа юм бэ?

Б.Бейсен: Хоёр дахь асуулт асуух үед нь дахиад л яагаадахъя.

Гишүүд үг хэлж дууслаа. Сайдын мэдээллийг сонссонтой холбоотой Байнгын хорооны тогтоол гарах юм. “Засгийн газарт чиглэл өгөх тухай”,

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Байнгын хороо юу Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороонд тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг хэлэлцээд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ, Монголбанк Лхагвасүрэн нарт чиглэл болгосугай.

Малчдаас зах зээлд нийлүүлэгдэх түүхий ноолуурыг 100 хувь худалдан авах ажлыг яаралтай зохион байгуулах.

Хоёрдугаарт, шаардагдах хөрөнгийн эх суурийг банкнуудын чөлөөт эх суурийг ашиглах замаар зохион байгуулах.

Хоёрт, энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хөдөө аж ахуйн Байнгын хороонд 2025 оны намрын чуулганы хугацаанд багтааж танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ, Монголбанкны Ерөнхийлөгч Лхагвасүрэн нарт үүрэг болгосугай.

Энэ тогтоолын хэрэгжилтийг хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Бейсенд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой үг хэлэх гишүүд байна уу? Санал хэлэх.

Мэндсайхан гишүүнээр тасаллаа. Мэндсайхан гишүүнээс асууя.

3.Мэндсайхан: Бейсен дарга тэр ноолуурыг 100 хувь худалдан авахыг Засгийн газарт гэдэг чинь арай жоохон болохгүй байх. Тэрийгээ юу гэдэг юм, хаврын ноолуур бэлтгэлийг хөнгөн үйлдвэрүүдийг дэмжих энэ бодлогоо арилжааны банкнуудын зээлийг нэмэгдүүлэх зорилгоор ч гэдэг юм уу арай жоохон өөр утгаар, болохгүй бол ноолуурыг 100 хувь худалдаж авахыг Засгийн газарт үүрэг болгох ч бас арай байж болохгүй байх.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүний саналыг авъя. Энэ тогтоолын төсөлд тусгая. Ноолуурыг нэмэгдүүлэх, худалдан авах гээд л өөрчлөөд оруулъя. Тогтоолын төсөлд засвар хийе.

Өөр саналтай гишүүн байхгүй юу тээ? Тогтоолын төслийг батлах уу? Санал хураалт явуулъя.

Тогтоолын төсөл 53.3 хувиар батлагдлаа. Дараагийн асуудалд оръё.

16.05 цаг

Хаврын тариалалтын бэлтгэл ажил, “Атар-4 дүгээр тариалангийн тогтвортой хөгжил ая”-ны талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсоно.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж ирсэн түрүүн ажлын хэсэг хэвээр байгаа. Сайд мэдээллээ танилцуулъя. 6 дугаар микрофон.

Ж.Энхбаяр: Атарын-4 гэж томьёолсон хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах энэ бодлого батлагдаад өнгөрсөн долоо хоногт Дархан-Уул аймагт салбарын зөвлөгөөн хийж Атрын-4 дүгээр аяны үйл ажиллагааг албан ёсоор эхлүүллээ.

Атрын-4 дүгээр аяны гол зорилт бол газар тариалан, мал аж ахуйн төгс хослолыг бий болгох. Хүнс, хөдөө аж ахуйг эдийн засгийн тулгуур салбар болгон хөгжүүлнэ гэсэн энэ зорилтыг тавьж байгаа. Энэ хүрээнд 5 бодлогын зорилт, 12 тэргүүлэх чиглэл, 63 хэрэгжүүлэх арга хэмжээ 4 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр төлөвлөгөө үндсэндээ ингээд гараад байна.

Нэгдүгээрт, хөрс хамгааллын бодлогыг онцгой анхаарах хэрэгтэй болсон. Нийт газар тариалан, газрын үржил шим нэлээн багассан. Зайлшгүй хөрс хамгаалалтыг сайжруулахгүй бол цаашдаа ургац тогтвортой авахад сөрөг ийм нөлөөлөл гарч байгаа судалгаа бий болсон. Энийгээ бид тэрбум үндэсний хөдөлгөөнтэй хосолж, газар тариалангийн болон ногооныхоо газрыг ойн зурвасаар бүрэн салхины хамгаалалтад авах нь чухал гэдэг ийм бодлогыг хэрэгжүүлэхээр эхний зорилт болгож байгаа.

Ингэснээр ойн зурвас бүхий талбайн ургац 25 хувь хүртэл нэмэгдэж байгаа ийм тооцоо гарч байгаа. Үр сортын механикжуулсан үтрэмүүдийг сайжруулж, ажиллах хүчний хомсдол бий бий болсон энэ цаг үед үтрэмийн ажлыг механикжуулах хураасан үр тарианы чанарыг үйлдвэрүүдэд чанартай улаан буудай нийлүүлэх үүднээс энэ механикжсан үтрэмийн хүчин чадлыг нэмэх ёстой. Энэ бодлогын хүрээнд ид тэлэгдсэн үр үржүүлгийн 7 аж ахуйг хөгжүүлж дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Сорт сорилтын 4 төв энэ бодлогын хүрээнд бий болж ажиллана. Нийтдээ бид нар зуур 100 мянган тонн хүчин чадлаар үтрэмийнхээ хүчин чадлыг нэмнэ.

Нөгөө талаас ургамал хамгаалал дээр нэлээн том бодлогын ажлууд эхэлсэн. Хэрэгжүүлэгч агентлаг Ургамал хамгааллын газар байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлээд явж байна.

Нэгдүгээрт энэ байгууллага маань талбай дахь, бэлчээр дэх хог, ургамалтай тэмцэх, ургамлын өвчинтэй тэмцэх, ургамлын хөнөөлт шавжтай тэмцэх, мэрэгч амьтантай тэмцэх, хөрсний өвчлөл буюу хөрс хамгаалал гэсэн энэ бодлогын ийм арга хэмжээнүүдийг энэ хүрээнд бодлогын ажлууд хийнэ. Мөн шинжлэх ухаан технологийн шинэ инновац нэвтрүүлэлт дээр онцгой анхаарч, ухаалаг хөдөө аж ахуй, ухаалаг фермерийг хөгжүүлэх түүнд шаардлагатай техник, цахим тэр платформ, программ хангамжийн хөгжүүлэлтүүд, инновацийн нэвтрүүлэлтүүдийг хийхээр тусгасан байна. Мөн хүний нөөцийн асуудал онцгой чухал байгаа. Яаралтай, техникийн мэргэжилтнийг бэлтгэх, ялангуяа орчин үеийн автоматжуулалт, робот ашиглах ур чадвар бүхий боловсон хүчнийг, шинэ үеийн тариаланчдыг бэлтгэх, шинэ үеийн фермерээр бэлтгэх ийм зайлшгүй шаардлага үүсэж байгаа. Энэ хүрээнд их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг яаралтай шинэчлэх, технологийн чиглэлээр нь сурч байгаа залуучуудад орчин үеийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, лабораториор хангах ийм зайлшгүй шаардлага, нөгөө

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

талаар хүүхэд залуучуудаа энэ хөдөө аж ахуйд дур сонирхолтой болгох ийм бодлогын арга хэмжээг авна.

Мөн хөдөө аж ахуйн салбарын эрсдэлийн менежментийг иж бүрэн шийдэхээр зорьж байгаа. Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөдөө аж ахуйн даатгал, үүн дотроо тариалангийн даатга, мөн хариуцлагатай тариаланч, мөн эрсдэлээс урьдчилан сэргийлэх экспорт, импорт, хорио цээр, тэр гэрээ, протоколуудаар дэмжинэ гэсэн ийм эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлогууд хэрэгжүүлэхээр бэлдэж байна.

“Атрын-4 дүгээр ая”-ны хүрээнд ямар арга хэмжээ ямар үр дүн хүлээгдэж байна вэ гэж.

Нэгдүгээрт, хөдөө аж ахуйн төрөлжсөн аж үйлдвэрлэлийн дэд бүс гэж төвийн бүсийг зарласан. Энэ хүрээндээ 200 мянган толгой мах, сүүний ашиг шимт үхэр сүргээр сүргийн сэлбэх сайжруулалтыг хийх хэрэгтэй. Ийм шаардлага гарч байгаа. Ингэснээр нэгдүгээрт экспорт, хоёрдугаарт дотоод махны, төв суурин газрын махны хэрэглээ болон сүүний хэрэгцээг бүрэн хангах ийм чадавх бүрдэнэ гэж үзэж байгаа.

Усалгаатай газар тариаланг хөгжүүлэх 20 мянгаас доошгүй га талбайг усжуулах, толгойн барилгуудыг шинэчлэх, суваг шуудууг сайжруулах, шинэ усалгааны систем, агрегатуудыг нь оруулж ирэх ийм зайлшгүй шаардлага байгаа. Энд 20 мянган га гэсэн тооц тоо байгаа. Хөдөө аж ахуйн техникийн шинэчлэлийг нэлээн эрчимтэй 100 хувьд хүргэх зорилт тавьсан. Үр тарианы салбар үндсэндээ 80 гаруй хувиар үндсэндээ шинэчлэгдээд амжилттай хэрэгжээд явж байна.

Одоо тэжээлийн таримлын техникийн шинэчлэл дөнгөж 1 хувьтай байгаа. Шинээр Монгол Улсад тэжээлийн олон уурагт буурцагт ургамлуудыг тарих ийм бололцоо бүрдэж байгаа тул тэжээлийн ургамлын техникийн шинэчлэлийг нэлээн сайжруулна. Хүнсний ногоо төмснийхөө хэрэглээг бид нар 100 хувь болгох, энд хүн хүч зарцуулалт ихтэй гар ажиллагаа нэлээн их байгаа. Энийг механикжуулах нь бүтээмж нэмэх, эрсдэлийг бууруулах ийм боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байгаа.

Хүлэмжийн өвөл, 4 улирлын хүлэмжийн аж ахуйг 50 га-гаар тэр тоо тэр барьж байгуулах ийм тооцоо гарсан. Одоо Монгол Улсын хэмжээнд 6 га өвлийн хүлэмж байна. 4 улирлын яг хамгийн орчин үеийн ...стандартын хүлэмж. Ийм хүлэмжээр бид нар 50 га хүртэл хөгжүүлж чадвал бид өдөр бүр хүлэмжийн нарийн ногоог төв суурин газрыг бүрэн хангах ийм бололцоо бүрдэнэ. Энэ дээр нийт 64 мянган тонн нарийн ногооны импорт гаднаас хамаарал их өндөр яваад байгаа, нэлээн олон тэрбум төгрөг гадагшаа алдагдаж байгаа юм байгаа юм.

Нэгэнт төмс, хүнсний ногоон дээр нэлээн ахиц гарч байгаа. Хураалтын түвшин сайжирсан ургац нэмэгдэж байгаа. Тэгэхээр хадгалах хугацаа, хадгалах өвлийн улирлын давах, ногоог боловсруулах ийм механикжсан агуулах зоориудыг нэмэх шаардлага байгаа. 100 мянган тонны хэрэгцээгүй дээр хүчин чадал өргөтгөх нь зүйтэй гэсэн ийм тооцоо, судалгаа хийгдээд явж байна.

Малын тэжээл тариалалт дээр онцгой анхаарч байгаа. Энэ Атрын-4 дүгээр аяны маань гол зорилго малын тэжээл тариалалт гэдэг их том бодлого орж ирнэ. Учир нь юу вэ гэвэл өнгөрсөн 2 жил баруун аймагт 5 орчим сая, тэрний саяын 23

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

он, 24 оны өвөл гэхэд бид нар 9.2 сая малыг үндсэндээ нүүдлийн мал аж ахуйгаас алдсан. Энийг гол эрсдэлийг зохих гол зүйл бол малын тэжээл тариалалт. Тэгэхээр тэжээлийн таримал, шинэ төрөл бүрийн ногоон тэжээл, вандуй, эрдэнэ шиш, наранцэцэг, тосны ургамал зэрэг энэ тариалалтыг нэлээн эрс нэмэгдүүлнэ. Энэ бодлогынхоо хүрээнд газар тариалангийн талбайг 200 мянган гагаар нэмэгдүүлэх гэсэн ийм томоохон зорилт тавьж байгаа. Нэг талдаа газар тариалангаа эрчимжсэн гахай, тахиа, сүү, үхэр эрчимжсэн аж ахуйтайгаа хослуулъя. Мөн нүүдлийн мал аж ахуйгаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх гол нөхцөл бол малын тэжээл тариалалт юм гэж үзэж байгаа.

Энэ Монгол Улсын хэмжээнд гол газар тариалан явагдаж байгаа мужлалын зураг байна. Үндсэндээ Дархан, Сэлэнгэ, Төв, Булган гэсэн үндсэнд байгаа газар тариалангийн гол бүс нутаг энд оршиж байна. Өнөөгийн байдлаар 962 мянган га талбайд тариалалт хийгдэж байна. Энэ газар нутгийн 0.6-хан хувийн хэмжээнд тариа таригдаж байгаа. Дэлхийн хөгжилтэй орнууд хамгийн багадаа ер нь 30хувиас дээшээ газар нутгийнхаа хэмжээнд газар тариаланг тариалалт эрхэлж байгаа ийм тоо статистик байна. Бид 0.6 хувь дээр нь л ажиллаж байна.

Нөгөө талаар бидний нөөц бас хязгаарлагдмал. Тэлээд тэлээд бид газар нутгийн 3 орчим хувьд л Монгол Улсад юм тарих, ургуулах, болц нь гүйцэх ийм бас цаг уур хөрсний боломж байгаа. Тэгэхээрээ бидэнд 3 хувь хүрэх тийм боломжтой гэдгийг бас бас мэдээлэл маягаар өгье.

Атрын-4 дүгээр аяны хэрэгжилт, санхүүжилт яаж шийдэгдэж байгаа мөн арилжааны 10 банк болон Монголбанктай хамтын ажиллагааны гэрээгээ хийгээд холбогдох эх үүсвэрүүд бодлогын арга хэмжээнүүд хэрэгжиж эхэлж байна. Газар тариалангийн үйлдвэрлэлд энэ жил 345 тэрбум, хүнсний үйлдвэрлэлд 270 тэрбум, мал аж ахуйн үйлдвэрлэл 185. Ингээд 800 орчим тэрбум төгрөгийн зээл. Мөн адил Цагаан алт хөтөлбөрийн адил батлагдсан эх үүсвэр 52.8 тэрбум төгрөгийг бид нар арилжааны банкнууд, Монголбанктай хэлэлцэж тохирсны дагуу зээлийн урамшуулалд өгч байж цаашаа 800 тэрбумын хөнгөлөлттэй зээл энэ салбарт очиж байгаа. Бодлого ингэж хэрэгжинэ. Энэ дотроо яаж задарч байна гэдгийн талаар ингээд бүрчлэн гаргасан. Ингээд үр тариа, тос, тэжээлийн үйлдвэрлэл дээр ингэж жишээлбэл 100 тэрбум, гурил тэжээлийн үйлдвэрүүд 120 тэрбум, хөдөө аж ахуй, техникийн диллерүүдэд 50 тэрбум, эрчимжсэн мал аж ахуй эрхлэхэд 30 тэрбум, сүү боловсруулах үйлдвэрүүдэд 20 тэрбум, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мөөгний үйлдвэрлэлд 35 тэрбум гэх мэтчилэн ингээд бүх салбар салбар, чиглэл чиглэлээр хийгдэх ажлууд холбогдох тооцоо, одоо байгаа хүчин чадал дээрээ тулгуурлаад одоо хэрхэн алийг нь бид нар сайжруулах вэ гэдэг талаар яам ийм бодлого гаргаад энэ эх үүсвэрүүдээ арилжааны банканд өгөөд арилжааны банк нь цаашаа ингэж зээлийн судалгаа хийгээд зээл олголтын ажил ид явагдаж байна. Энэ мөн адилхан ингээд махны аж ахуй, өсвөр үхэр, өсвөр мал бордох, сүүний үхэр, зөгийн аж ахуй, шувууны аж ахуй, малын тэжээлийн үйлдвэрлэл гээд үйлдвэрлэл болгон ингээд хийх салбар болгон ингээд тодорхой эх үүсвэртэй, тодорхой зорилготойгоо ингээд задарсан байгаа.

Ингээд бэлтгэл ажлын хүрээнд энэ жил улаан буудай 310 мянган тонн улаан буудайн тариалалт явуулахаар зорьж байгаа. Хэрвээ улаан буудайн гурилын татварын асуудал шийдэгдэхгүй бол энэ багаар бодоход 100 мянган гагаар унах ийм эрсдэл үүсэж байгаа. Иймд эн тэргүүнд энэ жилийн тариалалтыг тогтвортой явуулахад бид нар энэ улаан буудайн ногдуулсан татварын асуудлыг нэг мөр

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шийдэх зайлшгүй шаардлага үүсэж байна. Төмс дээр 20 мянган тонн, 20 мянган га-д төмсний тариалалт хийгдэнэ. Хүнсний ногоон дээр 18.8 мянга хийгдэнэ. Энэ бараг 20 мянга хүрчих биз дээ. Энэ жил ногоон дээрх өсөлт их өндөр явж байна. Тэжээлийн ургамал буюу түрүүний ярьдаг мал аж ахуйг эрсдэлээс гол сэргийлэх бодлого эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх гол суурь болсон тэжээлийн таримлыг бид нар 144 мянган га-д хүргэж тариалалтыг явуулна. Тосны ургамал 103 мянган га-д хүрч таригдана. Жимс, жимсгэнэ 8000 га-д, бусад төрлийн үр тариа 35.6 мянган га-д тариалагдана. Нийтдээ 655.5 мянган га-д таригдаж 1.5 сая тонн ургац авна гэсэн ийм зорилттой. 245 мянган га талбай уринш боловсруулалтад буюу талбай өнжих нь. Ийм бэлтгэл ажил үндсэндээ техникийн болон үрийн, бордооны ургамал хамгааллын болон аж ахуйн нэгжүүд үндсэндээ бэлтгэлээ базаагаад салбар нэгдсэн тариаланчдынхаа зөвлөгөөн бүх бодлогуудаа хийгдээд дууссан. Зээлүүд аж ахуйн нэгжүүд дээр очиж байна. Одоо тулгамдсан асуудал энэ татварын асуудал маш их хүлээлт үүсгэж байгаа ийм байдалтай байна.

Газар тариалангийн салбарт үзүүлж байгаа энэ Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд бид бас газар тариалан ногооныхоо талбайг ой модоор ойн зурвас байгуулах ийм ажлыг хийнэ. Нийт энэ жил 102км ойн зурвасыг 2 аймгийн нутаг дэвсгэрээр дамжин байгуулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд талбайг нүүдлийн мал аж ахуйгаас тусгаарлах, эрсдэлийг бууруулах үүднээс бас 325 мянган ширхэг хашааны шонг газар тариалан ногоочид нийлүүлэх ийм ажил хийгдэж байна. Мөн жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг хийх Дархан-Уул аймгийн Орхон суманд жимсний эх цэцэрлэгийг байгуулах энэ ажил мөн энэ бодлогын хүрээнд хийгдэж байна. Газар тариалангийн салбарын мэдээлэл ийм байдалтай байна.

Б.Бейсен: Энхбаяр сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Идэрбат гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Атрын-4 дүгээр аян, тариалангийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажлууд зохион байгуулагдаж эхэлсэн. Авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд нэлээн гайгүй байгаа. Өмнөх он жилүүдэд хэрэгжиж явсан тэр нэмэгдсэн өртгийн албан татварын импортоор орж ирж байгаа бүтээгдэхүүнүүдэд тэглэж байсан заалт байхгүй болчихсон. Хуулийн үйлчлэл дуусчихсан. Энэнтэй холбогдуулж Хөдөө аж ахуйн яам, Засгийн газраас ер нь ямархуу асуудал боловсруулж байна вэ гэдэг асуудал. Улсын төсвийг батлах үед бид гаалийн татварын асуудлыг нь дан дамаа газар тариалангийн үйлдвэрлэлийнхээ гол техник хэрэгслүүдийг нэр зааж байгаад 5 жилийн хугацаатай чөлөөлчихсөн. Энэ нэлээн техникийн шинэчлэл бүтээмж, нэмэгдүүлэлт. ер нь бас энэ хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүчний хомсдол үүсээд байгаа, тэгээд технологийн цаг хугацаатай ажлууд байдаг учраас үүнийг шийдвэрлэхэд нэлээн том дэмжлэг болно гэж ингэж харж байгаа. Нөгөө талд нь харин тэр нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн үйлчлэл 25 оны 1 сарын 1-нээс дуусчихсан. Үүнийг та хэд цааш нь яана гэж бодож байна уу гэж. Нэг ийм зүйл.

Хоёр дахь зүйл улаан буудайн үрийн асуудлаа 7 аж ахуйн нэгж дээр 4.5 орчим мянган тонныг импортолж оруулж ирэхээр гэрээ хэлцэл хийгдчихсэн юм байна. Үүнийг шуурхайлах тухай асуудал байна. Нэг.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хоёрдугаарт энэ аж ахуйнууд дээр байгаа үрийн баталгаажуулалт ер нь ямар түвшинтэй хийгдэв? Бид хэд чинь энэ намрын ахиу ургацын асуудал яах аргагүй баталгаатай, стандарт хангасан үрээр тариалах тухай л асуудал байгаад байгаа. Энэ дээр ер нь ямар юм байна уу гэж.

Хоёр дахь зүйл тэр малын тэжээлийн тариалалтын асуудал дээр үр ер нь яаж шийдэгдэж байна вэ? Дээр нь хэдүүлээ 103 мянган га тосны ургамал тариалаад байгаа хэр нь дотоодынхоо ганц үйлдвэрийг түүхий эдээр хангаж чадахгүй байгаад байгаа, сорт зөрөөд болж өгөхгүй байгаа. Тийм учраас тариаланчидтайгаа, уг үйлдвэртэйгээ энэ таримлын сэлгээнд яваад байгаа тосны ургамлын тариалалтыг үндэсний үйлдвэрээ түүхий эдээр хангах тэр сортыг нь тариалуулах чиглэл дээр ер нь яам ямар бодлогын зохицуулалт хийж байна вэ? Энэ ер нь ямархуу байдлаар асуудал шийдэгдэхээр байна? Ийм 3 зүйл дээр тодорхой хариулт авъя.

Б.Бейсен: 6 номер, Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Атрын-4 дүгээр аяны гол зорилго маань улаан буудайнаас гаднах бусад таримал, тэжээлийн таримал, тосны ургамлын тарилтыг эрс нэмэгдүүлнэ. Энэ маань бас хүнсний хувьсгалын зорилтод хангасан ургамлын тосоо дотооддоо хангах том зорилтыг биелүүлэх гол суурь маань энэ.

Нөгөө талаас эрчимжсэн мал аж ахуйг тэжээх буюу тосны ургамал, бусад тэжээлийн таримал нэмэгдээд ирэхээр нөгөө гахай, тахиа, шувуу, сүү, саалийн аж ахуйнууд ч хөгжих, хүчит тэжээл буюу уураг тэжээл бүрдэх ийм гол суурь нь ингэж хамт уялдаж явж байгаа юм. Энэ хүрээнд тэр дотоодод байгаа үндэсний энэ тосны үйлдвэрүүдэд түүхий эд нийлүүлсэн аж ахуйн нэгжүүдэд улаан буудайтай адилхан урамшуулал олох асуудлыг оруулж ирнэ. Тэгж хөшүүрэгдэж байж л бид нар явна. Нэгдүгээрт экспортоо хийе, мөн дотооддоо хангая. Гол зорилго нь юу вэ гэвэл дотооддоо тосоо хийгээд ирэхээр тэрнээс үүсэж байгаа шахац гэдэг маань манай нөгөө гахай, тахиа, шувууны гол тэжээл болно гээд маш олон салбарт ийм эерэг нөлөө үзүүлж байгаа тул энэ бодлогоо урамшуулна.

Үрэн дээр импортын 4, 5 мянга орчим тонн тиймээ, 4 аравны, 4 хэд хэд боллоо? Яг 5 шүү дээ тээ. 4.3 мянган тонны зөвшөөрөл авчихсан байна. Нийт 5 зөвшөөрөл гарсан. Тэгээд олон аж ахуй оруулаад ирнэ. Дотооддоо бид нар 5 мянган тонн үр намар бэлдсэн. Аж ахуйн нэгжүүд дээр өөрт нь 35 мянган тонн байна. Мөн бас үр үржүүлгийн бас 3, 4 томоохон аж ахуйн нэгжүүд дээр нийлүүлэх 6 мянга орчим тонн үр бэлэн байна. Энийг бид нар хөдөө аж ахуйн биржээрээ дамжуулна долоо хоног болгон үрийн болон таваарын будааны арилжаа хийгдэж байна. Улаан буудайн дээр, үрэн дээр яг эрсдэл гарахгүй ээ хангалттай гарчихна. Тэжээл дээр мөн үрийн нөөц бүрдүүлэх, ялангуяа шинэ таримлууд, шар буурцаг, эрдэнэ шиш, овьёос, арвай гэх мэтийн ургамлын тэжээлийн үрийн нөөцийг боломжийн хэмжээнд бүрдүүлж байна. Бид энэ тавьсан зорилтынхоо орд нэлээн гарчих байх. Аж ахуйн нэгжүүдтэйгээ ялангуяа тариаланчдынхаа холбоотой бүх бодлогоо уялдуулж дандаа хамтран тооцоо хийж яваад байгаа болохоор яг зөрүү их гарахгүй. Гол энд шийдүүлэх асуудал улаан буудайн импортын татварыг гурилын татварын асуудлыг нэг мөр шийдсэнээр энэ гол зангилгаа тайлагдах гээд байна гэдгийг л та бүхэн анхаарч өгөөч. Хөдөө аж ахуйн техникийн импорт НӨАТ чөлөөлөгдөж байсан. Энэ хүчингүй болсон. Уул нь бид энэ дотроо чадахгүй байгаа

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

зүйлээ хийхийн тулд орцуудын л, бүгдийг нь хөнгөлөөд татваргүй болгоод л баймаар байх юм.

Тэгээд гол ордог орц зүйлүүдээ л татвартай болгоод улам үнэтэй болгоод, дээрээс нь эцсийн бүтээгдэхүүн дээр нь эсрэгээрээ хамгаалалтыг нь авч хаяад ингээд гаднын хамааралд нөлөөнд оруулаад байх юм. Тэгээд энийг ийм бодлогын цогцоор нь Байнгын хороо минь авч үзээч. Цөөхөн хэдхэн төрлийн юм бид нар хийж бүтээж чадаж байгаа шүү дээ. Улаан буудайг бид нар тарихын тулд шатахуун, сэлбэг хэрэгсэл, бордоо, ургамал хамгааллын бодис бүгд импортоор авч байна. Татвартаа орж ирээд. Эцсийн бүтээгдэхүүн болохоор татваргүй болгоод гаднаас хямдхан оруулж ирээд арай гэж үйлдвэрлэсэнгээ бодлогоор цохиод байгаа ийм их ойлгомжгүй байдал. Энэ дээр дүгнэлт хийж, шийдэл гаргах л зайлшгүй шаардлага байх юм.

Технологи дээр энэ 7 номер хариулаад үрийн үр баталгаажуулалтын дээр.

Б.Бейсен: 7 номер хариулъя.

Д.Есөн-Эрдэнэ: Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ. Сайд бас сая хариулчихлаа. Үндсэндээ аймгийн аймгийн хөдөө аж ахуйн газар, хөдөө аж ахуйн тасгаар ингээд дамжуулаад улаан буудайн үрийн нөөц, хангамжийн судалгаануудыг авсан. Одоогоор аж ахуйн нэгж дээр 35 мянган тонн үр байна. Үүний бол бас технологийн намар хянан баталгаажуулалт хийгдсэн, одоо хянан баталгаажуулах энэ ажлуудыг бас хийгдээд явж байгаа.

Мөн улаан буудайн үр импортлохоор 7 аж ахуйн нэгж ингээд хүсэлт ирүүлсэн. 4.3 мянган тонны үрийн улаан буудайн ийм зөвшөөрөл олгосон. Нэмээд дахиад 3 аж ахуйн нэгж 700 мянган, 700 тонн үр уучлаарай импортлохоор ингээд зөвшөөрөл.../минут дуусав./

Б.Бейсен: 7 номер гүйцээж хариулъя.

Д.Есөн-Эрдэнэ: Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэргэд Үр сортын салбар зөвлөл гэж байдаг. Энэ салбар зөвлөлөөр 9 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл, судалгааны байгууллагын төлөөлөл, мөн ТББ-ын төлөөлөл гээд бас яамны төлөөлөл ингээд оролцсон ийм 9 хүний бүрэлдэхүүнтэй энэ үр сортын зөвлөл дээр шинээр тариалах, шинээр тариалж байгаа үрүүдийг оруулах, бүртгэлжүүлэх, баталгаажуулах энэ асуудлуудыг бас их оруулж ирж үр сортын зөвлөл дээр оруулж ирсний дагуу баталгаажуулаад Ургамал хамгааллын газраар дамжуулаад импортын мэдэгдлүүдийг ингээд олгож байгаа.

Б.Бейсен: Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: 3, 4 асуулт байгаа юм. Өнөөдрийн хаврын тариалалтыг эхлүүлэх үү яах вэ, буудай тарих уу тарихгүй юу гэдэг асуудлын углуурга нь нөгөө гурилын үнийн асуудал байгаа шүү дээ. Гурилын үнэ өсөөд байна, инфляцад нөлөөлөөд байна. Тийм учраас гаднаас оруулж ирье гээд гаргасан хууль нь тийм байхгүй юу. Тийм учиртай.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхээр энэ дээрээ бас маргаантай байдаг юм. Нэмсэн, нэмээгүй, зах зээл нь ийм байгаа гээд. Сүүлдээ шүүх рүү очсон юм шиг байгаа юм. Тэгэхээр би эхний ээлжид энэ асуудал нь тэр шүүх дээр үндэслэлгүй нэмсэн юм уу, нэмээгүй юм уу гэсэн ийм эцсийн шийдвэр гарсан уу гарсан уу гэж нэгдүгээрт асуумаар байгаа юм. Энийгээ шийдчихвэл тэр энэ улаан буудай тариа явуулж байсан тэр юм руугаа ороод л явах байх л даа. Тэгэхээр энэ дээр эхлээд хариулт өгөх хэрэгтэй байх. Нэг их тухайн үедээ бөөн сенсац болоод л тэгээд ямар үр дүн гарсан нь мэдэгдэхгүй ингээд орхичихсон шүү дээ.

Хоёрдугаарт, Атрын-4 дүгээр аяны талаар 200 мянган га газрыг нэмэгдүүлнэ гэсэн ийм зүйл байгаа юм. Тэгээд манай зүүн бүсийн хувьд бас газар тариалангийн нэлээдгүй том бүсэд орно. Ялангуяа энэ төлөвлөгөө дээр Дорнод, Хэнтий аймагт бас тариалангийн талбай нэмэгдүүлнэ гэсэн ийм зүйлийг оруулж байгаа юм байна гэж би ингэж ойлголоо. Тэгэхээр ер нь Атрын-4 дүгээр аяны энэ үйл явц ямархуу байдалтай явах юм гэдэг тал дээр энэ зүүн бүсийн тариаланчдад бас мэдээлэл өгөөч. Энэ би хэлээд байгаа юм биш зүүн бүсийн 2 ч сумд очиход бидэнд ямар ч мэдээлэл байхгүй байна. Тэр төвийн 3 аймгаар л мэдээлэл яваад байна гэдэг ийм гомдлыг бүр тавьж хэлээрэй гэсэн учраас би хэлж байгаа юм. Бид бас энэнд оролцмоор байна гэдэг ийм зүйлийг ярьж байгаа юм.

Дараагийнх нь яах вэ амьдрал дээр байгаад байдаг нэг зүйл бол газар тариалангийн зориулалтаар авсан газрууддаа өөрөө ч тарьдаггүй, өрөөлийг ч тариулдаггүй ийм талбай ер нь Монгол Улсад хэд байдаг юм бэ? Тэгэхээр энийг эдийн засгийн эргэлтэд оруулах тал дээр ямар хөшүүрэг юмнууд бас хэрэглэх ёстой байдаг юм бол? Энд тэнд хэдэн мянган гагаар нь зарна л гэж яваад байгаа болохоос биш яг Газрын хуулиараа ингээд хураачих гэхээр маш сайн хамгаалалттай байгаад байдаг, явж өгдөггүй. Тэгсэн хэр нь тарьдаггүй, өөрөө тарихгүй өрөөлийг тариулахгүй. Тэгээд ийм юмыг бас шийдээд явчихвал 200 битгий хэл өшөө дахиад нэмэгдэх бололцоо байна уу гэж. Ингэж би бас хараад байдаг юм. Энэ дээр яамны юу ямар байдаг юм бэ?

Дараагийн нэг асуудал нь ийм зүйл яригдаад байдаг. Ингээд тарьж чаддаг, ургуулж чаддаг дотоодын хэрэгцээ нь 100 хувь хангачихдаг, гадагшаа экспортолмоор байна гэхээр гарц байхгүй байна гэдэг гомдлыг бас яг энэ нөгөө гурилын экспортыг яана гэж байх үед л эд яригдаж байсан үе шүү дээ. Тэгэхээр энэ дээр сайдын хувьд бас гадагшаа экспортлох тэр гарц юмнуудын талаар ер нь Хөдөө аж ахуйн яам ямархуу бодлоготой байдаг юм гэж ингэж асуух гээд байгаа юм. Тэрнээс тухайн үед тарьж чадаж байна, зарж чадахгүй байна гэдэг зовлон яриад байсан шүү дээ.

Б.Бейсен: Хэдэн номер уу, сайд хариулах вэ? 6 номер, сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Өнгөрсөн жилийн өвөлжилт, зудын хохирлыг даван туулахын тулд энэ татварын зохицуулалт хийгээд татваргүйгээр гурил болон улаан буудай тэжээлийг импортыг нээсэн. Ингээд тухайн үедээ энэ зохицуулалт үүргээ амжилттай гүйцэтгэсэн гэж үзэж байгаа. Нэгэнт үүргээ гүйцэтгэсэн бол цаашид буцаад хувийн хэвийн байдалд нь оруулж салбарын тогтвортой байдлыг хангах нь онцгой чухал байна. Гурилын үнийн хэлбэлзэл дээр баруун бүсэд тодорхой төрөл дээр үнэ бага зэргийн хямдрал үзүүлсэн, мэдрэгдсэн. Төвийн бүсэд үнийн өөрчлөлт гараагүй. Яг хууль гарсан 24 оны 4 сарын 29, жилийн эцсийн 12 сарын 30-ны байдлыг үзэхэд 2446 төгрөг байсан 1 дүгээр гурил жилийн эцэс гэхэд 2236

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ийм л хэлбэлзэлтэй. Дээд гурил 2969 байсан жилийн эцсээр 3139 бүүр өссөн. Дотоодын үйлдвэрлэлийн гол түүх юм унаад ирэхээр гол хэрэглээд байдаг дээд гурилын үнэ өсчихсөн байх жишээтэй. Үр дагаварт нь 211 мянган тонн гурил үйлдвэрлэгдэж байсан дотоодын үйлдвэрлэл 148 мянган тонн болж, 40 уналт хийсэн. Дотоодын үйлдвэрлэлийн уналт хийчхэж байгаа юм.

Харин үндсэндээ Охувьтай байсан импорт 64.2 мянган тонн болж импорт эрс нэмэгдэж байгаа буюу бид гурил энэ гурилан бүтээгдэхүүн гол зах зээлийнхээ 40 гаруй хувийг импортод алдсан гэсэн үг. Дотооддоо 100 хувь тарьдаг, 100 хувь үйлдвэрлэдэг үндэсний үйлдвэр нь 100 хувь дотоодын гурилаараа бүтээгдэхүүнээ хийдэг байсан бол энэ импортын хамаарал 40 хувь болоод байна. Энэ бодлогын яаралтай өөрчлөлтийг хийхгүй бол энэ жилийн үр дүнд 60 хувь руу, 70 хувь руу орох бодитой эрсдэл гарчхаад байна.

Нөгөө талаас гурил үйлдвэрлэл унахаар малын тэжээлийн үйлдвэрлэл унаад, мөн адил тэжээлийн хамаарал гадна талаас хамаарал үүсээд байна. Ингээд хөдөө аж ахуйн салбар чинь ингээд цогц явдаг болохоор ингээд харилцан нөлөөллүүд их өндөр гараад байна. Ингээд нөгөө валют ахиад гадагшлах, гадаадаас валютаар гурилаа, улаан буудайгаа, тэжээлээ худалдаж авдаг тал руу л яваад байгаа ийм бодит байдал байна.

Тэгэхээр одоо яаралтай энэ зохицуулалт хийж энэ жилийн хаврын тариалалтыг сезоныхоо яг яаралтай энэ долоо хоногт шийдвэрийг нь гаргаж тодорхой болгохгүй бол нэлээн хүнд ийм нөхцөл байдал үүсэх гээд байна гэдгийг л дахин дахин хэлээд байгаа юм. Нэгэнт Их Хурал шийдвэр гаргасан болохоор Их Хурал шийдвэрээ хэрхэхийг шийдэх ёстой байгаа юм. Уг нь өмнө нь Засгийн газар дотроо зохицуулалт хийгээд үнэ, өсөлт, уналт, ханштай холбоотойгоор нефть бүтээгдэхүүнтэй адилхан зохицуулаад явчихдаг байсан зүйлийг Их Хурал татаж авчраад хууль болгоод баталчихсан. Тийм болохоор заавал Их Хурлаар орно гэсээр байтал үндсэндээ бүтэн яг 1 жилийнхээ нүүрийг үзэж байна. Дараагийн үйлдвэрлэл тулчхаад байгаа байдал байна.

Экспорт дээр бид нар нэлээн анхаарч бусад таримлаа нэмж байгаа нь ерөөсөө ганцхан улаан буудай биш экспортын таримал руугаа нэлээн анхаарал тавьж байгаа. Энэ жил 50 гаруй сая долларын газар тариалангийн бүтээгдэхүүний экспорт гарсан. Энийг бид нар 100 сая доллароор хүргэх бодитой бололцоо байгаа. Ер нь аль болох л хөдөө аж ахуйг экспорт чиглэсэн байж байж дотоод хөгжил ер өөрөө хангагдаж байна.

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулах, сайд гүйцээж хариулъя. 6 номер.

Ж.Энхбаяр: Сая бид нар Монгол Улсын тариаланчдынхаа улсын зөвлөгөөнийг хийсэн. Бүх бүс нутгаас бүгд төлөөлөл ирсэн. Зүүн бүсийнхэн нэлээн өргөн ирсэн. Бүх 21 аймгийн хөдөө аж ахуйн газрын дарга нар, 21 аймгийн Мал эмнэлгийн газрын дарга нар, бүх агрономичид бүрэн цугларсан. Удирдах ажлын зөвлөгөөнөө энэ үед давхар хийсэн бүрэн мэдээллийг өгсөн. Одоо ингээд орон нутгууддаа очоод хөдөө аж ахуйн салбар зөвлөгөөнүүд тариаланчдын, ногоочдын, мал аж ахуйн чиглэлийн ийм семинарууд, зөвлөгөөнүүдээ орон нутгууд зохион байгуулаад эхэлсэн байгаа. Тэнд яригдсан бүх мэдээлэл, энэ тооцоо файл, судалгаа бүрэн мэдээллээр хангаж явуулсан. Үнэхээр зүүн бүс бол манай их маш том бодлогын нөөц ийм өв байгаа. Атрын-4 дүгээр аяны хүрээнд зүүн бүсээс 71

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

мянган га талбайг нэмж эргэлтэд оруулна гэдэг хүсэлт ирсэн байгаа. энийг.../минут дуусав./

Б.Бейсен: Замира гишүүн асуулт асууя.

С.Замира: Баярлалаа. Энэ Атрын-4 дүгээр аян гээд л өөрөө татварын гурил буудайны юу яриад байна шүү дээ Их Хурлаас баталсан гээд. Энэ нь ийм учиртай байгаа байх. Би мэргэжилтний хувьд энийг ингэж баруун бүсэд та хэдэн аймагт гурил буудай тариулж байгаа юм? Зүүн бүс тэртээ тэргүй газар тариалангийн төв, газар тариалангийн талбайтай. Баруун бүс дэх хэдэн аймагт газар тариалан байгаа, ялангуяа гурил будаа? Тэгээд тодруулъя даа.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 6 номер, сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Баруун бүсэд үр тарианы үйлдвэрлэл Увс аймгийн Баруунтуруун суманд явагдаж байна. Өөр газар үр тарианы үйлдвэрлэл бараг байхгүй. Голцуу малын тэжээлийн түвшинд, ногоон тэжээл бэлдэх хэмжээнд бага хэмжээний тал маань явагдаж байгаа. Гол юм бол энэ төвийн бүсийн район болон зүүн бүсэд газар тариалангийн үйлдвэрлэл явагдаж байгаа. Энэ баруун бүс нутгаар ер нь энэ улаан буудай, гурил татваргүй болсонтой холбоотойгоор Баруунтуруун буюу Увсад нэлээн бодлогын хувьд хэрэгжиж байсан олон арга хэмжээ хойшилж байгаа. Үндсэн тэнд хөрөнгө оруулах ажил хийж байсан аж ахуйн нэгжүүдэд маш хүнд цохилт болсон. Үндсэндээ баруун 5 аймаг Оросын Алтайн хязгаарын гурилын зах зээл болж хувирчхаад байгаа буюу тэнд дотоод үйлдвэрлэл явуулах, тариалалт хийх нөхцөлд туйлын хязгаарлалууд болж байгаа юм.

Тэгэхээр энийг л засахын тулд энэ татварын асуудлыг шийдээд өгвөл бид баруун бүс рүү бүүр бодлогын арга хэмжээ явуулах бололцоотой. 40 гаруй мянган га талбай Баруунтуруунд байгаа. Дөнгөж 20 гаруй мянган га талбай ашиглалтад байна. Баруун бүс нутагтаа Баруунтуруунд тулгуурласан тэжээлийн аж ахуй, үр тарианы аж ахуй байгуулна. Хангайн бүсэд Хархорины түшиглэсэн тэжээлийн болон үр тарианы аж ахуй байгуулах ийм зорилт бодлого байгаад байдаг.

Нөгөө зохицуулалтаар Гааль, тарифын бодлогоор энэ бодлого нь бодлогоо бас цавчаад байдаг ийм л юм үүсчхээд байгаа юм.

Б.Бейсен: Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Энэ жишээлбэл тэр баруун бүст тэр Увсад байгаа тэр сумд байгаа 40 мянган гээд газар гэсэн тээ. Тэр нь баруун бүсийн аймгуудыг хангаж чадахаар хэмжээний юм уу, биш үү гурилыг? Одоо яагаад татвар тэглээд байна гэхээр нь ийм зүүн бүс, төв аймгуудад хангалттай гурил будаа тарина. Тэгээд баруун бүсэд гурил, будаа байхгүй. Тэгээд ард түмэн эндээс зөөж авиа аваачлаа гэхэд маш үнэтэй. 2000-аад километр газар тээврийн хөлс энэ тэр нэмэгдэхэд маш үнэтэй гурил тэнд очдог байхгүй юу Баруун аймгуудад, Говь, Баян-Өлгий, тэр Завхан, Говь-Алтай аймгуудад. Тийм учраас ингээд гурил будааг нь юу нь тэглээд тэр хойд талаас нь хойшоогоо цааш нь ингээд Алтайгаас ингээд юм оруулж ирж байгаа гурил будаа оруулж ирж байгаа байгаа. Тэр нь тийм учиртай. Тэгэхээр бид нар яг 100 хувь адилхан үнэ.../минут дуусав./

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бейсен: Гүйцээж асууя. Замира гишүүн.

С.Замира: Адилхан үнэ ханшаар Монгол даяараа гурил будаагаар хангаж чадна гэвэл тэр юуг тэглэж болох байх даа. Арай тэгж чадахгүй бол энэ зүүн бүсэд байгаа гурил будаагаа экспортод гаргаад баруун бүсээс Оросоос яагаад гурил, будаа оруулж ирж болохгүй гэж. Ингэж уг нь ийм зохицуулагдах ёстой шүү дээ. Тэгэхгүй бүх юмыг бид нар өөрсдөө барина гээд үнэтэй юмыг баруун бүсийнхэн аваад л тэгж бас энэ зах зээлийн үед ер нь ийм юм байж болохгүй. Тийм учраас энэ дээр та бүхэн жоохон ялгаатай харвал яасан юм бэ гэж би бодож байна л даа.

Б.Бейсен: 6 номер, сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Тийм, таны санал их зүйтэй л дээ. Одоо ганц энэ үйл явдлын сургамж юу вэ гэвэл одоо гурилын үйлдвэрүүд гурилын холбоотойгоо Монгол Улсын хэмжээнд үнийн зохицуулалт дээр та нар бодлого гарга, баруун бүсийг төвийн бүстэй үнэ ижил байх нөхцөлийг хангахын тулд тэр тээвэрлэлт болон бусад зүйл дээрээ бас жоохон тарифын бодлогын жоохон хамтын ажиллагааг хийгээд зохицуулж болох юм байна. Өмнө яг адилхан яг л зах зээл, чөлөөт зах зээл гээд л тээвэр нээгээд л 2000 км тээвэрлээд л үнэтэй гурил, төвийн бүсээсээ үнэтэй идээд байсан. Энэ маань өөрөө ард түмний бас нэлээн бухимдал, дургүйцэл, шаардлага үүссэн. Энийг бид маш сайн ойлгож байгаа.

Хоёрдугаарт Баруунтурууны энэ 40 мянган га талбай, Завханд бас тодорхой нөөц байгаа тэжээлийн үр тарианд шилжүүлэх бололцоотой. Баруун бүсийг чөлөөтэй үр тариагаар хангах ийм чадавх бид нарт байгаа юм. Тэгэхээр энэ бодлогуудаа их энэ хууль хэлэлцэх хүрээнд эвтэйхэн ойлголцоод.../минут дуусав./

Б.Бейсен: Сайд гүйцээж хариулъя байна.

Ж.Энхбаяр: Хуучин 90-ээд оноос өмнө чинь Баруунтуруунд элеватортой гурилын үйлдвэртэй, Хархорин чинь элеватор гурилын үйлдвэртэй яг төв төв бүсээ бүрэн хангаж байсан байхгүй юу. Энэ бодлого л жоохон орхигдчихсон. Тэгээд энийг энэ бодлого, энэ саяын үйл явдал сургамжид тулгуурлаад бид нар хэрэгж нөгөө сэргээх, босгох ийм арга хэмжээг шат дараатай аваад явчхаж болно шүү дээ.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Идэрбат гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя, үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Ийм л юм байгаа юм Энхбаяр сайд аа энэ бодлогын алдаа гэж хэлэх юм уу эсвэл харилцааны асуудал гэж хэлэх юм уу, эсвэл танайх уул нь аймаг болгон дээр өөрийн гэсэн Хүнс, хөдөө аж ахуйн газар гээд ингээд хэлтэс газрууд чинь байж байдаг. Гэтэл тэнд явж байгаа мэдээллүүд, яаман дээр явж байгаа мэдээллүүд хоорондын зөрөө өндөр байна. Яг өнөөдөр малчидтай гэдэг юм уу ингээд орон нутагт байгаа иргэдтэй харилцаж байгаа гол газар чинь тэнд байгаад байдаг. Гэтэл та хэдийн өгч байгаа мэдээлэлтэй дүйцэхүйц хэмжээний мэдээлэл тэнд байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энд нөгөө жишээлбэл

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

манай Хүнс, хөдөө аж ахуйн газар гэж ярихаас илүүтэйгээр Хөдөө аж ахуйн яамны бодлого Засгийн газрын түвшинд болохгүй байна л гэж ингэж шүүмжлээд байдаг процесс яваад байгаа юм. Тэгээд энийг зүгээр энэ бүтцийнх нь хувьд гэдэг юм уу, энэ харилцаа холбоо гэх юм уу, эсвэл мэдээлэх гэдэг юм уу ямар байдлаар цаашдаа явуулах юм.

Хоёрдугаарт энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой цөлжилт явагдаж байгаа, газар, энэ бэлчээрийн доройтолтой холбоотой асуудал ялангуяа бэлчээрийн төлөв байдлын тайланг бол танай яам гаргадаг. Цаашдаа бид нар мал аж ахуй, мах, ноос, ноолуур гээд ингээд маш олон зүйлүүдийг л яриад л яваад байдаг. Гэтэл цаашдаа энэ бэлчээрийн доройтлоос чинь улбаатай энэ ноос ноолуурын чинь асуудлууд нөгөө давжаарлын асуудал буюу махны чинь асуудлууд ингээд маш олон асуудлууд үүсэх гээд байна л даа. Тэгэхээр бид нар энэ бүсчилсэн хөгжил, бодлогын хүрээндээ газар нутгаа ч гэсэн эд манай бүс нутаг манай Монгол Улсын нутаг дэвсгэр бас бүс нутгаараа ялгамжтай байдалтай байгаад байгаа учраас энэ дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам ямар бодлого явуулах вэ гэдгээ маш дэлгэрэнгүй тодорхой болгоод тодорхой өөрийнхөө харьяа байгууллагууд руу нэгдсэн мэдээллээр хангах системчлэлээ хийхгүй бол тэнд яг ний нуугүй хэлэхэд тэр суман дээр байгаа нөхцөл байдал бол асар өөр байдалтай. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд ирэхээр асуудаг хөөрхий. Тэгээд зарим гишүүд нь мэднэ, зарим гишүүд нь мэдэхгүй. Зарим нь сошиалд явж байгаа мэдээллээр мэдээлж байна.

Гэтэл энэ чинь төрийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа хүмүүс болчихоод байдаг. Тэгэхээр энэ дээр бол бид нар өчигдөр би бас Булган, уржигдар Булган аймгаар ажиллаад малчидтай уулзаад ингээд ирэхэд бол тэнд явж байгаа мэдээллүүд ерөөсөө маш хомс, Хөвсгөлөөр ажиллаж байх ч гэсэн бас энэ мэдээллүүд маш хомс байдалтай байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр та бүхэн маань бас сайн анхаарч энэ мэдээллүүдээ зөв байдлаар орон нутагт түгээх орон нутагт байгаа тэр сум, аймагт байгаа газар хэлтсүүдээ жоохон сайн мэдлэг, мэдээлэлтэй хүмүүсээр хангах, улс төржсөн байдлуудыг нь жоохон намжаах арга хэмжээг авдаг юм уу яадаг юм. Энэ бодлогынхоо түвшин дээр өглөө бид нар хүнс, хөдөө хөдөө аж ахуйн ажлын хэсгээр хүмүүстэй, бас танай яамны хүмүүстэй бид нар бас уулзалтууд хийсэн. Маш хангалтгүй. Бодлогоо тайлбарлаж чадахгүй байгаа байхгүй юу. Тэгээд заавал сайд нь байж байж энэ бодлогыг тайлбарлах ёстой юм уу, эсвэл би тэр чиглэлийнх тэр чиглэлийнх нь байхгүй гэдэг бусад яамнуудын хэлбэр дээр яваад байх ёстой юм уу? Яам төлөөлж л ирж байгаа бол төлөөлж ирж байгаа албан тушаалтан Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг болон энэ Байнгын хороо бусад газрууд дээр өөрийнхөө яамны бодлогоо ядаж мэд мэдээд тайлбарлаад явчихдаг хариултуудаа өгчихдөг хэлбэр дээр л баймаар байгаа юм.

Тэгэхгүй бол сумаас бид нар ингээд л стресстэж стресстэж нөгөө Хөдөө аж ахуйн газрынхан нь юугаа ч хийж байсан юм гээд бухимдаж бухимдаж орж ирээд Төрийн ордонд орж ирээд л дахиад л нөгөө яамных нь албан тушаалтнууд яг урдаас нөгөө адилхан процесс дээрээ ингээд сууж байхад л бүр болохгүй байна л даа. Тэгэхээр энийг та хэд маань бас цаашдаа мэдээлэл технологи байдаг юм уу, харилцаагаа яаж сайжруулах ёстой юм. Мэдээллийн нэг шугам дээрээ байхгүй бол малчид руу чинь, тариалан эрхлэгчид рүү чинь очиж байгаа мэдээллүүд их өөр өөр мэдээлэл яг ний нуугүй хэлэхэд байна шүү л гэж би хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Тийм. Тэгэхээр хаврын тариалалтынхаа бэлтгэл ажлын хангалтыг богино хугацаанд шуурхай эрчимжүүлэх хэрэгтэй. Аж ахуйнуудад олгох зээлийн хөрөнгөөс авхуулаад олон зүйлүүд яригдах ёстой. Үүнийг бид цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэх талын асуудал байна гэж.

Тэр гурил тэжээлийн гаалийн татварыг тэглэсэнтэй холбогдуулаад гарч байгаа үр дагавруудаа бид бүгд мэдэж байгаа. Би 2024 оны 5 сарын 1-нээс 25 оны 3 сарын 25-ны хооронд импортоор орж ирсэн гурилыг бүгдийг нь татаж үзсэн 71 мянган тонн байна. 24 оны жилийн эцэст 64 мянган тонн байна. 99 аж ахуй оруулж ирсэн юм байна. 10 мянгаас дээш тонныг 2 аж ахуй оруулж ирсэн. Мянгаас дээш тонныг 21 аж ахуй оруулж ирсэн. Зүүн бүсэд 1 аж ахуй, Улаанбаатарт 8 аж ахуй, бусад нь Увс, Баян-Өлгий аж ахуйнууд байна лээ. Тийм учраас би баруун бүсийн гурилын хангалт, үнийн тодорхой бууралт энэ тэр дээр тэр нэлээн том нөлөө үзүүлсэн юм байна гэж ингэж харж байгаа.

Тэгэхээр одоо бид үйлдвэрлэл бараг 40 гаруй хувиар буураад, тариалалт 20 гаруй хувиар буураад тэгээд 70 гаруй мянган тонн гурил гаднаас оруулж ирээд, үнээ тавиад байсан зорилгодоо хүргэж чадаагүй бол шийдвэрээ эргэж харахаас өөр арга байхгүй. Засгийн газар өргөн барьчихсан юм билээ. Энийг харин Бейсен дарга анхааралдаа авч, мэргэжлийн үндсэн Байнгын хороо нь учраас энэ асуудлаа ярих ёстой. 23 оны 11 сард шиг санаад байна Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос цаг үеийн нөхцөл байдалтайгаа уялдуулаад баруун бүсийн аймгуудыг тухайн хилийн боомтуудаар нь гурил, тэжээл оруулж ирэх юуг нь нээ гэдгийг Засгийн газарт чиглэл өгөөд нээсэн юм. Тэр зохих үр дүнгээ өгч явсан. Би тэр арга хэлбэрээрээ явах нь зөв гэж ингэж ойлгодог тийм чадамжаа бий болтол.

Хоёр дахь зүйл. Анхаарах ёстой хоёр дахь зүйл бол энэ гурилын үйлдвэрүүд дээр байж байгаа будааныхаа үлдэгдлийг тооцож үзмээр байна. Энэ жилийн тариалалтын ургац хураалтаар гарч ирж байгаа юмыг авах уу, үгүй юү гэдэг асуудал энд л яригдана. Байж байгаа будаа нь гурилынхаа стандартыг хангах хэмжээний байгаа юу, үгүй юү. Зүй нь би яг тухайн үед шийдвэр гаргахад гурил биш жоохон чанарын будаа оруулаад ирсэн бол жорлогчоор ашиглаад гурилын үйлдвэрүүдийн үлдэгдлийг бүрэн дуусгачих бололцоо байсан байхгүй юу. Тэгээд шинэ ургацаасаа будаагаа бүрэн татаад авчих ийм бололцоог энэ гурилын үйлдвэрүүд хийх ийм нөхцөл нь хангагдах байсан. Тийм учраас эргээд энэ асуудлаа бид судалж үзэж, зөв шийдлээ гаргаж шийдэх ёстой гэдгийг зориуд хэлмээр байна.

Гурав дахь зүйл нь тэр стратегийн нөөц бүрдүүлэлтийн асуудлаа хийх ёстой. Одоо та хэдийн 3 жил явсан үр дүн 70 мянга орчим тооны тухай асуудал яриад байгаа юм билээ. 100 мянган тонн байх ёстой. Тэгээд тэр сэлгэлт, нөхөн бүрдүүлэлтийнхээ үйл явцаар явах ёстой. Тийм учраас энэ намрын ургац хураалтаас өмнө 30 мянган тонныг нэмж нөөцлөх хөрөнгийнхөө асуудлын зохицуулалтыг хийж явах ёстой шүү. Энэ бол бидний хамгийн гол зүйл. Тэгж байж энэ салбарын өмнө тавигдаад байгаа зорилтууд би хангагдана л гэж ингэж л тооцож байна. Тийм учраас энэ тал руугаа анхаарах нь зөв байх. Тэгээд манай Байнгын хороо.../минут дуусав./

Б.Бейсен: Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Баярлалаа. Уг нь газар тариалангийн асуудал ч бай, Цагаан алт ч бай бүх юмыг цогцоор нь шийдвэрлэх нь зүйтэй. Зарим нэг газруудын судалгаа нь ч дутмаг тиймэрхүү юм харагдаад байна л даа. Энэ зөвхөн сайдтай холбоотой биш, ажлын аппараттай бас үнэхээр холбоотой. Сая гишүүд нь зөв ярьж байна. Тэгээд уг нь энэ гурил, буудай гэдэг ганцхан зүйл биш, өргөн хэрэглээний бараа гээд тухайн үед нөөцөд байсан улсын нөөц гээд. Тэр нь ямар учиртай гэвэл ямар нэгэн асуудал үүслээ гэхэд дотооддоо тэр хэмжээний нөөц нь байж байх, хадгалагдаж байх ёстой. Та бүхэн маань энэ тал дээр бас анхаарна уу гэж хэлмээр байна. Ямар нэг аргаар манай хил хаагдлаа гэж бодъё. Тэгэхээр бид гурилаа дотооддоо хангах ёстой. Одоо үнийн ялгаа ярьж байгаа болохоос биш тийм асуудал үүсэх юм бол байдал бас хүндэрнэ.

Тийм учраас тийм Завхан аймагт бас газар тариалангийн талбай байвал тэрний бас эргэлтэд оруулахыг бодоорой. Аль болохоор одоогийн манай Монгол Улсын цахилгааны үнэ нэмэгдсэн, үйлдвэр үйлчилгээ явуулах хэцүү байдалтай байгаа болохоор ард түмнийг бас бодох хэрэгтэй.

Гуравдугаарт, энэ дотоодын үйлдвэрлэгдэж байгаа гурил, будаа, стандартаа барих хэрэгтэй. Тэр дээр маш сайн хяналтаа тавиад гурил үйлдвэрлэж байна гэж хэлэхэд тэр нь чанар нь хэр зэрэг хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлөх байдал нь ямаршуу байгаа, талбай нь цэвэрхэн тэр бордоо нь ингэж хэрэглэж байгаа юм нь яг стандартын шаардлага хангаж байна уу гээд бүх юмыг цогцоор нь хийхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Б.Бейсен: Идэрбат гишүүн үг хэлье.

Ц.Идэрбат: Наад улаан буудайн асуудал чинь та зөвхөн хивэг яриад байна уу? Үгүй л дээ наад гурилын үнээс улбаалчихсан байхгүй юу. Гурилын үнэ нь 6, 7 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнд нөлөөлөөд инфляц өсөөд байна. Гурилын үнийг буулгах зорилгоор хийсээд тэрнээс та зөвхөн хивэг яриад байж болохгүй. Тэр чинь хавар бараг тэр зуд чинь бараг арилж байх үед шүү дээ тэр чинь. Тэгэхээр яах вэ энийгээ л нэг талдаа л би гаргачхаасай л гэж бодож байгаа юм. Тэрнээс миний хувьд тэр 90-ээд оны эхээр ясны гурил идэж байсан тэр үеийг монголчууд давтаж болохгүй шүү дээ. Хятадаас ясны гурил оруулж ирдэг тийм үеэ давтаж болохгүй. Өөрсдөө гурилтай болох л ёстой. Гол нь гагцхүү монопол гэдэг юм уу тэр нь үүсээд инфляцдаа нөлөөлөөд байх тэр хэмжээнд л байлгахгүй юм сан л гэсэн ийм л санаагаар би бас тэрийг хэлсэн юм байгаа юм.

Хоёрдугаарт тэр 200 мянган га Атарын-4 дүгээр аяныг дэмжиж байгаа. Гэхдээ бидэнд бас гашуун туршлагууд байгаа. Монгол Улсын газар тариалангийн нийт хянан магадалгаатай талбайн хэд нь эргэлтэд ороод, хэд нь зүгээр бизнесийн зарчмаар зарагдаад явж байгаа вэ гэдэг дээр бас яам анализ хийгээсэй. Газрын хуулиараа тарьдаггүй хэр нь шон босгочихоор ашиглаж байгаа гэж үзээд хураачхаж болдоггүй, байчхаж болдоггүй. Саяхны түүх бол Халх голын 500 мянган га-гийн асуудал. Яаж, хэн олгосон нь мэдэгдэхгүйгээр өнөөдөр тэр бүс нутагт ямархуу байдал үүсгэхээд байгаа билээ. Та тэр дээр анхаарна гэж хэлсэн. Тийм учраас би энэ Атрын-4 дүгээр аяны 200 мянган гагийн асуудал ч тэр бас нэлээн ил тод яваасай, бас тэр эндээс ашиг олдог зөвхөн газрын наймаагаар хийх гээд

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байдаг тэр нөхдүүдэд бас хаалттай байгаасай гэсэн утгаараа л энийг би бас хэлээд байгаа юм гэдгийг онцолж бас хэлье. Баярлалаа.

Б.Бейсен: Гишүүд үг хэлж дууслаа. Энэ 2 дахь асуудал хэлэлцээд дууслаа. Дараагийн хэлэлцэх асуудалд орёе.

16.55 цаг

Махны экспортын асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсьё.

Мэдээллийг Энхбаяр сайд танилцуулна.

Ж.Энхбаяр: Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын нэгээр хөдөө аж ахуйн салбарыг тодорхойлж, хүнс экспортлогч орон болох үүн дотроо мах, махан бүтээгдэхүүний экспортыг үе шаттай нэмэгдүүлэхээр Монгол Улсын Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын нийгмийн эдийн засаг хөгжүүлэх гол бодлогуудад туссан. Энэ зорилтыг Хөдөө аж ахуйн яам хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Жилийн эцсийн тооллогоор 24 онд 57.6 сая мал тоолуулсан. Эндээс бид нар 15-аас 20 орчим сая толгой малыг хэрэгцээлгэх ийм нөөц бүрдэж байна. Энэ жилийн өвөлжилт, мах бэлтгэлтэй холбоотойгоор 9.2 сая толгой буюу 230 мянган тонн махыг хэрэгцээлсэн. 6.1 саяыг буюу 160 мянган тонныг дотооддоо үүнээс зарцуулсан байна. 3 сая гаруй буюу 72.3 мянган тонныг бид экспортлохоор ийм тооцоо гарсан. Энэ гүйцэтгэл 71.1 мянган тонноор, цул махаар шүү дээ. Ястай мах, ястайгаар тооцвол 110-аад мянган тонн ийм мах нийт 300 орчим сая долларын мах экспортод гарчхаад байна. 1921 онд 21 мянган тонн, 22 онд 16 мянган тонн мах гарч байсан бол сүүлийн 3 жил 80 мянга, 70 мянга гэсэн ийм тоо буюу 300 сая долларын түвшинд хүрч, экспортын их том бүтээгдэхүүн болж гарч ирж байна. Энийг экспортод гарч байгаагийн гол суурь нөхцөл нь юу вэ гэвэл мал эмнэлгийн үйл ажиллагаанд нэлээн ахиц гарч, малыг дархлаажуулах, вакцинжуулалтын арга хэмжээ түүнд хэрэглэсэн арга тактикууд нэлээн оновчтой болсны үр дагавар байдаг. Яагаад гэвэл мал аж ахуй дээр олон улсын гоц халдварт хэд хэдэн томоохон өвчин дэлхийн хэмжээнд бас хорио цээртэй, хатуу хорио цээртэй ийм өвчнүүд явдаг. Тэгэхээр энд бас нэлээн Монгол Улсад бас сүүлийн хэдэн жил Улсын Их Хурал Засгийн газраас авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ мал эмнэлгийн салбарт үр дүнгээ өгсөн байна гэдэг нь харагдаж байна.

Экспорт үндсэндээ улсаас хамааралтай байсан экспорт өнөөдрийн байдлаар бүтэц нэлээн өөрчилсөн. БНХАУ 23 онд 80 хувьтай байсан бол 24 онд 63 хувь руу орсон. Иран улс 30 хувиар, Ирак орнууд 30 хувиар булангийн орнууд орж ирж байна. Мөн Зүүн өмнөд ази, Вьетнам, мөн Төв азийн орнууд, ОХУ бусад импортлогч болж орж ирж байна.

Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын гишүүнээр Монгол Улс 1989 онд элссэн байдаг. Тэгэхээр энэ олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн ийм шаардлагууд энэ экспортлох, импортлох бүхий л үйл ажиллагаанд явагддаг. Энэ томоохон арга хэмжээ сая мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсан тодорхой зарим чиг үүрэг

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Монгол Улсын гаалийн байгууллага дээр хэрэгжиж байсан энэ чиг үүргүүд Мал эмнэлгийн ерөнхий газарт сая бүрэн шилжиж ирсэн. Энийг бид нар нэвтрүүлэх, аж ахуйн нэгжүүдтэйгээ ажиллах, энэ зөвшөөрөл олгох энэ асуудлуудаа ингээд үндсэндээ цэгцлээд дуусаж байна.

Бид мах экспортлох бүх хорио цээр, хоригийг бүрэн цуцалсан. Энэ ч үр дүнгээ хүрч, энэ өндөр түвшний экспорт хийгдээд байгаа. Одоо энэ Атрын-4 дүгээр аян дээр хийгдэж байгаа тэжээлийн таримлынхаа баазыг бид нар сайн нэмээд өгөх юм бол энэ 300 сая долларын экспорт 500 сая доллар хүрэх маш ойрын зорилт. 1, 2 жилийн дотор бид нар энэ махны экспорт нэлээн томоохон валютын эх үүсвэр болох ийм бололцоо байна. Энийг хийхийн тулд нөгөө талдаа бид, нэг талдаа мал эмнэлгээ сайжруулах, био комбинатаа шинэчлэх гээд томоохон бодлогын ажил хүлээгдэж байгаа. Мөн олон улсын гэрээ хэлэлцээрүүд байгаа. Энэ хугацаанд бид нар 14 Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгууллаа. Хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай 15 протоколыг байгууллаа. Харилцан ойлголцлын 6 санамж бичиг мал эмнэлгийн гэрчилгээний 60, мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөлийн 5, хорио цээр, мал эмнэлгийн ариун цэврийн шаардлага 2-ыг тус тус тохиролцсоны үр дүнд энэ экспорт гарч байгаа. Зарим гишүүд махны экспорт хязгаарлалтад орсон талаар ярьж байсан. Ийм ямар нэгэн хязгаарлалт экспорт дээр хийгдээгүй. Энэ маш их үнэ цэнээр, маш их ажил болж байж олж авсан зах зээл, гэрээгээр хүлээсэн үүрэг. Иймд гэрээ байгуулсан бүх аж ахуйн нэгжүүд махаа бүрэн экспортод гаргаж дууссан. Одоо ингээд шинэ оны мах бэлтгэл амжилттай явагдаж байна. Нэг том дэвшил гарч байгаа зах зээл их өндөр байна. Одоо бид ахиад 10 сая толгой мал экспортод гарах бололцоо байна мал, мах. Хамгийн гол нь тогтвортой нийлүүлэлтийг шаардаж байна. Бидний нүүдлийн мал аж ахуй маань улирлын хамааралтай буюу богино хугацаанд байгаа. Энийг Атрын-4 дүгээр аянд хэрэгжүүлж байгаа тэр тэжээлийн таримлыг нэмэгдүүлснээрээ бид өвлийн мал жинг алдах улирал мал өсвөр малыг бордох, тэжээх ийм аргатай хослуулснаар энэ экспортыг идэвхжүүлэх энэ хугацааг эрс нэмэгдүүлэх ийм бололцоо байна. Энэ жил эхний байдлаар мал, махны экспорт үндсэндээ хэрэглээд дуусчихсан байх ёстой өнөө үед ч гэсэн яг одоогийн байдлаар он гараад 8 мянга гаруй тонн мах, 8.8 тийм үү, 35 сая долларын мах экспортлогдоод байна. Энэ үндсэндээ зогсохгүй нь. Ингээд мал тэжээдэг, үйлдвэрүүдэд тасралтгүй нийлүүлдэг ийм сэтгэлгээний арга ухааныг томоохон эерэг ийм ойлголт бас их бий болж байна. Тэр нь их чухал байна гэж.

Ингээд ахиад хэлье энэ манай махны экспорт бүрэн либерал болсон. Үйлдвэрүүдийг нэлээн сайн олон улсын стандарт руу нэлээн нийцүүлж байгаа. Ялангуяа энэ исламын шашинтай оронд гаргаж байгаатай холбоотой халал стандартыг нэвтрүүлэх ажлууд үндсэндээ хэрэгжээд амжилттай дуусаж байна. Экспортод хүлээн авч байгаа улс орнуудын хорио цээрийн байгууллагуудаар магадлан итгэмжлэх ажлууд үндсэндээ амжилттай хийгдээд дуусаж байна. Ер нь махан дээр нэлээн их томоохон бололцоо бий боллоо. Ингээд энийгээ Атрын-4 дүгээр аянтайгаа холбоод ингээд үйлдвэрийн аргаар мал төхөөрөөд ирэхээр нөгөө цагаан алт болсон үйлдвэрүүдийн маань түүхий эдийн чанарт онцгой нөлөөлөл учруулж байна. Үйлдвэрээрээ нядалсан малын арьс гэмтэлгүй байна, дайвар бүтээгдэхүүнүүд бүрэн ашиглагдаж байна.

Хоёрдугаарт төв суурин газрын махны хэрэглээг хангах тэр боловсруулагдсан, тэр эрүүл ахуйн баталгаажсан, ангилсан ийм махны худалдаа нийтэд түгж үйлдвэрүүдэд борлуулалт хийж эхэлж байна. Энэ бас мөн эргээд энэ

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

дотооддоо энэ аюулгүй байдал, нөгөө талаасаа энэ ариун цэврийн асуудалтай холбоотой их том ахицууд бас гарч байна. Тэгэхээрээ хөдөө аж ахуйн салбарын энэ болгон чинь л хоорондоо холбогдож, бие биеийгээ дэмжсэн ийм маягаар уялдаж явж байгаа юм гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Ахиад хэлье экспортын орон зай их өндөр байна. Гишүүдийн анхааралд хүргэх юм бол Биокомбинат гэж томоохон байгууллага байгаа. Энэ дотоодынхоо хүчин чадлыг эм бэлдмэл, вакцины үйлдвэрлэлийн хүчин чадлыг эрс нэмэгдүүлэх, Биокомбинатаа эрс шинэчлэх зайлшгүй шаардлага байгаа. Энэ олон сая мал улмаар бид нарт бас олон сая шувуутай болж байна, гахайтай болж байна, бусад олон тэжээвэр амьтад бий болж байна. Дотоодын мал аж ахуйн энэ шаардлагатай эм бэлдмэл, вакцин үйлдвэрлэлийг үндэсний чадавхыг бий болгох нь зайлшгүй бодлогын арга хэмжээ байна.

Нөгөө талаасаа мал эмнэлгийн гол лабораториуд байгаа. 2 том лаборатори яамны харьяанд ажиллаж байна. Суурьшлын бүсэд орчихсон эргэн тойрон, орон сууц, суурьшлын бүс, Зайсанд суурьшлын бүс төвдөө Био аюулгүй байдлын 3 дугаар зэргийн лаборатори үйл ажиллагаа явуулж байгаа нь санаа зовоосон байдал байгаа. Иймд энийг мөн төв, нийслэлээс гаргах ийм зайлшгүй шаардлага байгаа. Ингээд мал эмнэлгийн үйлчилгээ 100 хувь үндсэндээ хувьчлагдсан. Орон нутагт мал эмнэлгийн тасгууд хувийн хэвшил үүргээ гүйцэтгэж байгаа. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд энэ вакцинжуулалтын бодлогын арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнийгээ хувийн хэвшлээ, мал эмнэлгүүдээ чадавхжуулах тэр төрийн өмнөөс үзүүлж байгаа үйлчилгээний үнэ тарифыг нь нэмэгдүүлэх гэх мэт бодлогын бас тийм арга хэмжээнүүдийг зайлшгүй авч хэрэгжүүлэх ийм шаардлага байна. Түрүүн Бат-Эрдэнэ гишүүний яриад байгаа бодлогын алдаа байна уу гэж яриад байгаа зүйл тогтолцоо буруу байгаа. Тогтолцоог цэгцлэх хэрэгтэй байна. Энд бас мэргэжлийн Байнгын хороо анхаармаар байна. Аймгуудын хөдөө аж ахуйн газрууд, байгууллагууд яамны шууд удирдлага нь байхгүй байгаа орон нутгийн. Хүний нөөцийн хангалт туйлын сул байгаа. 40 хувь нь мэргэжлийн, 60 хувь нь мэргэжлийн бус байдалтай байгаа.

Ер нь хөдөө аж ахуйн салбараа шинжлэх ухаантай, хүний нөөц бэлтгэлтэй, орон нутагтаа нэг мөр босоо, цогц болгож өгөөд ингээд зүтгэвэл бас манай хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн салбар өөрөө хамгийн том ажил олгогч, нөгөө талаасаа маш сайн нийгмийн тогтвортой байдлыг хангагч баялгийн хамгийн сайн тэгш олон хүнд хуваарилж хүртээж чадаж байгаа. Нөгөө талаар экспортын одоо байгаа экспортдоо 2, 3 дахин нэмэгдүүлэх ийм боломж, нөөц байна. Хаа хаанаа малчид нь тэр, тариачин, ногоочид нь тэр, үйлдвэрлэгч тэр аль аль нь сэтгэл хангалуун байх ийм боломж байна. Бодлогын бөгөөд хууль, эрх зүйн ийм арга хэмжээнүүдийг Байнгын хороо, мэргэжлийн Байнгын хороо маань шийдвэртээ хурдтай аваад ингээд бидний ажлыг дэмжээд өгвөл бас их сайн байна.

Б.Бейсен: Энхбаяр сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгөөрэй.

Мандхай гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн асуулт асууя. Батжаргал гишүүнийг та нэмээрэй. Бат-Эрдэнэ гишүүн асуух юм байна дарааллаар.

Б.Бат-Эрдэнэ: Махны экспорт нэмэгдээд бас хэмнээд явж байгаа сайхан байгаа. Болж байгаа. Гэхдээ уржигдар бид хэд Хялганатад байдаг яг махны

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

чиглэлээр үйлдвэрлэл, үйлдвэрлэл ч юу байх вэ дээ махны чиглэлийн эрчимжүүлсэн аж ахуй гээд нэртэй 1000 үхрийн фермээр орлоо. Энэ бодлогын уялдаа холбоотой асуудлуудыг бас л яг хөндөж байна. Жишээлэх юм бол газартай холбоотой асуудал хөндөгдөөд байгаа юм. Үхрийн ферм, махны чиглэлийн төрөлжсөн ферм байгуулдаг. Гэтэл газар олголттой холбоотой, бэлчээртэй холбоотой асуудлууд ингээд нэлээн түвшинд хөндөгдөөд явчхаж. Яах вэ зээл энэ тэр гээд ингээд бодохоор бас л тодорхой хэмжээнд ярьж байгаа асуудлууд байна.

Гэхдээ гол тулгамдсан ярьж байгаа асуудал ерөөсөө л бэлчээр. Одоо бид нар ингээд ногоон тэжээл байдаг юм уу, тэжээлээ тавиад, тэжээгээд малчдаасаа ялангуяа Хялганат дээр нөгөө улаан тарлан гэдэг билүү үхрүүд нь байна, энийгээ бид нар бэлчээх газар гээд ингэхээр ерөөсөө нутгийн иргэдтэй, малчидтайгаа бид нар ерөөсөө болж өгөхгүй, зохицохгүй хэлбэр дээр байна.

Хоёрдугаарт малын бэлчээрийн доройтолтой холбоотой асуудлуудыг яг төрөөс ямар бодлого арга хэмжээ авч явуулах юм бэ? Бид нар жишээлбэл өгчихвөл 100, 200 гагаар нь өгчихвөл заримыг нь ээлжлэх, сөөлжлөх хэлбэр дээр бид нар бас тодорхой хэмжээнд өнжөөхийг нь өнжөөгөөд ингээд зохион байгуулалт хийгээд явчих бас боломж нэг талдаа байгаа.

Гэхдээ олгож байгаа газар нь өөрөө хэмжээ бага байгаагаас улбаатайгаар нөгөө газраа сэлгэх боломж нь бид нар дээр алга байна. Мэдээж тэр үхэр чинь ороод талхлаад гараад явчихвал тэнд юу үлдэх вэ дээ. Нөгөө талдаа малын тэжээл тариалах газар олголтыг шийдэж өгөх боломж бас байна уу? Ерөөсөө л газартай холбоотой, бэлчээртэй холбоотой харилцааг л яг энэ ферм дээр бол маш их хэмжээгээр хөндөж байна.

Дээрээс нь тэр тодорхой хэмжээнд гадаад руу гарч байгаа экспорттой холбоотой асуудлууд дээр сая хэдэн компанийн нэр, тоонууд байна л даа. Гадуур явж байгаа дээр бол тухайн тусгай зөвшөөрөл авсан компанийн тусгай зөвшөөрлөөр дамжуулан экспортод гаргадаг процессын асуудлуудыг хөндөөд байгаа юмнууд байна.

Тухайлах юм бол тэр дээр өөрсдөө тусгай зөвшөөрлөө авч чадаагүй. Тэгэхдээ тусгай зөвшөөрөлтэй компанийн тусгай зөвшөөрлийг ашиглаж нөгөө тусгай зөвшөөрөл авсан компани нь тодорхой мөнгөн дүн санал болгож тэр мөнгөн дүнгээр нь тухайн махыг нь авч, өмнөөс нь экспортод гаргадаг ийм процессын асуудлууд бас байгаад байна. Энийг бас яриад байна. Тэгэхээр энэ дээр жишээлбэл ямар бодлогын ийм арга хэмжээнүүд авах вэ? Нөгөө хорио цээртэй холбоотой асуудлын төсвөөс өгөгдөнө. Тэндээс ямарваа байдлаар өвчин илэрдэг юм уу, ямарваа байдлаар асуудлууд үүсээд явахад.../минут дуусав./

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? Сайд хариулах уу? 6 номер. 6 номер сайд.

Ж.Энхбаяр: Таны хэлээд байгаа үнэхээр энэ тогтолцооны буруу байдал яг л ингээд жижиг сажиг бүх юман дээр л илрээд байгаа юм. Орон нутагт газар олголт, бэлчээрийн асуудал бүх л орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын бүрэн эрхийн асуудал. Тэдний бодлогын зохицуулалтууд болчихоод. Ялангуяа хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлого аймгийн асуудал болчихоод байгаад байгаа юм.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Бид ерөнхий бодлогыг нь гаргаад, санхүү эх үүсвэрийг нь гаргаад юм хийе бүтээе гэсэн аж ахуйн нэгжүүдэд аль болох л хямд эх үүсвэр олж өгөхийн төлөө л явж байгаа. Энэ ажлаа л хийж байгаа. Тэр маань энэ 4 том бодлого болоод явж байгаа нь энэ. Гол зах зээл дээр нь аль болох хүнд сурталгүй, хурдан шуурхай экспорт хийх бололцоог нь бүрдүүлье л гэж байгаа. Энэ дээр олон ахиц гарсан. Үнэхээр 20 мянган тонноос 100 мянган тонн хүргэсэн 300 сая доллар экспортлогч нь тийм амар бүтэж байгаа зүйл биш шүү дээ. Маш их хөдөлмөр хийж байж гарч байгаа. Тэр бусдын махыг аваад дамжуулаад гаргадаг маргадаг тийм зүйл, тэр үлгэр дууссан одоо. Худалдан авагч ч хариуцлагатай болсон, гаргаж байгаа нь ч хариуцлагатай болсон. Бид хатуу шахаж байгаа. Тэр чинь аюулгүй байдал, гарал үүсэл, чанар гээд энэ чинь их том асуудал үүснэ. Ямар нэг квот буюу хязгаарлалтгүйгээр чи бэлдэж чадаад, баталгаажуулж чадаад, гэрээ хийж чадаж байгаа тэр үйлдвэрүүд бүх махаа гаргаж байгаа юм. Ямар ч саадгүй гарч байгаа юм. Цаашдаа ч тийм байх болно.

Тэгэхээр тэр бэлчээр газар олгох энэ ямар бодлого вэ гэдэг дээр ер нь Монгол Улсын 20050 хүртэлх хөтөлбөрийн Улсын Их Хурлын баталсан бодлого дээр бид үхэр сүргээ өсгөнө, тэмээгээ өсгөнө, бусад 3 нэр төрөл зүйлийнхээ малыг тоог бууруулна гэсэн зорилготой байгаа. Бэлчээр 20 саяар багаар бодоход, зарим тоон дээр 30 сая гэж байгаа толгой малаар даац хэтэрсэн. Малын тоо нэмсэнтэй холбоотойгоор бэлчээр хүчтэй доройтож байгаа. Мал бэлчээрээсээ авах шим тэжээл авч чадахгүй, тарга тэвээр гүйцэхгүй байгаа. Энэ маань харин өвөл цаг зуурын бэрхшээлийг давах чадавхыг сулруулж энэ олон саяараа үрэгдэж байгаа. Энийг хийх, шийдэхийн тулд махны экспорт. Махыг үнэтэй зах зээлд экспортолж байж илүү үр ашигтай, цөөн тооны ашиг шимт мал руугаа улсуудын хандлага бас төвлөрч байна.

Тэгэхгүй бол энэ малын олон тонн тулгуурласан энэ урамшууллын, сайн малчны гээд олон бодлогуудыг бүгдийг нь эргэж харж байгаа. Энэ бололцоо шаардлагууд бүгд өөр болох байх. Тэгээд орон нутагт үнэхээр тэр бүтцийг цэгцлээд энэ яамны мэдэлд гаргаад өгөх л хэрэгтэй байна. Энэ яг л Байнгын хорооны л ажил шүү дээ. Байнгын хороо энэ бодлогын асуудлуудыг л засаад, залруулаад өгөөч ээ гэж хүсээд байна. Яам ийм ийм асуудал үүсээд байна шийдэж өгөөч ээ гээд асуудал тавиад байгаа. Бүтцийн хувьд, удирдлага зохион байгуулалтын хувьд, хууль, эрх зүйн хувьд гээд бидний ганц гарын доор байгаа том боломж чинь энэ хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар байна шүү дээ. Тэгээд энийгээ хамтраад урагшлуулчих ийм бололцоо байна. Гишүүд маань өөрсдөө бас их санаачилгатай байгаач. Бид тэр дутуу мэдээлэл гаргаж байгаа дээр анхаараад мэдээллээр хангах, аль болох бүх мэдээллийг ил тод болгох, хурдан шуурхай байх гээд хэрээрээ л хичээж байна. Тэгээд алдаа, дутагдал байгаа бол тэрийгээ засаад явъя.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм тэр тогтолцооны асуудлыг тэгээд хэдүүлээ засахын төлөө л явахгүй болохгүй л байна л даа.

Хуучин хөдөө аж ахуйн сайдаар ажиллаж байсан Сэргэлэн Элчин сайдтай бид нар бас уулзаад ярилцаж байсан. Жил орчмын дотор яаж засагдсаныг би сайн мэдэхгүй болохоор зүгээр тодруулаад асуучихъя гэж бодож байгаа юм. Тухайн үед

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Сэргэлэн Элчин сайдтай уулзаж байхад Кувейт рүү, Саудын Арабын тодорхой Арабын орнууд руу гаргаж байгаа юм байхтай холбоотой килограмм тутмын 7 доллар гээд бид нар ярьчихсан байж байтал дотоодоос, Монголоос өөрсдөө наана цаана гэсээр байгаад үнийн өрсөлдөөн рүү оруулаад 5 доллар, 4 доллар, 3, 2 гээд бүүр ингээд буулгаад болохгүй байна. Одоо бид нар мал, махаа үнэтэйгээрээ экспортолмоор байдаг, авъя гэсэн сонирхол нь өндөр байгаад байдаг. Тэгэхээр энэ дээр бид нар жишээлбэл тэнд байгаа элчин сайдын яриа нь ийм байхад бид нар энэ дээр яамнаас тодорхой хэмжээнд үнийн бодлоготой холбоотой гадагшаа экспортолж байгаа дээр шүү, тийм ер нь тусдаа явж байгаа бодлогын шинж чанартай юмнууд бас байдаг уу, байгаа юу гэж асуух гэж байгаа юм.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Ийм байдал бүхий л түвшинд байгаа л даа. Байсан. Би байсан гэж хэлэх гээд байна. Хийсэн ажил бол сайдын дэргэд үр тарианы, ноолуурын, ноосны, арьс ширний, махны гээд зөвлөлүүд байгуулагдсан. Техникийн бодлогын гээд. Махны холбоо, ер нь бүх холбоодыг нэг болгож байгаа, цэгцэлж байгаа. Тусдаа 2, 3 байсан холбоо нийлүүлээд Махны холбоо бол нэг л холбоо. Тэгээд холбоотойгоо яам хамтран ажиллах бодлогынхоо бид нар гэрээнүүдээ байгуулчихсан. Яам юун дээр нь дэмжлэг үзүүлэх вэ, холбоо дотоод зохион байгуулалтаа яаж хангах вэ, чанар стандартаа сайжруулах вэ, ялангуяа саяын тэр үнийн өрсөлдөөн дээр үнэ унагаах байгаа ийм байдлыг яаж урьдчилан сэргийлэх вэ гэдэг юмнуудаа бүгд тэр гэрээ хэлэлцээр дээрээ тавиад мөрдөөд явчихсан.

Одоо ноолуур дээр гэхэд л мөн адил ямар үйлдвэрүүд ямар тоног төхөөрөмжийг бид нар сайжруулах ёстой вэ гэдгээ яам нь ч мэдэж байгаа, үйлдвэр ч мэдэж байгаа буюу гээд бүх юмаа ил тод мэдээлэл солилцоод тийм хамтын ажиллагаа холбоонуудтайгаа их тулгуурлаж.../минут дуусав./

Б.Бейсен: Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Тийм махны экспортын асуудал бид ярьж байна. Тэгэхээр энд 2, 3 зүйл л байгаад байгаа л даа. Газар тариалангийн бүс нутагтаа тэр өндөр ашиг шимтэй ахиу бүтээгдэхүүн өгдөг малаа өсгөн үрлүүлэх ажлыг шуурхай хиймээр байгаа юм. Тийм учраас мах бэлтгэлийг энэ газар тариалангийн бүсээс тэргүүн эгнээнд ээлжид хийж, буцаагаад тэнд өндөр ашиг шимтэй малаа хөгжүүлэх асуудлаар зохицуулж тэгээд энэ газар тариалан мал аж ахуй 2-ын зохистой хослолыг бий болгох ёстой. Энэ рүү бид нэн яаралтай явмаар байна. Нэг.

Хоёр дахь зүйл уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн бүс нутагтаа бид тэр нутгийн шилмэл омог дээр нь тулгуурлах асуудлыг шуурхай шийдмээр байна. 50 хэдэн үйлдвэр байгаа зураглалыг нь гаргачихсан гээд яриад байдаг юм. Одоо тэрийг ажил болгомоор байна л даа хэдүүлээ. Тэгж байж нэгж малаас авах ашиг шимийн хэмжээ нэмэгдэх ийм бололцоо, боломж бүрдэнэ.

Хоёрдугаарт тэр өнгөрсөн жил бид Малын эрүүл мэндийн тухай хууль хийгээд, тодорхой хуулиудад өөрчлөлт оруулаад хамгаалагдсан аж ахуйн тухай асуудлыг хөндөөд гаргаад ирчихсэн. Тэгэхээр үүнийг нэлээн сайн нутагшуулах замаар мах экспорт дээр тавигдах эргэлзээ юмнууд багасах ёстой. Үүнийг хэдүүлээ шуурхай шийдэж авмаар байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Гурав дахь миний хиймээр байгаа асуудал энэ сүргийн бүтцэд хээлтэгчийн эзлэх хувийн жинг эрс нэмэгдүүлмээр байна. Дан дамаа бог дээр. Одоо 40 хэдэн хувиар баримгүй байна л даа. Бүүр 65 руу нь хүргэмээр байна. Малынхаа тоог энэ 3, 2 төрөл дээр нь өсгөнө, бусад дээр нь бууруулна гэж ярьж болох ч сүрэг доторх хээлтэгчийн эзлэх хувийн жин нь өндөр байж байж наад мал аж ахуйн салбар гэдэг юм уу, малчид чинь өөрөө орлоготой, ашигтай явах бололцоо бий. Ингэж байж өсвөр малыг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлого чинь зөв хэрэгжих ёстой. Ингэж байж сая энэ тэжээлийн борлуулалтын асуудал зөв шийдэгдэх ёстой. Энэ жил ер нь нийт нутгаар хардуу орсон ногоо нэлээн оройтож идэж мэднэ Тийм учраас энэ хурга төлөө тэжээх асуудал руу гол анхаарал төвлөрөх нь зөв юм байна. Айл болгоны хашаанд цаг сайхан байсан гээд хэрэглээгүй баахан ногоон тэжээл өвс байгаад байдаг. Яагаад бид энийг малаа, төлөө бордох замаар арай эрт зах зээлд мах нийлүүлэх боломжоо бүрдүүлж болохгүй байгаад байгаа юм бэ? Энэ тал руу Хөдөө аж ахуйн яам бодлогын чиглэлээ гол анхаарлаа хандуулмаар байна.

Дээр нь тэжээчихсэн хургыг борлуулах баталгааг нь л гаргаж өг. Гадагшийгаа хэчнээн сая толгой хурга гаргах юм бэ, мах. Тэгэх юм бол энэ малчид чинь тэжээхэд бэлэн байна шүү дээ яг. Хурганы мах гарах, гарахгүй нь мэдэгдэхгүй байгаа учраас наад улсууд чинь нэмэгдэл зардал гаргаж хурга тэжээх тухай.../минут дуусав./

Б.Бат-Эрдэнэ: Нэмэлт минут авах уу Батжаргал гишүүн? Энхбаяр сайд, 6 номер.

Ж.Энхбаяр: Батжаргал гишүүн чухал асуудал хөндөж байна. Нэгдүгээрт бид нарт ашиг шимт малаа сайжруулах, малын энэ үржил селект, малын ... фондыг зайлшгүй сайжруулж том ажлыг хийхгүй бол оройтож байгаа. Махны гарц ч тэр, сүүний гарц ч тэр, олон гарц бид нар дэлхийн дунджаас хол хоцорч байгаа. Нэг.

Нөгөө талаар уламжлалт мал аж ахуйгаа хэрхэн үр дүнтэй болох вэ гэдэг хүрээнд ялангуяа Батжаргал гишүүний хөндсөн, бид нар өсвөр мал бордох ийм арга ухаан дээр нэлээн сая төвлөрөөд энэ сүүлийн 6 сар нэлээн хэдэн судалгаанууд, туршилтууд хийгдсэн. Ер нь бог дээр тооцоо хийгдээд ямар тэжээлээр, ямар уураг тэжээлээр, ямар эрдэст минералыг нэмж өгөөд ямар хугацаанд тэр гүзээ хөгжүүлэлт буюу тэр зөв нормоор тэжээвэл ямар үр ашиг гарах вэ гэдэг судалгаанууд хийгдсэн. Малчдын орлогыг, одоо байгаа олж байгаа орлогыг нь 3 дахин нэмэгдэх ийм бололцоо тооцоо гараад байна. Үүнийгээ бид нар энэ жилдээ эцэслээд ер нь ирэх жилээс улсын хэмжээнд тэр чигт нь энийг албан ёсны бид нар сурталчлах арга хэмжээ болгож хийнэ. Ингээд бид бүгдээрээ газар тариалан, мал аж ахуй хамт хосолдог, үр дүнд нь нөгөө өсвөр малаа борддог экспортын хамгийн үнэтэй тэр Арабын зах зээлд олон сая малыг бид нар гаргах бололцоотой. Үнэхээр Сэргэлэн сайд энд ажилласны үр дүнд бид нар Арабын 4 оронд хамгийн үнэтэй махны зах зээлд монгол мах гарч чадсан. Очсон мах 3-аас 4 хоногийн дотор л бүрэн дуусаж байна ер нь. Эрэлт их өндөр байна. Хамгийн гол нь та нар тогтвортой нийлүүлэлтийг хийж чадах уу гэдэг асуудлаар бид унаж байгаа юм.

Иймд энийг шийдэхийн тулд тэжээлийн баазаа нэмье. Өсвөр мал бордох ийм арга ухаанаа тодорхой болгоё, жор тэжээлийнхээ юмыг үндсэндээ гараасаа

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гаргачихлаа. Одоо ингээд бүс нутгийн хэмжээнд туршилт болгож хийх, түрүүчийн зарим сумуудаар нь, малчдын бүлгээр нь, хоршоодоор нь туршилтууд эхэлчихсэн явж байна. Энэ чинь 1, 2 туршилт биш шүү дээ бид нар. Мянга, 10 мянга хүртэл толгой хонин дээр, 100 мянга хүртэл толгой хонин дээр туршилтууд явагдаж байгаа, эхэлж байна. Энэ л бид нарын энэ нүүдлийн мал аж ахуй, үүн дотор хонь, ямаан дээр их том махны экспорт дээр их том бололцоо гарч, малчдын орлогыг их нэмэгдүүлэх том зүйл болно. Ноолуураа ингээд боловсруулах түвшнээ сайжруулаад бид нар 100 хувь самнадаг болчиход манай ноолуурын үнэ тогтоод байнгын өсөлттэй болчихно.

Махаа экспортын маягаар ингэж тэжээдэг, борддог ийм арга ухаанаа өөрчлөлт оруулаад тэжээлийнхээ таримлаа нэмэгдүүлээд явчихаар малчдын орлого маань үндсэндээ сайжирчихна. Ингээд дээрээс нь сүү үйлдвэрлэлийг эрс мэдүүлэх шаардлагатай. Сүү 60 хувь бараг сүүн бүтэн импорт байна. Тэгэхээр сүүн дээр явж байгаа урамшуулал, энэ сүүний гарцыг нэмэгдүүлэх, сүүний чиглэлийн үхрийн, ямааны тоог нэмэх гээд ийм ажлууд байгаа. Ингээд л энэ болгон хийх ажил маш их байна. Тэгээд л нөгөө хөнжлийнхөө хэрээр л, байгаа төсөв хөрөнгийнхөө хэмжээнд л байна шүү дээ. Нөгөө талаар бүтцийн өөрчлөлтийг зайлшгүй.../минут дуусав./

Б.Бат-Эрдэнэ: Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Дараагийн нэг зүйл энэ махны экспорт, дотоодын хэрэглээ, хангалтыг бид зохистой уялдуулахгүй бол болохгүй болчихоод байгаа юм. Дотоодын үнээс хямд үнээр гадагшаа мах экспортолдог юм байхгүй. Тийм учраас тэр аж ахуйнуудтай ер нь экспортын махны доод түвшний асуудал ярьдаг тэр нь үнээр нь татварын асуудал нь явдаг байх ёстой хамгийн багадаа.

Дээр нь энэ мах экспортолж байгаа аж ахуйнууд дотоодын хэрэглээ хангалтад нь тодорхой хувь зааж үүрэх ёстой. Тэгж байж энд төв суурины иргэдийг чанартай бас арай тогтвортой үнээр махны хангалтыг хийх бололцоо байгаа. Үнэхээрийн энэ малчид иргэдийн бий болгосон жаал нөөц боломжийг аж ахуйнууд гадагш нь гаргаад тодорхой үр дүн хүртэж байгаа бол буцаагаад энэ төв суурины иргэдийн өмнө нийгмийн хариуцлагынхаа хүрээнд бас бололцоотой үнээр.../минут дуусав./

Б.Бат-Эрдэнэ: Нэмэлт минут авах уу? Та Батжаргал гишүүний микрофоныг нээе.

Ж.Батжаргал: Энэ зохицуулалтыг нийслэлтэй хамт манай яам, Хөдөө аж ахуйн яам ярьж шийдлийг нь олж өгөөд тэгээд энэ төв суурины нөөцийн махнаас жоохон холдуухан махныхаа экспорт, үнийг түвшнийг өсгөх тал руугаа гол бодлогоо чиглүүлээд яам маань явахгүй бол нэг гараараа махны экспорт, мал аж ахуйн хөгжил яриад нөгөө гараараа үнэ тогтворжуулах тухай юм яриад ингээд зодолдохоор зэрэг болохгүй 2 юм нийлүүлчхээд болж өгөхгүй байгаа юм л даа. Ер нь олон жил тэгж явсан. Энэнээсээ л хэдүүлээ бүрэн салах ёстой. Нийслэл рүү 2 жилийн өмнөөс эхлээд албан ёсоор нөөцийн махных нь юмыг чиглүүлсэн. Одоо харин үүнийг нь тэр мах экспортлогч аж ахуйн нэгжүүдтэйгээ уяж, холбож өгөөд энэ зохицуулалтыг нь бүрэн хангаж өгөөд л орхих нь зөв л гэж би ийм л юм бодоод байна. Энэ тал дээр манай яам ямар бодол байна вэ?

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бат-Эрдэнэ: 6 номер, Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ бас л нөгөө тогтолцооны алдаа гэдэг шиг л юм байдал яг сая их тод анзаарагдсан. Яам мах бэлтгэх нь зохисгүй, энэ асуудалд оролцох нь хэрэггүй гээд орон нутгуудад өгчихсөн нөөцийн асуудлууд. Тэгээд саяын энэ жил нийслэл Улаанбаатар дээр махны үнэ инфляцад нөлөөлөх хэмжээнд үүсээд тэгээд засаг яаралтай зохицуулалтын арга хэмжээ хийж, бид нар нөгөө экспортод бэлдсэн махнаасаа тодорхой хэмжээг энд нийлүүлж хийж байж аваад гарчхаж байгаа юм буюу яг Батжаргал гишүүний хийдэг зохицуулалтыг экспорт дотоод хангалт хоёроо нэг аваад явахад бид нар үнийн тогтвортой байдлыг бариад гарчих бололцоотой. Нөгөө улаан буудай, гурил дээр мөн адилхан шүү дээ. Баруун бүсэд үнэтэй байлгахгүйн тулд бид тэнд тариалалт, үйлдвэрлэл бий болтол дотоодын үнийн зохицуулалтаараа баруун талаа үнийн бодлогыг нь бариад ингээд нийгэмд тийм асуудал үүсгэхгүйгээр аваад явчих бололцоо байгаад байдаг. Тэгэхээр ийм уялдаанууд их тус тусдаа, салгаад салгаад салгаад ингээд хэрчээд хэрчээд тайраад тавьчихсан ийм байдал анзаарагдаж байна.

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Экспортод мах гаргаж байгаа аж ахуйн нэгжүүдтэйгээ гэрээ хийж байгаа бодлогын гэрээ бэлдсэн махны 10 хувийг шаардлагатай нөхцөлд дотоодын үнэ тогтворжуулах дотоодын махны хангалт нь дайчилна гэсэн гэрээтэй явж байгаа.

Гэхдээ аль болох тэрийг хөндөхгүй байхыг хичээж байгаа. Орон нутаг ажлаа хийчихвэл энэ чинь ингээд л байх ёсгүй ажил шүү дээ. Эсвэл нэг мөр наашаа зохицуулалт өгөөд тэр экспорт талдаа энэ дотоод нийлүүлэлттэй хамт уялдуул гэвэл үүрэгтэй байдаг. Яамны үүрэг ерөөсөө экспорт, зах зээл, тэр валютын орлого бий болох аль болох л гаралтыг л нэмэгдүүлэх ийм бодлогын төлөө явж байгаа шүү дээ.

Б.Бейсен: Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор их олон ажил хийсэн юм байна. Саяхан ч бас заримыг нь хийсэн байх. Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн хурлаар экспортлох импортлох мах, махан бүтээгдэхүүний тоо хэмжээгээ ярьсан юм байна. 22 оны 10 сараас эхлээд мах, махан бүтээгдэхүүний экспортод тоо хэмжээ тогтоохгүй байгаа юм байна. БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлох 9 аж ахуйн нэгжийг 23-24 онд бүртгүүлжээ гэх мэт танай танилцуулгад 5 ажлыг дүгнэж бичсэн байна л даа. Ингээд экспортолж байгаа мах, махан бүтээгдэхүүнийхээ тоо хэмжээг харахаар 23 онд 80.4 мянган тонн, 24 онд 71.1, тэгээд 25 онд хэдийг экспортлохоор төлөвлөж байгаа юм бэ гэхээр 72.3 мянган тонн мах экспортлохоор урьдчилсан тооцоолжээ гэсэн байх юм.

Тэгэхээр энэ хийж байгаа үйл ажиллагаа маань 1.2 мянган тонн мах, махан бүтээгдэхүүний экспортын өсөлтийг 25 онд бий болгохын тулд хийгдэж байгаа юм шиг л яг танай танилцуулга уншигдаад байна л даа. Тэгэхээр сайд ер нь манай яг багтаамж нь хэд юм? Одоо энэ бүх үйл ажиллагаа, 5 үйл ажиллагааны хэрэгжилт нь хангагдаад ирэхээр хэд болох юм бэ? Цаашаагаа ер нь энэ хэчнээн хувийг дэлхийн зах зээлд хэтэрхий хол байж магадгүй хангах боломжтой юм бэ? Яг

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

танилцуулгаас болохоор ноос, ноолууран бүтээгдэхүүнээ болохоор манайх яг тэдэн хувийг нь дэлхийн зах зээл дээр хангаж байна гэнгүүтээ махан дээр ирэнгүүт нэлээн тийм дүгнэлтүүд сул оргиод явчихдаг юм байна. Тэгээд яг энэ 25 оны 72.3 мянган тонн нь хэдээр өсөх боломжтой юм? Ер нь дэлхийн зах зээл нь хэд байдаг юм гээд яг Байнгын хорооны гишүүдэд тодорхой мэдээллийг хэлээд өгөөч ээ.

Б.Бейсен: Сайд хариулах уу? Хариулъя.

Ж.Энхбаяр: Махны экспорт дээр ингээд нэлээн урт хугацааны ажлын үр дүнд ийм үр дүнгүүд гараад би нэгдүгээрт мал эмнэлгийн байгууллагын ажлын үр дүн, малын вакцинжуулалт, дотоодын малын эм бэлдмэл, вакцины үйлдвэрлэл, түүний чанарын асуудал ийм олон зүйл нөлөөлж байж ингээд гэрээ хэлэлцээр хийж байж бид урагшилж байгаа юм.

Бид нарын нөгөө боломж 180-аас 200 мянган тонныг гаргана. 10 хүртэл, 10 сая толгой мал экспортлох бололцоотой байна. Энэ жилийн танд өгч байгаа тоо чинь жилийн эцсийн нөгөө малын тоо буюу 57.6 сая малчдаас тооцоод хийгдэж байгаа юм. Ийм бодитой 70 мянган тонн, 70-аас 80 мянган тонн доор байна.

Энэ жилийнхээ нөгөө хаваржилтаа авна, төлөө харна, зун зуншлага буюу малын тарга тэвээрэгтэй холбоотойгоор боломж яаж гарах нь вэ, нөгөө тэжээлийн таримал ургамалтайгаа холбоотойгоор гарна. Тэгэхээр хамгийн минимум буюу 70-аас 80 буюу 300 сая доллар, дээш нь бид нар 180 буюу 600, 700 сая долларын мах экспорт бололцоотой байна. Жоохон тэжээл дээрээ анхаараад тэжээлийн таримлаа жоохон нэмчихье. Мал тэжээх арга ухаанаа малчдаа жоохон сургаад өсвөр мал жоохон бордоод экспортлох хугацаагаа, мал бэлдэх хугацаагаа жоохон уртасгаад ингээд нэг ухасхийхэд бид нар маш богино хугацаанд энэ махны зах зээлийг бид нар боломжийн түвшинд одоо байгаагаасаа 2, 3 дахин хэмжээнд үндсэндээ тэрбум доллар гэсэн л амбицтай байгаа. Тэрбум долларын махны экспорт хийдэг ийм чадавхтай болно. Энийг хийхийн тулд бид нарт мэдээж ахиад хэлье мал эмнэлгээ сайжруулмаар байна, биокомбинатын асуудлыг сайжруулмаар, лабораторийн чадавхаа нэмэгдүүлэх хэрэгтэй байна. ингээд малынхаа үржил шимийг сайжруулах, ашиг шимт малын тоогоо нэмэх хэрэгтэй, үржил селекцийн бодлого, тэжээлийн таримлын нэмэгдүүлэх, ингээд тэжээлийн үйлдвэрүүдийг бид нэлээн энэ жил гэхэд бид 4 үйлдвэр орууллаа. Тэжээлийн буюу уурагт эрдэс тэжээлүүдийг бид нар дотооддоо үйлдвэрлэдэг болж эхэлж байна. Энэ маань их томоохон үр дүнгүүдийг ирэх жилүүдэд дагуулна. Мал 1 сар, 2 сард мал таргалах, тарга тэвээргээ алдахгүй байх ийм боломжийг энэ тэжээлийн үйлдвэрүүд, тэр тэжээл бүрдүүлж эхэлж байна. Манай үндэсний энэ эрдэмтэд энэ жорыг бүтэн зохиогоод үндсэндээ эцэслэлээ батлаад туршаад амжилттай болж байна. Тэгэхээр мал, махны чиглэл дээр нэлээн их үр дүн гарах байх. Энийгээ дагаад мал маллах, фарм байгуулах, янз янзын энэ сонирхол хөдөлгөөн хотоос хөдөөг зорих ийм залуучууд бас нэлээн их их болж байна. Ер нь их өөдрөг л юм байна даа, эрэгдүү л байна. Тэгээд сүү, махны зах зээлд бид нар дөнгөж л идэвхтэй дөнгөж орж, сэргэж байгаа болохоор бас нарийн ширийн гадаад махны том зах зээлийн юман дээр тоо баримт дутуу байгаа. Энийгээ бид нар гүйцээгээд дараагийн танил.../минут дуусав./

Б.Бейсен: Замира гишүүн асуулт асууя.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

С.Замира: Баярлалаа. Энэ бүх салбарт нь тогтолцоо нь буруу байна гээд ярьж байгаа биз дээ сайд аа? Энэ тал дээр урьд өмнө Засгийн газар ч юм уу, Их Хурал дээр танилцуулга хийсэн үү та? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт мах сайн экспортолж байгаа юм байна. Ер нь махны экспорт сайжирсан байна. Тэгэхдээ концерв хийх, халал хиам хийх тал дээр анхаарч ажиллаж байна уу? Түүхий мах ингээд гаргаад байснаас эцсийн бүтээгдэхүүн гаргаж экспортолбол арай бид нар бас нэлээд валютын нөөцтэй болно шүү дээ. Энэ 2 асуулт.

Б.Бейсен: 6 номер, Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Гарч байгаа махны маань гол хувь нь дандаа боловсруулсан мах гараад байгаа юм. Дулаан аргаар боловсруулна гэдэг маань янз бүрийн хэлбэрээр боловсруулалт хийгдсэн, консервлосон гэсэн үг шүү дээ. Тэгэхээр боловсруулалт консерв хийж байгаа үйлдвэрүүдийн байдлууд сайн байна. Нөгөө талаар халал стандартыг манай махны гол үйлдвэрүүд үндсэндээ бүрэн нэвтрүүлээд дууссан, баталгаажчихсан. Одоо бид хамаг махны хамгийн үнэтэй зах зээл тэр Арабын зах зээл, Арабын 4 орон, Ойрх Дорнодын орнуудад манай мах ямар асуудалгүй гарч байгаа. Холбогдох бүх гэрээ, хэлэлцээрүүд нь хийгдээд явж байгаа. Яг нөгөө уламжлалт консерв бол ОХУ л чиглэл рүү нэлээн их явж байна.

Тогтолцооны асуудал үндсэндээ голцуу хуультай холбоотой хуульчилсан. Тэгэхээр Байнгын хороо Их Хурлын түвшинд нэлээн асуудлуудыг шийдэх хэрэгтэй болоод байгаа юм асуудлууд байна. Тэгэхээр энэ дээр Байнгын хорооны гишүүд маань бид хэд хэдэн хуулийн төслүүдийг боловсруулсан гишүүддээ өгөөд өргөн бариад хэлэлцүүлэх ийм хүсэлтэй байгаа.

Ж.Энхбаяр: Замира гишүүн тодруулъя.

С.Замира: Халал калпса гэж байдаг шүү дээ хиам. Энэ ямар учиртай гэхээр нь гадаадын улсууд чинь өндөр үнээр авна л даа энийг. Энийг гахайны мах оролцуулахгүйгээр, өгөх тос холихгүйгээр хонины сүүлээр тэгээд мах яагаад л халал хиам хийдэг л дээ. Энэ мусульман шашинтай орнуудад их байдаг юм. Манай Монгол оронд энэ байхгүй. Бүх юм нь гахайтай холилдсон юм авъя гэхээр нь боломж байхгүй. Манай дотооддоо ч гэсэн энийг авах сонирхолтой зөндөө хүн байдаг юм. Тийм учраас энэ тал дээр ямар бодлоготой байна гэж асуусан юм.

Б.Бейсен: 6 номер, сайд харуулъя.

Ж.Энхбаяр: Бидний бодлого нөгөө хүнсний хувьсгал. Атрын-4 дандаа хүнсний үйлдвэрүүдийг дандаа оруулж яваа. Тэгээд яг энэ мал, мах, үр тариа, төмс, хүнсний ногоо боловсруулах үйлдвэр рүү юм хийе ээ гэсэн бол тэр хөнгөлөлттэй зээлд л хамрагдах бололцоо буюу бид нар тэр эх үүсвэрийг нь л олж өгч байгаа юм. Тэгэхээр ийм яг таны хэлдэг энэ халал хиам үйлдвэрлэх хүсэл сонирхолтой аж ахуйн нэгж тэр хүсэлтээ гаргаад хандаад явахад орон зай их бэлэн байгаа шүү. Яг өнөөдрийн байдлаар манайхаас 19 орон мах импортолж байгаа, 7 оронд малын дайвар бүтээгдэхүүн өлөн гаргаж байгаа ийм тоо байна.

Б.Бейсен: Мандхай гишүүн асуулт асууя.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

М.Мандхай: Би сайдаас болон яамны төлөөллөөс 3 асуулт асууя. Одоогийн байдлаар бас 9 аж ахуйн нэгжүүд Хятад руу мах экспортлох ийм зөвшөөрлөө авчихсан явж байгаа гээд түрүүн статистик тоо байсан. Одоо яг ямар асуудал үүсээд байна гэхлээр аж ахуйн нэгжүүд Хятадын талд, Хятад руу яг махаа борлуулъя гэхлээр олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ шаардагдаж байгаа. Энийг болохоор манай Мал эмнэлгийн газар болохоор цахимаар хийдэг болчихсон.

Гэтэл нөгөө цахимаар нөгөө систем дээрээ бүртгүүлээд ингээд олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг авъя гэхлээр цахим дээрээ ачаалал үүссэнээс болоод аж ахуйн нэгжүүд гэрчилгээгээ авч чадахгүй гацаад энэнээс болоод борлуулалтаа хийх асуудал удааширч байгаа асуудлыг энэ аж ахуйн нэгжүүд тавиад эхэлсэн. Тэгэхээр энэний асуудлыг яаж эрчимжүүлэх вэ? Тэр цахим системийн тэр гацаж байгаа, удааширч байгаа асуудлуудыг энэ цөөхөн хэдэн компаниудын асуудлыг даруй шийдэж өгөх боломж байна уу?

Хоёрдугаарт Арабын булангийн 6 улс руу одоогийн байдлаар 2 үйлдвэрүүд л халал аргаар мах борлуулах боломжтой зөвшөөрөл авсан байгаа. Траст трейд, нөгөөх нь Дорнодын махны компани байгаад байгаа юм. Ямар асуудал үүсэж байна гэхлээр зөвшөөрлөө аваад, хөрөнгө оруулалтаа халал аргаар үйлдвэрээ байгуулаад хөрөнгө оруулалтаа хийчихсэн мөртөө бизнесийн асуудал нь юу гэхлээр нөгөө бизнесүүдтэйгээ ийм харилцаа тогтоогоод явах шаардлага байгаа байгаад байгаа юм. Тэгээд тэр бизнесүүдийнх нь тэр гарц, бизнесүүдийг нь нээж өгөх, тэр бизнес түншлэгчтэй нь уулзуулж өгөхөд манайд байгаа Кувейт ч гэдэг юм уу энэ Элчин сайдуудыг идэвхтэй ажиллуулаад эсвэл яам бүр өөрөө яг энэ бизнес хоорондынх нь энэ уулзалтуудыг нь зохион байгуулж өгөх ажил ялт ч үгүй бас хэрэгтэй байна. Тэгэхгүй бол аж ахуйн нэгжүүд зөвхөн зөвшөөрөл авснаараа шууд энэ Арабын булангийн 6 улс руу очоод өөрсдөө бизнесээ олоод явахад бас хүндрэл байгаа. Олон улсын бас тодорхой түвшинд Засгийн газрын дэмжлэг, эсвэл энэ элчний оролцоо бас зайлшгүй хэрэгтэй байгаа гэдэг асуудлыг ярьж байгаа. Тийм учраас энэ дээр яамны зүгээс анхаарч ажиллаач ээ. Энэ зөвшөөрөл авсан компаниуд хөрөнгө оруулалт хийчхээд борлуулалтаа хийж чадахгүй учраас зээлээ төлөөд ингээд бас алдагдалд орох ийм эрсдэл байгаад байгаа учраас энэ харилцаа, түншлэлийн асуудлыг нь бас яамны зүг, бас ЭСЯ, ГХЯ-тай яриад яаралтай энэ түншлэлийн асуудал дээр нь тусалж, дэмжээд ажиллаж өгөөч ээ гэсэн асуудлыг хэлж байгаа.

Хоёрдугаарт манай дээр болохоор өлөнгийн бизнес нэлээн эрчимтэй явж байгаа. Өлөнг хаядаг ч гэсэн нөгөө талдаа Хятадууд ороод ирчихсэн үйлдвэр байгуулаад, хөрөнгө оруулчихсан.../минут дуусав./

Б.Бейсен: Мандхай гишүүн гүйцээж асууя.

М.Мандхай: Өлөнгөөр анх Хятадын зах зээл рүү борлуулалтаа хийгээд нэлээн ашигтай ажиллаад 2 дахь үйлдвэрээ байгуулах гээд 30-аад тэрбум төгрөгийн зээл ингээд босгох гээд явж байгаа үйлдвэртэй уулзаж байсан. Одоо манай махны үйлдвэрүүд юу гэж байгаа вэ гэхлээр дайвар болон ясны тос гаргах Хятад руу гарах боломжтой гэж байгаа. Тэгэхлээр энэ Хятад Улс руу энэ эдгээр бүтээгдэхүүнийг дайвар бүтээгдэхүүнийг Хятад руу гаргах зах зээлийг бас энэ яам бодлогоор дэмжиж өгмөөр байна. Энэ дээр ер нь ямар нэгэн хэлэлцээрийн ажлууд

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хийгдэж байгаа юу? Энэ дайвар бүтээгдэхүүнийг гаргах, ясны тосыг гаргах дээр бас судалж үзсэн үү? Энэтэй холбоотой асуултыг хариулж өгөөч ээ.

Б.Бейсен: 7 номер хариулъя.

Д.Довчинсүрэн: Сайн байна уу? Мандхай гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн байна.

Энэ цахимаар олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний асуудал яригдаж байна. Энэ гаалийн байгууллагаас гаалийн байгууллагад олгогддог байсан мал, амьтны эрүүл мэндийн гэрчилгээ маань өөрчлөгдөөд одоо яг энэ Мал эмнэлгийн ерөнхий газарт маань олгодог болсон. Энэтэй холбогдуулаад цахимын асуудлууд нэлээн яригдаж байгаа. Өнөөдөр бас бид нар бас Хятадын талтай бас цахим уулзалтуудыг хийгдсэн нэлээн нааштай байгаа. Асуудлуудаа тодорхой болгочихсон байгаа. Тийм учраас яг энэ экспортын асуудлууд хэвийн явагдахаар болоод өнөөдөр тохиролцоонд хүрсэн.

Энэ халаар аргаар мах, махан бүтээгдэхүүн экспортод гаргаж байгаа 2 компани гэж та хэллээ. Нийтдээ 17, 8 компаниуд байгаа. Сая энэ 2024 онд болохлоор Монголын стандартын байгууллага халал стандартын Дэн холбоо эд нар гэх мэтчилэн 3 холбоо болохлоор энэ халал стандарт олгодог тийм эрхийг нь авчихсан. Тийм учраас Монголын аж ахуйн нэгжүүдээс тандалтын шаардлага хангуулах гээд энэ халал стандартын шаардлага хангуулах гээд сая таны хэлдэг 2 компани эрхээ авчихсан. Бусад компаниуд нь энэ яг энэ халал-ын стандарт нь урьд нь авчихсан байгаа. Тийм учраас 17 аж ахуйн нэгж бол яг энэ чөлөөтэй экспортод гараа явж байгаа.

Энэ дайвар бүтээгдэхүүний асуудлууд байна. Бид нар 2024 онд БНХАУ-ын Гаалийн ерөнхий газартай уулзалт хийгээд адууны түүхий эд дайвар бүтээгдэхүүний экспортод гаргая гэдэг саналаа тавьсан. Хятадын тал нэлээн нааштай хариу ирж тэгье гэдэг дээр санал тавьсан. Тэгээд энэний үндсэн дээр бид нар протоколынхоо төслийг бэлдээд Хятадын талдаа хүргүүлчихсэн байгаа. Мөн дулааны аргаар.../минут дуусав./

Б.Бейсен: 7 номер гүйцээж хариулъя.

Д.Довчинсүрэн: Мөн дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны дайвар бүтээгдэхүүнийг экспортод гаргах гээд бас Хятадын талтайгаа тохирсон. Эхний байдлаар бид нар төслөө, хорио цээрийнхээ протоколын төслийг хүргүүлсэн байгаа. ГХЯ-аараа дамжуулан хүргүүлсэн байгаа. Хятадын тал болохлоор судалж үзээд эргээд хариу өгөх хугацаа нь ингээд өгсөн байгаа. Тийм учраас энэ жилдээ бас энэ адууны махны дайвар, энэ дулааны боловсруулалт хийгдсэн мах, махан бүтээгдэхүүний дайврууд маань экспортод гарах боломжтой болох болов уу гэсэн тийм горьдлоготой байгаа.

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Халал аргаар нөгөө үйлдвэрлэх стандарт гэж ярьсан. Гэхдээ үйлдвэрлэгч нарын яриад байгаа асуудал ийм байхгүй юу. Өөрсдөө шууд Араб руу очоод зах зээлээ нээгээд борлуулах, худалдан авагч олоход амаргүй учраас энийг

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ядаж бодлогын түвшинд яам өөрөө энэ худалдаа хэлэлцээрийг нь нээж өгөх бизнесүүдийг энэ бас Монголын энэ үйлдвэрлэгчтэй холбож өгөх ажлыг хийж өгөөч ээ, энэ дээр дэмжиж өгөөч ээ гэдэг асуудлыг хөндөж байсан. Тэгээд энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ гэж асуух гэсэн юм.

Б.Бейсен: 6 номер, сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Одоо ингээд яриад байхаар хөдөө аж ахуй үндсэндээ гадаад харилцааны асуудал байгаа биз. Бүх юм гадаадтай холбоотой. Зайлшгүй зах зээлийг нь тэлэх, олон улсын гэрээ, хэлэлцээр, протоколыг хийх, олон улсын үүссэн худалдаанд тэр гаргах, брэнд хөгжүүлэлт гээд дандаа гадагшаа л байгаа юм. Тэгээд 26 онд анхаараач ээ гэж хүсэлт байгаа юм. Ер нь манай энэ гадаад томилолт, бүх арга хэмжээ чинь тэг байгаа шүү дээ. Хөдөө аж ахуйн яамны гадаад арга хэмжээ ямар хамаатай юм гээд л хассан. Тэгэхээр энэ үнэхээр хөдөө аж ахуйн салбар гэдэг бол ерөөсөө л гадаад харилцаанд тулгуурлаж байгаа юм.

Нөгөө талаар бид сая бодлогын юм гарч байгаа. Юмнуудаа манайх Гадаад худалдааны хууль байхгүй, ер нь худалдааны хуульгүй байгаагийн улмаас Гадаад яамаараа манайх дамжуулаад энэ аж ахуйн нэгж мах гаргах гэсэн юм гэдэг л ийм ийм маягтай л явж байна шүү дээ. Тэгээд нөгөө талаас байгууллагууд ирж хяналт шалгалт хийнэ, магадлан итгэмжлэн стандарт хангасан эсэх дээр үнэлгээ хийж байж зөвшөөрөл.../минут дуусав./

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Өнөөдөр чухал 2, 3 асуудлуудыг хэлэлцэж байна махны экспорттой холбогдолтой асуудал дээр Монголчууд Хүнс, хөдөө аж ахуйн яам бидний хувьд бас сүүлийн жилүүдэд нэлээн үр дүнтэй бас ажлууд хийгдээд ингээд явж байгаа. КОВИД-ын дараах экспорт 4, 5 дахин нэмэгдэх энэ боломжууд бас бий болгоход хүнсний хувьсгалын том хөтөлбөр, дээрээс нь энэ квотыг олгодог байсан асуудлыг бүх төрлийн махан дээр нээлттэй болгосонтой холбогдолтой энэ асуудлууд бас байгаа.

Цаашдаа эрүүл ахуйн асуудлын тухай бас сайд ярьж байна. Өнөөдрийн байгаа энэ бас гаргаж байгаа үр дүнгээ цаашдаа ахиулах тал дээрээ бид бүхэн бас анхаарах, ухарсан тодорхой тооны квот бий болгох, хязгаарлах тухай асуудал бас цагаан сарын өмнө та бас хэвлэлийн хурал хийгээд мэдэгдээд авсан. Тэгээд энэ байгаа байдлуудаа цаашдаа бас яг талдаа гаргаад жилийн 4 улиралд экспортлох, яг та бүгдийн саяын ярьж байгаа тасралтгүй экспорт дээр хязгаарлалт тавиагүй ээ гэдэг энэ байр сууриа хадгалж явах нь туйлын чухал шүү гэдгийг би бас үгийнхээ түрүүнд бас дахиад сануулаад хэлье ээ гэж бодож байна.

80.4 мянган тонн 2024 онд гаргасан энэ махны экспорт 70 мянга руугаа бас бууж байгаа тодорхой энэ асуудлууд дээрээ дүгнэлт гаргаад бид нар улам ахиулах, нэр төрлөө нэмэгдүүлэх энэ чиглэл рүүгээ анхаараад явах тал дээрээ бид нар энэ үзүүлэлтүүдээ өсгөх энэ байдлаар харагдах ёстой.

Хүнс, хөдөө аж ахуйн яаман дээр яригдаж байсан энэ хамгаалагдсан аж ахуйн тухай энэ асуудал, сайдын журам гараад тодорхой түвшинд бид бүхэн энэ хамгаалагдсан аж ахуйгаас түүхий махыг экспортлох тухай ийм зорилт тавиад ажиллаж байгаа. Энэ журам батлагдсан уу? Үүнтэй холбогдолтой аж ахуйн

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нэгжүүд хэлцлүүд хийгдээд явж байгаа ажлууд байна уу? Ялангуяа энэ БНХАУ-тай бид бүхэн протоколтой байгаа. Энэ протоколын дагуу бид нар дулааны аргаар боловсруулсан махыг одоогоор экспортод гаргаж байгаа. Гэтэл үндсэндээ энэ протоколын энэ хорио цээрийн энэ шаардлагаа ахиулах дараагийн шатны боломжууд, энэ урагшлах боломжуудын тухай бас бид нар нэлээн бага яриад байна. Тэгээд энэ чиглэл дээр бас яг тодорхой ямар алхмууд хийгдэж байна? Ялангуяа тэр дэд сайдуудын хоорондын протоколыг 2 жил тутам шинэчлэх ёстой энэ асуудлыг бас бүүр урд хөрштэй ямар түвшинд ярьж байна вэ? Дулааны аргаар боловсруулсан махны энэ шат дамжлагыг ахиад ахиулах тухай асуудал чухал байна. Шинээр боомтууд нэмэгдсэн үү амьдаар болон энэ бусад хэлбэрээр явагдаж байгаа асуудал дээр? Тэгээд энэ бүсүүд экспортын ийм гарцтай болох, мал аж ахуйн түүхий эд бүтээгдэхүүнээ махаа өөрийнхөө бүсээс экспортлох тухай энэ сонирхлыг маш ихээр бас илэрхийлж байна. Үүнтэй холбогдолтой ямар ажлууд бас төлөвлөгдөж байна? Цаашдаа эрчимжүүлэхэд их чухал ажлууд болов уу гэсэн ийм саналууд асуултууд байна.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 5 номер хариулъя.

Ц.Болорчулуун: Ганхүлэг гишүүн гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун.

Тэгэхээр ер нь экспорт, тэр дундаа махны экспорттой холбоотой асуудал энэ хамгаалагдсан аж ахуйгаас бид Монгол Улсын хэмжээнд бэлчээрийн мал аж ахуйтай 70 орчим сая толгой малтай бүгд бүс нутгийн хувьд эрүүл гэж олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, зөвшөөрөгдөх хугацаа маань бас төдийлөн боломж хомс байгаа учраас бид нар энэ хамгаалалттай аж ахуйг олноор байгуулж, тэндээс махны экспортыг гаргах энэ бааз бид нарын тэргүүн зэрэгт тавьж байгаа ийм бодлого. Тэгээд энэнтэй холбоотой бид нар журам боловсруулаад Хууль зүйн яаманд бүртгүүлэхээр хүргүүлсэн боловч бүртгэгдээгүй байгаа. Саяхан харин энийг би эргэж бүртгэх талаар тодорхой хариу ирж байгаа учраас энийгээ бүртгүүлээд мөрдөөд явах энэ боломж нь бүрдэнэ гэж харж байгаа.

Ер нь бол бид хөдөө аж ахуйн тухай хууль анхдагч хуулийг боловсруулахаар бас холбогдох нэр бүхий гишүүдтэй хамтарч ажиллаж байгаа. Энэ хуульд энэ бүс, бүсчлэлийн тухай асуудлаа тодорхой оруулаад өгье гэсэн ийм тодорхой зорилтуудыг дэвшүүлээд хуулийн төсөлд энийг хууль боловсруулах шатдаа саналуудаа гаргаад ингээд явж байгаа. Ер нь цаашдаа бид ийм бүсчилсэн байдлаар экспортыг хийх, хамгаалагдсан аж ахуйн нэгжүүдийн хамгаалсан аж ахуйгаас мах экспортлох боломжийг бүрдүүлэх энэ хуулийн зохицуулалттайгаар явна гэсэн ийм байдлаар ажиллаж байгаа.

БНХАУ-тай хэд хэдэн асуудлаар санал солилцож, нот бичиг солилцож байгаа боловч дорвитой хариу бас хүлээж авч чадахгүй байгаад байгаа. Тухайлах юм бол бид дэд сайдын түвшний уулзалтыг даруйхан хийе. Түүнчлэн саяын яриад байгаа хэд хэдэн дайвар бүтээгдэхүүн бусад хэд хэдэн таримлын төрлөөр хорио цээрийн протоколд тохиръё гэсэн энэ асуудлуудыг удаа дараа дэвшүүлж байгаа. БНХАУ-д суугаа ЭСЯ-аараа дамжуулаад ажиллаж байна. Энэ дээр бас тодорхой дорвитой алхмууд гарах байх гэж бодож байгаа. Тийм учраас энэ дээр бас хөндөгдөж байгаа асуудлын нэг нь энэ экспортын боомтын тоог нэмэх асуудлуудыг бас тавьж байгаа. Энэ асуудлуудаа нэлээд шийдэх тал дээр ажиллаж байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгээд бид нар ямар ч байсан энэ 5 сардаа бас сайдын айлчлалыг БНХАУ руу төлөвлөж байгаа. Энэ айлчлалын хүрээнд бас энэ асуудлуудыг шийдэх тал дээр анхаарч ажиллая гэсэн байдлаар ажлаа төлөвлөж ажиллаж байна.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Салбарын сайд маань ер нь цаашдаа энэ хязгаарлалт квоттой холбогдолтой асуудлаараа яг албан ёсны тодорхой байр сууриа илэрхийлчих нь зөв гэж бодож байна. Одоогийн байгаа байр суурийг би бас дэмжиж байна. Гэхдээ хэдүүлээ яг хэдхэн сарын өмнө бид бүхэн Хэнтий аймгийн ер нь зүүн 3 аймгийн бүх багуудаар явж байхад та бас мэдэгдэл хийчихсэн байхгүй юу. Тийм. Тэгээд тэр мэдэгдлийн гол агуулга нь тодорхой хязгаарлалт юмнууд хийнэ ээ, экспорт дээр ингээд түүнтэй холбогдолтой махны үнэ яг тэр сум орон нутаг дээр тэр таны мэдэгдлээс болоод ингээд яг тодорхой түвшинд ингээд барих ийм асуудлууд бас үүсчихсэн юм. Тэгэхээр иймэрхүү ийм 2 үзүүртэй иймэрхүү санаа, агуулгуудыг бас цаашдаа гаргалгүйгээр яг тодорхой байр сууриа хэлж байгаатайгаа адилхан энэ дээрээ ч гэсэн тодорхой байр сууриа хийгээд, нэг талдаа гараад илүү урагшлах алхмуудаа хэдүүлээ бас хийгээд явъя гэсэн ийм байр суурьтай байна.

Б.Бейсен: 6 номер, Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Тийм байна. Тухайн үед Нийслэл Улаанбаатар хотод орон нутгаас ирсэн махыг бөөндөж аваад зуд болсон мал нэлээн хорогдсон тул мах өснө гэсэн хүлээлттэй нэлээн улсууд байсан. Энэтэй холбоотойгоор нэлээн техникийн зохицуулалтын арга хэмжээг авах шаардлага гарсан, авсан, тогтворжуулсан, нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн. Өнөөдөр нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд нөөцийн мах тогтвортой байнга худалдаалагдаж байгаа буюу махан дээр үнийн хөдөлгөөн гараагүй.

Энэ бодлогын хүрээнд бид нар экспортод гарч байгаа махныхаа тодорхой хэмжээг эх үүсвэр болгож ашигласан. Үйлдвэрүүддээ, нийлүүлэлт худалдаанд гаргасан. Таны хэлдгээр би нөгөө залруулгаа хийгээгүй. Энд албан ёсоор хэлье. Гадаад гэрээ хийгдсэн бүх аж ахуйн.../минут дуусав./

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: 23 онд мал, мах бэлдсэн бүх үйлдвэр аж ахуйн нэгжүүд бүх гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу бүх махаа амжилттай экспортолсон. Ямар нэгэн экспортын хязгаар хийгдээгүй. Үнийн зохицуулалт буюу дотоодын нийлүүлэлтийн асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэж чадсан. Иймд ямар нэгэн хүндрэл гараагүй.

Ер нь цаашдаа ахиад хэлж байгаа нь энэ орон нутгийн мах нийлүүлэлт, мах бэлтгэл, экспортын энэ бодлогыг бас нэг цонхоор явуулбал илүү зөв юм байна гэдэг нь бас энэ дээр анзаарагдсан. Одоо мөрдөж байгаа зохицуулалтаар орон нутаг, Нийслэл өөрөө махаа бэлдэх учиртай. Энэ дээр жоохон алдаа гарсан. Ингээд яам оролцсон, экспортынхоо эх үүсвэрээс гаргаж өгсөн, асуудлыг шийдвэрлэсэн, гэрээгээр хүлээсэн мөнгө, гадаад гэрээнүүд бүрэн биелсэн.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Яагаад тэгж хэлсэн бэ гэвэл тухайн үед малчид малаа үндсэндээ хэрэгцээлээд идшээ хийгээд дуусчихсан, үйлдвэрүүд авах малаа аваад дуусчихсан, ямар нэгэн мал мах дээр үнийн.../минут дуусав./

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Нэрс өгөөрэй. Замира гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя, үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Байнгын хороон дээрээ бид нар бас яг энэ тогтолцоотой холбоотой асуудлаа нэг мөр шийдэж өгөхгүй бол яг ний нуугүй хэлэхэд жоохон хөдөө орон нутагт үнэхээр асуудал, энэ тогтолцоо дээр байна шүү. Хэвтээ, болсон гэж бид нар ярьдаг. Би бас Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байсан. Одоо ч Одонтуяа сайдад яг энэ байгаль орчны асуудал, хэвтээ тогтолцоо гээд орон нутагт байх удирдахтай холбоотой асуудлууд хүндрэлтэй байгаа ний нуугүй хэлэхэд. Энэ тогтолцоо нэг мөр зөв байж чадахгүйгээс улбаатай гажуудлууд маш их гарч байгаа. Өнөөдөр бид нар ууланд нэгдмэл улс, нэг харахаар ингээд холбооны улс ч юм шиг, бүх аймаг нь өөрийн гэсэн далбаатай, эмблемтэй, хүний нөөцийн бодлогоо бид нар тусдаа боловсруулж тогтоох ёстой гээд ингээд яриад байдаг. Яах вэ улс төрчдийн л асуудал л даа нэг талдаа. Тэр хэдэн агентлаг орон нутагт байгаа тэн дээрээ тодорхой хэмжээний томилгоо хийгээд тэр төсөв, мөнгийг нь зарцуулъя л гэсэн бодолтой байдаг юм шиг байгаа юм. Тэгэхдээ бид нар энэ нэгдсэн том бодлого, суурь шинж чанараа харахгүйгээр энэ салбарын хөгжлийг, улс эх орны хөгжлийг харах боломжгүй байхгүй юу. Тэгэхээр бид нар энэ тогтолцоо дээрээ нэлээн сайн Байнгын хороон дээр бас онцгойлон анхаарч, байгаль орчин болон хүнс, хөдөө аж ахуйн энэ салбарын тогтолцоог нэг мөр ойлгомжтой болгох тал дээр Байнгын хороо маань ажиллаад явах ёстой болов уу гэж харж байгаа юм.

Хоёрдугаарт яах вэ тэр өвчин зовлонгийн асуудлыг нэг тийш нь шийдэж чадна. Экспорт гэдэг бол тасралтгүй ханган нийлүүлэлтийн асуудал байхгүй юу. Цаанаас манай Монголоос мах нь амттай байна, сайхан байна, авъя гээд байдаг. Бид нар тасралтгүй нийлүүлж чадах уу, үгүй юү? Энэ бодлогыг Хөдөө аж ахуйн яам ямар бодлогоор гаргаж ирж цаашдаа явуулах юм, аж ахуйн нэгжүүд дээрээ тулгуурласан системээ жишээлэх юм бол зөвхөн нүүдлийн мал аж ахуй малчид дээрээ суурилсан биш. Нөгөө талдаа нөгөө эрчимжүүлсэн мал аж ахуй дээрээ махны чиглэлийн төрөлжсөн, эсвэл кластер гэдэг ямар байдлаараа бид нар цаашаа энэ нийлүүлэлтийн бодлогыг тасралтгүй тогтвортой барьж явах боломжтой вэ гэдэг энэ тооцоо, судалгааг л их сайн гаргаж улс орнуудтай харилцаж явахгүй бол 1 тасарна, 2 тасарна, 3 тасарна тэгээд л манай улсаас махаа авахаа болиод л эхэлнэ.

Гуравдугаарт, Батжаргал гишүүний хэлсэн түрүүн бас хариулсангүй гэж харлаа. Ул нь их чухал санаа хэлсэн. Дотоодод худалдаалагдаж байгаа махны үнээс, дотоодод нийлүүлэгдэж байгаа махны үнээс бага үнээр гадаад руу бид нар яг махаа нийлүүлээд байх шаардлага байгаа юм уу? Энэ дээр ямар бодлого явуулах ёстой юм бэ гээд асууж байсан. Тэгээд энийг бол бид нар бас ер нь цаашдаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хувьд салбарын хэмжээнд бас бодох л ёстой асуудлын нэг. Мэдээж эдийн засгийн суурь асуудалтай холбоотой юмнууд яригдах л байх. Тэгэхээр ийм 3 асуудал дээр бол Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үйлдвэрийн яам маань аль аль талдаа хамтраад ажлаа цаашдаа явах ёстой болов уу гэж харж байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Баярлалаа. Энэ Монгол Улсад одоогийн байдлаар энэ гадаад, дотоод худалдаа бүх юм их алдагдалтай байна л даа. Хулгай ч их байна, хариуцлагагүй гэрээ, хэлэлцээр ч их хийгдэж байна. Зөвхөн хөдөө аж ахуй биш, мал аж ахуй хэлээгүй л дээ би биш бүх салбар дээр. Энэ ямар учиртай гэвэл энэ бүхэл бүтэн том салбарыг дааж явж байсан Худалдаа үйлдвэрийн яам гэдгийг татан буулгачихсантай холбоотой. Худалдаа үйлдвэрийн яам энэ гадаад, дотоодын бүх гэрээ хэлэлцээр, экспорт, импорт бүгдийг нь хариуцаж авч явах ёстой том яам. Энэ юм байхгүй болохоор зэрэг хөдөө аж ахуйн яам газар тариалангаа, хөдөө аж ахуй, мал аж ахуйг авч явах юм уу, худалдаагаа хянах юм уу, тэрийг өргөжүүлэх юм уу энэ бүх асуудлыг ер нь ялгаж салгах нь зүйтэй. Тогтолцоо буруу байна гээд яриад байгаа нь үнэн. Энэ тогтолцооны гажуудал.

Тийм учраас энэ хэрвээ манай Монгол орон эдийн засгаа сэргээе, эдийн засгаа хөгжүүлэе, энэ хулгайгаар энд тэнд алдаж байгаа бүх юмыг хяная гэх юм бол Худалдаа үйлдвэрийн яамаа л сэргээх хэрэгтэй. Тэгж байж хөдөө аж ахуйн яам өөрийн хариуцсан ажилдаа л эзэн болж, сая гишүүний яриад байгаа Арабын орнуудтай бизнесменүүд холбож өгөөч ээ гээд байгаа нь тэр чинь Худалдаа үйлдвэрийн яамны хийх юм шүү дээ. Хөдөө аж ахуйн яам очоод тэр гадаад худалдаан дээр энэ холбогдохгүй шүү дээ. Тийм учраас энэ бүгдийг нь Байнгын хороо маань Их Хуралд асуудал болгох юм уу, яах юм ер нь Хөдөө аж ахуйн яамаа сэргээгээд өгөөч ээ Байнгын хорооны дарга. Энэ тэгэхгүй бол цаашаа явахгүй энэ хэвээрээ л байгаад байна. Эндээс нэг асуудал үүснэ, тэндээс нэг асуудал үүснэ энэ бүгдийг зангидах яам нь байхгүй, хажуугаас нь нэг яамд аваачаад наачихдаг юм. Тэгээд сүүлд бүүр Засгийн газар нь ажил хийгээгүй болоод дуусна шүү дээ. Яам ч ажлаа хийгээгүй болоод. Тийм учраас ийм санал дэвшүүлмээр байна даа. Тэгж байж манай эдийн засаг сэргэх байх. Баярлалаа.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн үг хэлье.

М.Ганхүлэг: Ерөнхий санал бас давхардлаа. Би тэр яг тогтвортой нийлүүлэлтийн тухай л асуудал дээр маш болгоомжтой хэдүүлээ бас хандаж байхгүй хүнсний хувьсгалын төслийн хүрээнд нэлээн олон бас махны үйлдвэрүүд жижиг мал төхөөрөх бас үйлдвэрүүд нэлээн баригдчихсан. Гол бас экспортын гэрээ юмнуудаа хийгээд ингээд явж байх энэ цаг хугацаанд нь санаатай, санаандгүй бас янз янзын байдлаар бас бид нар хязгаарлахтай холбогдолтой асуудлуудыг яриад эхлэхээр бас жоохон асуудлууд бас болохоор байна шүү. Тэгээд энэ тал дээрээ ер нь маш болгоомжтой бас хандах нь зөв шүү гэдэг энэ байр суурийг бас илэрхийлэе гэсэн ийм саналтай байсан юм.

2026 оны улсын төсөвтэй холбогдолтой асуудал дээр аль болох цогцоор нь хараад мал эмнэлгийн гоц халдварт өвчлөлтэй холбогдолтой асуудлаа, Био комбинатын шинэчлэлтэй холбогдолтой асуудлаа бас нэлээн бас цогцоор нь хараад ингээд оруулаад ирээсэй гэсэн ийм бас бодолтой байна. Энэ чиглэл дээр та шаардлагатай ажлын хэсэг нарийвчилсан ажиллах Байнгын хорооноос бас тодорхой дэмжлэг юмнууд авах юмнууд байвал бас ингээд хамтран ажиллая гэсэн ийм бодолтой байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

БНХАУ-д бас болох энэ сайдын айлчлалыг маш өндөр ач холбогдол өгч, цаашдаа ерөнхийдөө бидний гол худалдан авагч бас байх учраас энэ дээр тодорхой бас үр дүнгүүд гарсан ийм бас ажил болоосой гэсэн ийм бодолтой байна.

Ялангуяа өмнөх хугацаанд хэд хэдэн ажлын хэсгүүд ахлаад ажиллаж байсан хүний хувьд энэ дээр бас хамтарч ажиллах иймэрхүү чиглэлээр бас ажиллая гэсэн ийм хэлэлцүүлгийн үр дүнгүүд, бодлууд бас төрж байна. Бусад асуудлууд давхардлаа. Баярлалаа.

Б.Бейсен: Өнөөдөр бас чухал чухал 3 асуудал, 63 дугаар тогтоол, Атрын аян, нөгөө талаар махны экспортын талаар чухал мэдээлэл өгсөн Хөдөө аж ахуйн сайддаа, бас яамныхандаа бас баярлалаа гэж хэлье.

Бид юуны өмнө тэр гурилын импортын татвар тэглэх талын асуудлыг бид өнгөрсөн долоо хоногийн даргын дэргэдэх зөвлөлөөр хурал дээр бас хэлсэн энэ 5 дахь өдөр бас хэлэх юм. Тийм учраас бид нарт албан ёсны албан тоотоор хандаач.

Нөгөө талаар гаалийн асуудал нь Төсвийн байнгын хорооны харьяанд байдаг юм байна. Энэ махны экспорттой, тэр тогтолцоотой холбоотой асуудлуудаар бид нарт бичгээр хандаач. Бид нар тэгээд албан тоотоор хандвал дараагийн юунууддаа бид нар уламжлаад энэ асуудал дээр бас Байнгын хорооны зүгээс бас анхаарч ажиллая гэдгээ хэлье.

Гишүүд үг хэлж дууслаа. Энэ асуудал хэлэлцээд дууслаа. Сайд болон ажлын албаныханд баярлалаа гэж хэлье. Дараагийн асуудалд оръё.

18.03 цаг

Барагшун нөөц ашиглалтын талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсьё.

Мэдээллийг Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн сайд Одонтуяа танилцуулна.

Энэ Байгаль орчин уур амьсгал өөрчлөлтийн яамны ажлын хэсгийг танилцуулъя. Одонтуяа Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн сайд, Уранчимэг Байгалийн нөөцийн бодлого, хэрэгжилтийн газрын дарга, Цогтсайхан Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга гэсэн байна. Ажлын хэсэг оруулъя. Сайдын мэдээллийг сонсьё. Одонтуяа сайд мэдээллээ танилцуулна уу.

С.Одонтуяа: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Барагшун дэлхий дээр зөвхөн Төвөдийн өндөрлөг уулс, Монгол болон ОХУ дахь Алтайн нуруу, Дундад Азийн Фамирын уулын бүсийн зарим хэсэгт байдаг нэн ховор, эмчилгээний чанартай байгалийн баялагт тооцогддог ба хэт ашиглалтын улмаас бусад улс орны нөөц нь багассан. Монгол орон Азийн эх газрын барагшун тархалтын төв муж юм.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Барагшун нь далайн түвшнээс дээш 2000 метр болон түүнээс дээш өндөрт хүйтэн, сэрүүн болон хуурай нөхцөлд хадны агуй, гуу жалганд хайлмагтсан, давирхайлаг байдалтай, хар хүрэн өнгөтэй, тослог өөрийн өвөрмөц амт, үнэртэй, олон төрлийн эмийн ургамлын үндэс, эрдэс, макро, микро элементийг агуулан тогтсон байдаг.

Тухайн эко системийн зохистой байдлыг хангахад чухал үүрэгтэй олон мянган жилийн хугацаанд биологи, газар зүй олон хүчин зүйлийн нөлөөгөөр үүсэж бий болдог бөгөөд хадны гагнаас ч гэж нэрлэгддэг биологийн өндөр идэвхт нэгдэл юм.

МУИС-ийн эрдэмтэн, судлаачид 2009 онд хийсэн судалгаагаар барагшун нь хадны барагчин оготнын амьдралын үйл ажиллагааны нөлөөгөөр үүсдэг олон найрлагатай байгалийн эрдэс бодис юм гэж тодорхойлжээ.

Барагшун нь Монгол Алтай улс болох Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймгуудад тархсан ба Говь-Алтай аймаг 58 тонн, Ховд 89 тонн, Увс 140 тонн, Баян-Өлгий, 28 тонн барагшуны нөөцтэй гэж 2009 онд МУИС-ийн Монгол Алтайн барагшуны тархац, гарал үүсэл, химийн бүрдэл судалгаагаар тогтоожээ.

Гэтэл нутгийн иргэн аж ахуйн нэгжүүд их хэмжээгээр бэлтгэн иргэн нөхөн сэргээх боломжийг алдагдахуйц хэмжээнд ашиглаж хууль бусаар бие биеэсээ өрсөж түүж бэлтгэх, дотоодын үйлдвэрлэгчдэд нийлүүлэхгүй шууд гадаадад гаргах сонирхол их байдаг.

Тухайлбал, 2016 онд 17 аж ахуйн нэгж ОХУ, Энэтхэг, БНХАУ руу 2335 тонн түүхий болон хагас боловсруулсан барагшун экспортолсон байдаг.

Тиймээс Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу шинжлэх ухааны байгууллагуудын судалгаа, зөвлөмжийг үндэслэн БОАЖ-ын сайдын 2017 оны 86 дугаар тушаалаар барагшуныг түүхийгээр болон хагас боловсруулсан түүхий эд байдлаар, мөн судалгааны дээжийг 5кг-аас дээш хэмжээгээр гадаад улсад гаргах зорилгоор түүж бэлтгэх, боловсруулах, экспортлохыг 5 жилээр хориглох, 2022 оны 108 дугаар тушаалаар барагшуныг түүж бэлтгэх, ашиглах, худалдах худалдан авахыг 5 жилийн хугацаатайгаар тус тус хориглосон.

Дээрх хугацаанд барагшуны тархац бүхий аймгууд дотоодын үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгжээс ирж буй саналыг авч үзэхэд урт хугацаанд тогтвортой ашиглах, дотоодын үйлдвэрлэгчид, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтран бүтээгдэхүүн хөгжүүлэх, барагшун нь маш удаан хугацаанд бүрэлдэн тогтдог тул түүхий болон хагас боловсруулсан байдлаар экспортлохыг хориглох, эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох гэсэн саналууд ирж байна.

Өнөөгийн байдлаар дотоодын 30 гаруй аж ахуйн нэгж Мал эмнэлгийн хүрээлэн, Биологийн хүрээлэн, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран судалгаа хийж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний стандартыг боловсруулж гаргах, инновац шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг судалж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн ажиллаж байна. Үүний үр дүнд хэд хэдэн үндэсний стандартуудыг батлуулсан байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Мөн Мал эмнэлгийн хүрээлэнгийн эрдэмтэд сүүлийн 25 жил барагшуны чанар, ашиглалтын талаар судалгаа хийж, доктор Энх-Оюун 2014 онд Дэлхийн оюуны өмчийн байгууллага, БНСУ-ын Оюуны өмчийн газрын дэмжлэгтэйгээр барагшун агуулсан тэжээлийн нэмэлт бэлдмэл бэлтгэх арга бүтээлээрээ Дэлхийн оюуны өмчийн байгууллагын алтан медаль, шилдэг зохион бүтээгч шагнал хүртсэн.

Цааш энэхүү бүтээлээр дэлхийд гарах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортод гаргах боломжтой гэжээ.

Цаашид авах арга хэмжээний тал талаар

1.Барагшуны жилд ашиглах боломжит нөөц, нөхөн сэргээх хугацаа, давтамж, найрлага, ач холбогдлыг нарийвчлан тогтоох судалгааг шинжлэх ухааны байгууллагаар хийлгэх.

2.Барагшуны экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоох.

3.Байгалийн нөөцийн ашиглалтын бүсийг тогтоож, жилд ашиглах зохистой хэмжээгээр ашиглах боломжийг бүрдүүлж болно.

Хууль бусаар түүж бэлтгэх явдлыг таслан зогсох зэрэг арга хэмжээг авах.

Хууль бусаар хил гаргадаг байдлыг таслан зогсох.

6.Түүхий болон хагас боловсруулсан байдлаар гадаадад гаргахгүйгээр зохих зөвшөөрлийн дагуу бэлтгэсэн барагшунаар олон улсын стандарт шаардлага хангасан үндэсний брэнд, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, экспортолж эдийн засгийн өндөр үр өгөөжийг бий болгож, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Баярлалаа.

Б.Бейсен: Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Танилцуулчихлаа. Чинбүрэн гишүүнээр тасаллаа. Ганхүлэг гишүүнийг нэмж оруулъя. Үгүй ээ төсөв, Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ цаашид авах арга хэмжээ гээд манайхан ингээд албан даалгавар өгөх байдлаар л хийх гээд шийдэх гээд л үзээд л байгаа юм л даа. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуультай холбогдуулж тухайн үед яамны холбогдох албан тушаалтнуудад аль болох л эдийн засгийн үр өгөөжтэй холбоотой хичээлийг олон удаа хэлж зааж байсан. Тэгээд ерөөсөө хэрэгжихгүй л байгаа юм байна. Энэ зүгээр л ингээд судалгаанд барагшуны нөөц, тархцын судалгаанд хөрөнгө төсөвлөхийг аймгуудад даалгах гээд ингэчихээр энэ аймгууд чинь хийхгүй ээ гэдгийг Уранчимэг дарга та хамгийн сайн мэдэж байгаа шүү дээ. Цогтсайхан дарга бас мэдэж байгаа байлгүй дээ. Та 2 чинь хоорондоо мэргэжлийн хүмүүс шүү дээ энэ тал дээр. Энэ орон нутагт нөөцийн менежментийн эрх мэдэл орлогын хуваарилалтыг нэмэгдүүлэх хэлбэр рүү нь хийж өгөхгүй бол энэ цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чинь хувьд хэрэгжихгүй байхгүй юу. Тэгээд энийг та хэд маань энэ орон нутгийн төсөвт яг оногдох хувийг нь өсгөж

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

өгөөд хариуцлага хяналтыг нь орон нутагт төвлөрүүлээд өгчихвөл болохгүй байгаа юм уу гэдгийг би асуух гэж байгаа юм. Шаардлагатай өөрчлөлтүүдийг хийхэд бас бэлэн байгаа.

Зөвхөн Монгол Улсад байгаа зүйл биш шүү дээ энэ чинь ОХУ-ын Тува, Алтай гээд сая сайд бас өөрөө ч хэлж байна, Хималайн бүс. Тэгээд бид нар энэ байгаа зүйлээ цаашдаа яаж олон улсын түвшинд бас бүсчилсэн хэлбэр дээр авч хамгаалж авч үлдэх вэ гэдэгтэй холбоотой асуудал байхгүй юу. Гол нь энэ барагшуны нөөцийг хамгаалах олон улсын сан энэ тэр шаардлагатай бол байгуулах хэрэгтэй байдаг. Байлаг бол тэнд бид нар тодорхой хэмжээний хамтын ажиллагааг өрнүүлэх зайлшгүй шаардлага байгаа байхгүй юу. Ингэж байж бид нар бүс нутгийн хэмжээнд явагдаж байгаа хууль бус худалдаа, наймаатай холбоотой асуудлыг бас таслан зохих ахиад бид нар тодорхой хэмжээний цахим хяналт шалгалтын цахим системийг нэвтрүүлэх боломжууд энэ тал дээр чинь бүрдэнэ шүү дээ. Тэгээд энийгээ бид нар нөгөө талдаа бас хармаар байна. Энийг та хэд маань юу гэж бодож байгаа юм?

Ер нь манайх ийм сонин хууль зүйн орчинтой л доо. Самар гэхэд Ойн тухай хууль, Байгалийн ургамлын тухай хууль, Генетик нөөцийн тухай хууль гээд 3 хуулиар самрын асуудлыг шийдэж байгаа байхгүй юу. Сая ингээд танилцуулга хийж байгаа угаасаа барагшуны асуудал, Амьтны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Байгаль орчныг хам хамгаалах тухай хууль гэдэг ч юм уу ингээд дахиад ийм хууль, эрх зүйн орчин дээр ашигт малтмалын хууль ч юм уу ингээд олон хууль, эрх зүйн орчин дээр энийг тусгаад өгчихөөр нөгөө хуулийн давхардлаас улбаатайгаар сарних бодлого чинь энэ дотор явагдаад байгаа байхгүй юу. Тэгээд бид нар энийг цаашдаа эрх зүйн орчныг нь маш тодорхой болгож, ангиллын ер нь нэгмөсөн тодорхой болгомоор байгаа яг ний нуугүй хэлэхэд. Энэ чинь байгалийн ховор нөөц баялаг гэдэг байх ёстой юм уу эсвэл?

Б.Бейсен: Хэн хариулах вэ? 5 номер.

Ц.Уранчимэг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг.

Яг одоо байгаа нөхцөл байдал яг хууль, эрх зүйн хүрээнд таны хэлдэг зохицуулалт бол яг тодорхой зохицуулалт байхгүй. Яг тантай санал нэг байна. Амьтны тухай хуульд ч гэсэн зөвхөн барагшин гэдэг оготнын л яг зохицуулалт нь байдаг болохоос биш яг барагшин гэдэг бүтээгдэхүүн үйлчилгээ, яг бүтээгдэхүүнтэй холбоотой зохицуулалт байхгүй. Дээрээс нь экологи, эдийн засгийн үнэлгээ нь тогтоогдоогүй ийм асуудлууд байгаа.

Тэгэхээр Амьтны тухай хууль, Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуулиар яах аргагүй экологи, эдийн засгийн үнэлгээ, үнэ цэнийг нь зайлшгүй хамгийн түрүүнд тогтоох, дээрээс нь бас авч хэрэгжүүлэх арга хэмжээн дотор яг барагшуны жилд ашиглах боломжит нөөцийг тогтоохоос гадна нөхөн сэргээгдэх хугацааг ингээд олон улсын туршлагад нийцүүлж зайлшгүй хийх шаардлагатай байгаа. Мөн бас нарийвчилсан эдийн засгийн тооцооллыг гаргахад яг барагшун гэдэг нь өөрөө яг амьтны баас тухайн тэр барагшин гэдэг оготнын баас, шээс, хэвтэр тэр нөхцөл байдлаас үүсэж байгаа гэдгийг нарийн тогтоох ийм боломжгүй судалгаа,

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шинжилгээг 2009 онд хамгийн сүүлийн байдлаар хийлгэсэн ийм тоо баримт байгаа. Олон улсын жишгээр харах юм бол Энэтхэг улсын сайн жишээ байгаа.

Тэгээд таны хэлдгээр яг олон улсын түвшинд бүсийн түвшинд хамгаалах, тээх хамтарсан ийм судалгаа хийх үнэхээр экспортод гаргах шаардлагатай бид нар био технологийн бүтээгдэхүүн болгож гаргах зайлшгүй ийм хэрэгцээ шаардлага байгаа. Энэ тал дээр илүү уламжлалт анагаах ухааны сургуулиуд судалсан ийм судалгаанууд судар, номд бичигдсэн л ийм судалгаанууд байна дэг. Тэгээд яг энэ та бас асуулаа Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуулиар яг энийг орон нутаг нь судалгаа хийх ёстой гэдэг нь одоо байгаа Амьтны хууль, Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуулиараа байгаа боловч Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайдын багц дээр тухайлсан амьтан, ургамлын асуудал дээр яг хөтөлбөрийн зардал ангилал байхгүй. Судалгаа хийх бас ийм санхүүжилт байхгүйгээр үнэхээр өнөөдрийг хүртэл бас энэ асуудлууд жил болгон төсөв дээр тавьдаг боловч хасагдах байдлаар ингээд явдаг үндсэн суурь судалгаанууд ерөөсөө хийгдэхгүй бас яваад байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн. Одонтуяа сайд хариулах гэж байна уу? Одонтуяа сайд нэмж хариулъя. Дараа тодруулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр ерөнхийдөө энэ талаар ийм товчхон хэлэхэд 2 яг санал явдаг. Нэг нь яг энэ бүтээгдэхүүн маш ховор бүтээгдэхүүн, эргэж нөхөн сэргээхдээ их олон арван, зуун жил шаардагддаг. Тийм учраас энийг түүхийгээр нь гаргаж болохгүй. Энийг аль болохоор Монголдоо нэмүү өртөг шингээж, Монголын брэнд болгож, илүү үнэ өртгөөр зарах шаардлагатай гэж нэг хэсэг хүмүүс бол үздэг. Нэг хэсэг нь надад ингээд баахан хүмүүсээс санал ирсэн байна л даа. Энэ юу гэж үздэг вэ гэхээр энэ чинь нөхөн сэргээгддэг юм. Одоо бол ёстой маш их болчихсон, бид нар энийг түүхийгээр нь зайлшгүй гаргамаар байна. Энэ бүтээгдэхүүн болохоор ерөөсөө үнэ хүрэхгүй, хүн авахгүй байна. Түүхийгээр нь гаргавал Орос, Энэтхэгт их үнэ хүрдэг юм. Маш их том зах зээл байна. Тэгэхээр энэ өөрөө их амархан сэргээгддэг шүү дээ. Энийг түүхийгээр нь гаргамаар байна. Тэр ганц бүтээгдэхүүн хийдэг компанийн лобби яв.../минут дуусав./

Б.Бейсен: Одонтуяа гишүүн гүйцээж хариулъя.

С.Одонтуяа: ...гээд ийм яг 2 талын санал маш их ирдэг. Тэгэхээр үүнийг бид нар ингээд яг судалгаа, шинжилгээний байгууллагаар нотлуулъя гэж байгаа. Яг үнэхээрийн нөөц нөхөн сэргээгддэг юм уу яадаг юм. Саяын миний хэлсэн бүх асуудлыг шийдэх ийм судалгааг хийлгэе гэж байгаа. Яах вэ харамсалтай нь судалгааны мөнгө нь ингээд хасагдчихсан ингээд л төсөвт байхгүй учраас энэ судалгаа байхгүй болохоор яг аль нь зөв юм, буруу юм гэдгийг нь бас тодорхойлоход жоохон хүнд болчихоод л байгаа юм л даа гол асуудал.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм. Тэгэхээр судалгаа, шинжилгээ бид нар байхгүй байгаад байгаа учраас 2014 онд тавиад л, 14 онд хориод л, 16 онд тавиад л, 19 онд үргэлжлүүлж хориод л ингээд явчихсан байхгүй юу. Юу ч байхгүй байна л гэсэн үг. Тэгэхээр бид нар улсын төсөвт нэгэнт хаашдаа байхгүй байгаа тохиолдолд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуультай холбогдуулаад

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бид нар нөөц ашигласны төлбөрөөс орон нутгийн төсөвт оногдох хувийг нь ихэсгэх боломжоор бид нар хангах шаардлага байгаа байхгүй юу.

Нөгөө талдаа таны саяын хэлдэг энэ дотоодын үйлдвэрлэлтэй холбоотой асуудал дээр ч гэсэн жишээлбэл бид нар юу гэдэг юм яаж бид нар цаашдаа дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих юм, технологийн шинэчлэлийг бид нар хэрхэн хийж байгаа гэдэг дээр ч гэсэн манай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам ялт ч үгүй бид нар ажиллах шаардлагатай байна.

Мэдээж жишээлбэл, тодорхой хэмжээнд ашиглаад явах нь ойлгомжтой байгаа тохиолдолд тодорхой хориг арга хэмжээгээ үе шаттайгаар авч явуулдаг байх. Эргээд энэ нь өөрөө зөвшөөрлийг нь бид нар квотын.../минут дуусав./

Б.Бейсен: Гүйцээж асууя Бат-Эрдэнэ.

Б.Бат-Эрдэнэ: Зөвшөөрөл олголтыг ч гэсэн квотын системд шилжүүлдэг юм уу. Ингээд тодорхой хэмжээний бодит арга хэмжээг л хэдүүлээ байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагын хувьд гаргаж явахгүй бол хэн нэгэн сайдын гарч ирснээр хориглодог, хэн нэгэн сайдын гарч ирснээр нөгөө хориглолтыг нь чөлөөлдөг, дараагийн сайд нь гарч ирээд хориглодог ийм эдийн засгийн тооцоо судалгаагүй, нөөцийн судалгаагүй, эрх зүйн орчин дээр ингээд 3, 4 хуулиа тэр харилцааг нь зохицуулж байгаа тодорхой бус хэлбэр дээр байгаа энэ зүйлүүдийг л бүгдээрээ нийлээд л засахаас өөр аргагүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ямар боломж байна гэдгийг манай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам танилцуулгыг аягүй сайн мэдэж байна. Яг л нөгөө хэдүүлээгийн ярьдаг л юмаа л яриад байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр та хэд маань шинэчилсэн бодлого, хөтөлбөрийн хүрээнд тооцож явж байгаа ийм яг та бүхэн мэргэжилтнүүд учраас тэр яг байна уу л гэж би аминдаа Уранчимэг даргаас асуугаад байгаа юм.

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Ц.Уранчимэг: Бат-Эрдэнэ гишүүн яг нөгөө шинэчлэл байна уу гэдэг яг үнэхээр энэ дээр бид нар шинэчлэх гээд Амьтны тухай хууль дээр явж байгаа. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар экологи, эдийн засгийн үнэлгээ, аргачлал байхгүй учраас баргашуны төлбөр ерөөсөө яг экспортлох хэрвээ зөвшөөрөл авахад бол төлбөр тооцоо ерөөсөө авахгүй зөвхөн улсын тэмдэгтийн хураамж авах ийм нэгдсэн тийм зохицуулалтаар яваад явж байсан. Одоо яг Амьтны тухай хууль дээр энэ зохицуулалтыг бол шинэчилсэн найруулгын төсөл дээр хийгээд явж байгаа. Тэгэхээр яах аргагүй суурь судалгаа зайлшгүй хэрэгцээтэй байгаа.

Б.Бейсен: Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Үгүй ээ энэ эрх зүйн хувьд нь нэлээн сонин л юм байна. Тэгээд энэ чинь бүтээгдэхүүн болгоод хөгжүүлчихсэн л юм байна лээ шүү дээ. Шингэн хэлбэрээрээ ч байж л байгаа, хатуу биет хэлбэрээрээ ч байж л байгаа, борлуулалт яваад л байгаа шүү дээ. Экологи, эдийн засгийн үнэлгээ байхгүй, эрх зүйн зохицуулалт байхгүй. Тэгээд яаж тэр хуулийн этгээд гэдэг юм уу, аж ахуйн байгууллагуудад бид энэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн асуудлыг нь явуулаад байгаа юм? Тэгэхээр Байгаль орчны яам иж бүрэн судалгаагаа хийж ,эрх зүйн

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

зохицуулалт, үнэлгээ бүх юмнуудаа оруулж ирж батлуулсан нь дээр. Би тэгж ойлгож байна. Нэг.

Ер нь энэ өөрөө ер нь ямар найрлагатай, ямар хэмжээний нутаг дэвсгэр эзлээд тархчихсан, байгалийн жамаараа хагдардаг эд юм уу, хагдардаггүй эд юм уу? Тэр байгалийнх нь хууль талаас нь судалж үзмээр байгаа юм. Хагдарч барьдаг л юм бол. Тэрийг бид жилд түүдэг барьдаг хэмжээг нь тогтоож өгч, эдийн засгийн эргэлтэд оруулах ёстой шүү дээ. Ер нь бид чинь юм хамгаална гэхээрээ заримдаа учиргүй хамгаалж байгаа нэртэй эдийн засгийн үр ашиггүй болгож боломжоо устгаад л, нэг бол нэлийтэл нь тавиад бүтээгдэхүүнгүй болдог гэдэг юм уу тухайн чиглэлийн нөөцгүй болдог ийм л үйл явц л яваад байгаа юм.

Тийм учраас уг зүйлээ өөрийг нь нэгдүгээрт таних тухай асуудал байна.

Хоёрдугаарт буцаагаад тэрийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах тухай л асуудал байгаа. Энэ талаасаа л энэ асуудал дээр барих бодлого юмнууд нь явах болов уу. Тэгээд үнэхээрийн тийм онцгой чадамжтай амин дэмтэй тийм бүтээгдэхүүн юм бол тэр анагаах ухаан талаасаа судалж, үнэ цэн оруулж дотооддоо хэрэглэх гэдэг юм уу, экспортлох асуудлаа шийдэх ёстой. Тэгээд энэ тал дээр манай яам ямархуу байр суурьтай, хэдүүлээ мөнгөтэй, мөнгөгүй гээд ингээд суугаад баймгүй л байна л даа. Энэ чинь Байгаль орчныг хамгаалах тодорхой сан, төсөл хөтөлбөрүүд бий байлгүй дээ. Тэрнээсээ хэдэн төгрөг гаргаад үнэхээрийн л ийм тодорхой хэмжээнд тархчихсан, бас өөр улс орнуудад их байгаад байдаггүй тэр нутаг усны онцлог байдлаас нь хамаарч бий болдог л бүтээгдэхүүн л юм бол үүнийгээ хэдүүлээ иж бүрэн судлаад, эрх зүйн орчин үнэлгээг нь бүрдүүлээд цаашид боломжтой юм бол тэгээд тэр эдийн засгийн зөв эргэлтэд оруулах, хамгаалах, нөхөн сэргээх энэ юмнуудыг нь хийж явах ёстой.

Би заримдаа ойлгодоггүй шүү дээ яамныхаа хийгээд байгаа юмнуудыг. Одоо бид хэд өнгөрсөн жил гэхэд агнуурын бүс нутгийн менежментийг авч явж байсан аж ахуйн нэгжүүд, байгууллагуудаас тухайн бүс нутгаас агнах ангийн дуудлага худалдаагаар агнана гэж шийдвэр гаргаад хамгаалалтгүй болгоод хаячхаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ байгаль дэлхий.../минут дуусав./

Б.Бейсен: Батжаргал гишүүн гүйцээж асууя.

Ж.Батжаргал: Хэдэн амьтанд чинь био технологийн арга хэмжээ авдаг асуудал байхгүй болчхож байгаа байхгүй юу. Тэр нь эргээд бүс нутгийн хамгаалалт гэдэг юм уу, эдийн засгийн эргэлтийг хүндрүүлж байгаа байхгүй юу. Тэгээд ийм бас янз бүрийн бодлогоор асуудалд хандаж боломгүй юм байна лээ. Тэр орон нутгийнх нь иргэд дээр гэдэг юм уу, яг тэр асуудлыг бас өөрийнхөө бизнесийн харилцаа болгоод явж байгаа тэр улсуудаар нь хамгаалуулдаг, тогтвортой үйлдвэрлэл эрхлэх нөхцөлийг нь бүрдүүлж өгдөг эд нар юмыг энэ байгаль орчны чиглэлийн юмнууд дотроо бодож явахгүй бол зүгээр ч зоосны нүхээр юмыг харчхаж болдоггүй л эд юм байна лээ л дээ. Тэгээд яг энэ шиг энэ барагшун гэдэг юмаа хэдүүлээ зөв таньж, зөв авч явах юм сан. Энэ тал дээр бодол нь юу байгаа юм?

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

С.Одонтүяа: Батжаргал гишүүний асуултад хариулъя. 100 хувь санал нэг байна. Энэ би сүүлээс нь ярьж байна. Энэ агнуурын бүс нутгийн асуудал бас эргээд сөрөг болоод ирсэн. Тэгээд ер нь аливаа зүйл 2 талтай. Энэний яг зөв тунг нь л тааруулах ёстой. Жишээлэхэд энэ агнуурын бүс нутгийг нь дуудлага худалдаагаар явуулдаг болсноос хойш нэг талаасаа энэ ингээд авлигал тэр ил тод байдал бүх юм ингээд цэгцэрсэн боловч нөгөө талаасаа яг хамгаалдаг хүмүүс нь тэнд оролцох боломжгүй болчихсон.

Өөрөөр хэлбэл, яг өөрөө тэр бизнесийн ашиг сонирхолтой хүмүүс чинь мөнгөө гаргадаг, төсвөө гаргадаг, хамгаалдаг. Гэтэл юу гэдэг юм дуудлага худалдаа гэнгүүт бас дурын янз янзын хүмүүс орж ирж бас оролцдог болсон ийм сөрөг тал бий.

Тийм учраас энэ дээр бид нар бас ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа. Ер нь яг ямар хүмүүсийг энэ дуудлага худалдаанд оруулах эрхийг нь нээж өгөх юм бэ, байгаль хамгаалах мөнгө төгрөг зардаг итгэмжлэгдсэн байгууллага ч гэдэг юм уу. Ер нь тэгээд гадаадын энэ ан агнуурынхантай ярихад ч гэсэн жоохон боловсронгуй энэ аж ахуйн нэгж нэлээн олон жил тогтвортой үйл ажиллагаа явуулчихсан, хэлтэй устай, иргэд нь аятайхан үйлчилчихдэг ч юм уу ийм бас зүйл рүүгээ бид нар нэлээн орохгүй бол ийм зүгээр арилжаа маягийн бас юм болоод байгаа энийг бас засъя гэж бодож байгаа.

Судалгаа хийх гээд энэ 130 сая төгрөг л байхад ерөнхийдөө бид нар гол судалгаагаа, анхан шатын судалгаагаа хийчхэж болмоор байгаа. Энийг нөгөө төсөвт тавьчихсан байсан чинь төсөвт энэ хасагдчихсан. Тэгээд өөр олон улсын төслөөр хийе гээд явахаар бас яг энэ барагшин дээр юм нь гарч өгөхгүй байгаа. Энийг 26 оных яг оруулаад судалгаагаа хийе гэсэн ийм зүйл байгаа.

Ер нь нөгөө яг юмаа мэдэж чадахгүй байна л даа. Энэ чинь үнэхээр ийм их хэт их элбэг байгаад байгаа нь үнэн юм уу, эсвэл ховор юм уу гэдэг нь бид нар энэ үнэ цэнийг нь бас энэ судалгааны байгууллагууд тодорхойлох болов уу л гэж бодож байгаа. Тэгээд ер нь энэ бол 115 өвчнийг анагаах чадалтай, чадвартай маш ховор ийм эмийн ургамлын төрөлд орно л гэж үздэг. Зарим эрдэмтэд энэ оготнын баас гэж хэлж байна. Зарим эрдэмтэд энэ хадны халуун, хүйтний юунаас гардаг, гоождог ийм давирхай гээд ч бас ингээд л ирүүлчихсэн л янз янзын л юм байгаа. Тэгэхээр бид нар энэ судалгааг 26 онд ямар ч байсан хийж бодит байдлаа мэдье гэж бодож байна.

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм. Өнөөдөр манай сайд нар маань Их Хурлынхаа төсөвт хандсан тухай л яриа болохгүй байна. Улсын төсвийг Их Хурал баталсан, Ерөнхийлөгч хориг тавьсан, Засгийн газар буцааж татаж аваад өөрөө өргөн барьсан. Үгүй ээ тийм л зүйл шүү дээ. Тэгээд Их Хурлынхан хасаад хаячихсан юм уу, үгүй юм уу би сайн ойлгохгүй л байгаа. Жоохон сайжруулсан харин. Тэрийгээ хүлээх ёстой жоохон сайжруулж өгсөн төсвийг.

Ер нь ийм юм юман дээр хэдүүлээ учиргүй мөнгө төгрөг байгаа, байхгүй энэ тэр гээд яриад хэрэггүй дээ. 130 сая төгрөг бүхэл бүтэн салбарт наад өнөө Ургамал хамгааллын хүрээлэн гэдэг юм уу өнөө хүрээлэнгүүд эд нар чинь хаачсан тэр рүүгээ захиалга юм өгөөд хийлгэчихмээр л юм байна шүү дээ. Их сүйдтэй юм

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

биш л байна шүү дээ. Одоо чинь их наядаар ярьдаг улсуудад чинь 12,0 30 сая төгрөг ч ер нь мөнгө мөн юм уу яг нарийндаа? Тэгээд энэ тал руугаа нэлээн анхаарал хандуулж.../минут дуусав./

Б.Бейсен: Яриулах уу? Үг хэлсэн. Чинбүрэн гишүүн асуулт асууя.

Ж.Чинбүрэн: Би Одонтуяа сайд, энэ Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлттэй газрын Уранчимэг эд нар энэ оруулж байгаад их баярлаж байна. Энэ чухал зүйл. Ер нь зүгээр ингээд бид энэ гарал үүслийн талаар нээрээ энэ сэргээгдэх юм уу, олон мянган жил зарцуулагддаг юм уу гээд судлахлаар энэ чинь бас их удаан хугацаанд бүрэлддэг зүйл байхгүй юу. Ховор зүйл.

Тэгэхлээр энийг ерөөсөө экспортолж ерөөсөө болохгүй ээ түүхий эдээр нь. Энэ заавал бүтээгдэхүүн болох ёстой. Бүтээгдэхүүн больё гэхлээр бид манай энэ эрүүл мэндийн эм үйлдвэрлэлийн процесс дотор дотор нь байгаа нөгөө хүнд металлуудыг нь цэвэрлэх, бохир бодисуудыг нь цэвэрлэж чадахгүй байгаа учраас энэ өөрөө үнэ цэнд хүрч чадахгүй байхгүй юу. Энэ дотор байгаа зүйл ганцхан та бүхэн нөгөө эрдэс энэ тэр гэж яриад байна. Үгүй ээ нэмэх нь амин хүчил, дээр нь фульвик хүчил гэдэг аягүй чухал зүйл байдаг. Фульвик хүчил гээд фульвик асейд гээд энэ яадаг вэ гэхлээр хүний биед хуримтлагдсан хүнд металлуудыг зайлуулах үүрэгтэй байхгүй юу. Тийм учраас гаднын орнууд бүүр тусгай ийм бэлдмэл гаргаад энэ 20-оос 50 доллароор зарагдаж байна шүү дээ. Тэр нь яадаг вэ гэхлээр ерөөсөө л хордлого тайлах гэсэн үг байгаад байгаа шүү. Детоксифайн эффект гэж нэрлээд байгаа юм.

Тэгэхлээр бид оготнын баас гэж ойлгох нь буруу юм байна. Яг үүсэл гарлын бид ганцхан энэ чинь Монголд байгаад байгаа биш гаднын эрдэмтэд судалчихсан зүйлүүд байна. Харин гагцхүү Эрүүл мэндийн яам, уламжлалт анагаах ухаантайгаа нийлээд бүтээгдэхүүн боловсруулах, бүтээгдэхүүний түүхий эдийн чанар, түүнээс бохир бодисыг нь ялгах энэ үйл ажиллагааг илүү сайжруулах, брэнд бүтээгдэхүүн болох. Түрүүн хэллээ шүү дээ энэ тааралддаг газар нь цөөхөн улсууд байна шүү дээ уулархаг газруудад үүсэж байгаа. Тийм учраас энэ чинь өөрөө Монголын брэнд бүтээгдэхүүн байхгүй юу. Би бас харин баяртай байна бүү. Бид энэ түүхий эдээ гадагшаа гаргахыг нь бүүр хориглочих хэрэгтэй. Тэгээд дотооддоо үйлдвэрлэ. эс үгүй бол Трамп харж байна уу татварын бодлогоороо АНУ-д хөрөнгө оруулдаг болох бодлого явуулаад байна шүү дээ. Тэгвэл бид энэ барагшун буюу энэ бүтээгдэхүүнээр сайн бүтээгдэхүүн гаргах тэр технологийн хөрөнгө оруулалтуудыг Монгол Улсад хийх бодлого барих ёстой шүү дээ. Энэ дээр Эрүүл мэндийн яамтай хамтраад, Эрүүл мэндийн яам нь энд оролцох хэрэгтэй. Уламжлалт анагаах ухааныхныг оролцуулах хэрэгтэй. Хуучин бид чинь ингээд л буцалгаад л тэгээд л марлинд шүүгээд л тэгээд л ууж байгаа шүү дээ. Энэ чинь нөгөө уламжлалт анагаах ухаан чиглэлээрээ бол. Энэ чинь дархлаа дэмжинэ, антиоксидант, нойргүйдлээс сэргийлнэ. Олон олон энэ биеийн байдлын доройтлыг эмчлэх, илаарьшуулах үйлчилгээ байгаад байгаа байхгүй юу. Ховор бүтээгдэхүүн. Би энэ дээр 100 хувь санал нэг байна. Тэгэхлээр харин бид энийг хэлэлцүүлж байгаа, энд ярьж байгаа асуудал өөрөө их зөв байна. Хэдүүлээ энийг харин цааш нь улам өргөжүүлж, энэ чиглэлээр уламжлалт анагаах ухаан, Нийгмийн бодлогын байнгын хороогоор сая дамжуулаад энэ асуудлыг бүүр цааш нь дэлгэрүүлээд тэгээд Монгол брэнд бүтээгдэхүүн гаргах нэг том бүтээгд.../минут дуусав./

Б.Бейсен: Үг хэлсэн үү тээ? Үг хэлсэн.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Би энэ барагшунтай холбоотой нэг асуулт асууя гэж бодож байна. Энэ та бүгдийн өгсөн мэдээллээр бараг нөөц Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Увс нийлээд 300 тонн юм байна л даа. Гэтэл энэ 2016 онд нийтдээ 2335 тонн экспортолсон байна шүү дээ. Энэ зөрүү нь хэдэн жилийн цуглуулсан юмыг яаж байна? 1 удаа гаргасан уу. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, одоо баруун аймаг дээр мянган тонн энэ түүхий цуглуулсан байж байна гэж байна. Барагшуны таблет гэдэг буцалсан юугаар нь үйлдвэр явуулж байгаа хэчнээн аж ахуйн нэгж байна? Энэ талын мэдээллийг авъя.

Ц.Уранчимэг: Бейсен гишүүний асуултад хариулъя. Яг таны саяын хэлж байгаа тоо их зөрүүтэй тоо яг харагдаж байгаа. Тэгэхээр яг МУИС-ийн хийсэн 2009 оны судалгаа бол яг энэ тухайн нөөц бүхий газруудад яг барагшун бүхий барагшин оготно амьдардаг яг бүс нутаг дээр нь ийм судалгаа хийж энэ тодорхой яг барагшин гэдэг тоо тоог гаргасан байгаа юм.

2016 онд 17 аж ахуйн нэгж ОХУ, Энэтхэг, Хятад руу гаргасан 2350 тонн нь болохлоор түүхий эдээр нь шууд гаргасан хад, асга, тэр бүх шороо ямар ч боловсруулалт хийгээгүй гаргасан учраас яг барагшун гэдэг ийм хэмжээг нөөц мөн гэж тооцоход бас ийм яг зөрүүтэй тоо яах аргагүй гарч байгаа. Тэгээд 2017 онд яг Байгаль орчны сайдын тушаал гараад ийм тодорхой хэмжээний зохицуулалт хийгээд хориглосон байгаа. 17 оноос хойш 17 он, 22 он, одоо ингээд 26 он гэхэд яг Байгаль орчны сайдын тушаал 5 жилээр хориглосон тушаал нь 26 онд хүчингүй, хүчинтэй хугацаа нь дуусаж байгаа ийм байгаа. Тэр хооронд ерөөсөө судалгаа хийсэн тоо бол яг байхгүй. Дэлгэрэнгүй судалгаа байхгүй байгаа.

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Чинбүрэн гишүүнтэй санал нэг байна. Энэ барагшун 3000 жилийн өмнөөс энэ анагаах ухаанд хэрэглэж ирсэн, 400 гаруй өвчин, эмгэгийг анагаах урьдчилан сэргийлэх увдистай гээд энэ барагшуны талаар танилцуулга байгаа юм. Тэгэхээр ер нь энэ өмнө нь яагаад ингэж 2 удаа хориглоод тушаал гарсан юм бэ гэхээр манай хүмүүс бас ийм Монголчууд зан байна л даа нэг юм зөвшөөрчихөөр бүүр юу ч үгүй болгодог, тэр хавь нь эвдэж сүйддэг, тэгээд л тэр доогуур байсан бүх зүйлүүдийг бүгдийг нь хуу хамаад гаргадаг, хэтэрхий хямдхан өгдөг гээд л ийм зүйлүүд байгаа. Тэрнээс болоод бас тушаал гаргаад 2 удаа хаасан юм байна лээ.

Бид нар яагаад бас энэ дээр ингээд нэг их нээх ч юм уу хурдхан шиг эдийн засгийн эргэлтэд оруулаад гаргая гэж яахгүй байгаа гэхээр хэрвээ энэ ингээд судалгаагаар нөөц нь ийм их удаан бүрэлддэг зүйл бол бас энэ Монгол Улсын хамгийн их ховор.../минут дуусав./

Б.Бейсен: Одонтуяа сайд гүйцээж хариулъя

С.Одонтуяа: Үг юм. Тийм учраас энэ дээр бас болгоомжтой хандъя гэж байгаа. Тэгээд шальдаггүй юм байна лээ. Би энэ хилээр гаргасан юуг нь харахад 1 тонн нь ингээд 900 доллароор зардаг гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр их бид нар энэ ийм 20, 30-хан тонны нөөцтэй юмыг ингээд 900 доллароор зараад дуусчихаар эргээд ямар байдалд орох бол. Тэгснээс таны хэлдгээр тэр технологийн

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шинэчлэлийг нь хийгээд харин бүүр тэр авах бодисоос, хүнд металлаас нь яаж салгах вэ ингээд энэ дээр бүүр сурталчилгааны брэнд болгож хийвэл арай илүү үнэ хүрэх юм болов уу гэж бас бодож байгаа.

Яагаад гэхээр зарим орнууд зүгээр жижигхэн юмны л ясыг л жигтэйхэн бүх юманд сайн гээд л жуулчдаа аваачаад л бүгдийг нь яадаг. Тэгэхээр барагшин дээр энэ бол миний бас хувийн бодол шүү. Би мэдээж тийм учраас эрдэмтэн судлаачидтайгаа бас хамтарч судалгаа хийе л гэж байгаа. Батжаргал гишүүний бас саналыг ч гэсэн сонслоо. Ямар ч байсан 26 онд бид нар энийг яаж хийгээд энэ асуудлыг судалгааг нь хийлгээдэхье.

Б.Бейсен: Барагшуны асуудал дээр бас Байгаль орчны яам бас энэ нөөцийг нь тогтоох шаардлагатай. Нөгөө талаар нөхөн төлждөггүй гэдгийг бас судлах шаардлагатай. Зөвшөөрлийг нь боловсруулсан таблет хэлбэрийн био биологийн идэвхт бодис болонгуут нь Эрүүл мэндийн яаманд зөвшөөрөл өгдөг. Гэтэл хулгайгаар маш их гарч байгаа энэ асуудал энэ буцалгаад ерөөсөө савлаад зарж байгаа. Жишээ нь Хятад, Казахстан, Киргиз, Энэтхэг хүртэл гарч байна энэ хулгайгаар. Тийм учраас энэ дээр тооцоо хийгээд нөхөн төлждөг байна уу, үгүй юү? Хадны юун дээр чинь нөөцийг нь гүйцэд тогтоох ямар ч боломжгүй. Дэлхийн өндөр ууртай бүх улс оронд байдаг. Энэтхэг, Европ, Польш, Дундад Азийн орнууд дээр чинь бас байдаг юм байна. Тэд нар бас боловсруулсан бүтээгдэхүүн болгоод гаргадаг юм байна. Манайд нэг онцлог нь ингээд буцалгаад яачихаар чинь чанар алдчихдаг, нарийн шинжилгээ хийж чаддаггүй, цэвэршүүлж чаддаггүй тийм нөхцөлтэй байдаг юм байна.

Тийм учраас энэ талын асуудлыг бас Эрүүл мэндийн яамтай хамтарч байгаад шийдэхгүй бол буцалгасан юмыг нь хулгайгаар их гаргаж байгаа гээд гадагш. Түүхий эдийн асуудлыг бид нар тагнуулын байгууллагаар бас асуулгаад үзсэн энэ баруун аймагт аймаг болгонд байна гэнэ бараг 1000-аад тонн барагшун цуглуулчихсан түүхий эд нь байдаг юм байна. Тийм учраас байцаагч нар энэ асуудал дээр бас судалгаа хийх шаардлагатай байх гэдгээ хэлье.

Анхаарал тавьсанд баярлалаа. Бас энэ барагшуны талаар мэдээлэл өгсөн сайдад бас баярлалаа. Энэ юутай холбоотой үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Чинбүрэн гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Яах вэ тэгээд барагшин дээр хэдүүлээ бодлогоо зөв бариад явах нь зүйтэй. Барагшуныг бид нар байгалийн ховор ангилалдаа оруулаад тооцох юм уу, энэ эрх зүйн орчныгоо хэдүүлээ маш ойлгомжтой болгож ямар ч байсан энэ асуудлуудаа аль аль талдаа хамтраад явах нь зөв болов уу гэж бодож байгаа. Энэ дээр бас Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороо маань анхаараад цаашаа явах нь зөв. Тодорхой хэмжээнд тусгай хамгаалалттай статус руугаа оруулах юм уу, үгүй юү? Энийгээ бас бид нар бодох ёстой байх.

Хоёрдугаарт, түүхийн болон хагас боловсруулсан экспортын хоригийг сунгах юм уу, үгүй юү гэдгээ үе шаттайгаар шийдэх шаардлагатай гэж харж байгаа юм. Хэрвээ сунгахаар бол зөвшөөрөл өгөх, квоттой холбоотой асуудлуудыг оруулж харах ёстой. Нөгөө нөхөн сэргээлтийн механизмыг бид нар хуулийн хүрээнд нэвтрүүлэх шаардлагатай байх. Энийг бол бид нар зайлшгүй хийх ёстой гэж харж байгаа юм.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Дараагийнх нь бол энэ дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг татвар, санхүүгийн бодлогоор дэмжих ямар бодлого байх боломж байна вэ? Нэгэнт л нэмүү өртөг шингээе, Монгол барагшин гээд брэнд бүтээгдэхүүн бий болгоё гэж байгаа бол энэ дээр бид нар тодорхой хэмжээнд дотоодын үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг татвар болон санхүүгийн түвшинд бид нар яаж шийдэх юм бэ? Дээрээс нь олон улсад бид нар энэ бүтээгдэхүүнээ яаж бүртгүүлэх вэ гэдэгтэй холбоотой асуудал бас байна. Тэгэхээр гэх мэтчилнээс авхуулаад энэ асуудлуудаа хэдүүлээ зоогоод явах нь бол зөв болов уу. Байгаль орчин, уур амьсгалын сан чинь татан буугдаагүй байгаа биз дээ? Тийм, тэгэхдээ сан нь татан буугдаагүй шүү дээ. Дуудлага худалдаа гэдэг бол 2022 оны 6 сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжээд, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд, батлагдаад 23 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байхгүй юу. Тэр үед би сайд байсан. 100 гаруй мянган доллар хэн нэгний кармагаар дамжиж ан агнуурын процесс яваад байсан учраас, нутаг орондоо ээлгүй байгаад байсан учраас л тэр дуудлага худалдаанд оруулах процессыг хийсэн шүү дээ. Тэгэхдээ 50 хувь нь Байгаль орчин, уур амьсгалын санд орж байгаа тэр мөнгөний. Тэр мөнгөний орж байгаа 50 хувиар эргээд тухайн амьтныг хамгаалах ажлыг бид нар хийх боломжтой шүү дээ. Одоо ч боломжтой. Дуудлага худалдаанаас орж байгаа 50 хувийн орлого орон нутагтаа төвлөрч байгаа. Тэр орон нутагт орж байгаа орлогоос эргээд тэр амьтныг хамгаалах мөн идэш тэжээлийг бэлтгэхээс авхуулаад тодорхой үйл ажиллагааг явуулах бүрэн эрх нь хуулиар олгогдчихсон. Одоо ч байгаа.

Нөгөө талдаа Байгаль орчин, уур амьсгалын сан дээр нэгэнт төвлөрч байгаа мөнгө өөрөө тэр чиглэл рүүгээ л явах ёстой учраас тэндээ энэ барагшуныгаа хамгаалдаг юм уу, яадаг юм тэр судалгаа, нөөцийн судалгаагаа хийдэг юм уу үйл ажиллагааны зориулалт дээр нь газрын дарга нар маань сайддаа хуулийнх нь гаргалгаануудыг гаргаж өгөөд энэ нөөцийн судалгаа хийх ажлуудаа эхлүүлчихмээр байгаа шүү дээ.

Тэгэхгүй бол ингээд улсын төсвөөр заавал шийдэх ёстой гээд ингээд хараад байдаг. Улсын төсөв чинь 25 оны улсын төсөв дээр судалгааны мөнгө хасагдчихсан гээд. 26 он яах билээ гээд ингээд явж байх жишээтэй. Болохгүй бол тэр Байгаль хамгааллын итгэлцлийн Сан “Ти Эн Си” байгуулахдаа 71 сая ам.долларын 240 гаран тэрбум төгрөгийн сан байгуулагдаад мөнгө нь бүрдчихсэн шүү дээ хандиваар. Тэр мөнгөнөөсөө эргээд энэ байгаль хамгааллын чиглэл дээр олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа өрнүүлэх чиглэл дээр нөөцийн судалгаа хийх ажлуудаа хийж болно шүү дээ. 130 сая төгрөг чинь юу юм бэ 40 мянган доллар уу? Тэгээд 40 мянган долларыг 71 сая доллароос Ти Эн Си байгууллагатай яриад, зөвшилцөөд тухайн хамтын ажиллагааны хүрээнд хийчих боломжууд нөгөө талдаа бас байгаа шүү дээ. Сая “Ти Эн Си”-гийнхэн чинь 330 сум, 300 гучин ус билүү, хөв цөөрөм билүү тэр дээр чинь хамтын ажиллагаа өрнүүлэе гээд л явж байна лээ шүү дээ. Нөгөө талдаа бас тул загас үржүүлэг дээр чи ч гэсэн мөнгө тэнд тавиад л явж байгаа шүү дээ.

Б.Бейсен: Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Энэ барагшун гээд хэдэн жил аптекаар зарагдаж байгаа юм шүү дээ шингэн хэлбэрээр, савлагдсан хэлбэрээр. Тэгсэн чинь яам хүртэл шинжилгээ юу нь хийгдээгүй зөвшөөрөл нь гараагүй тийм байдалтай яваад байгаа юм уу? Сая

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Чинбүрэн гишүүний хэлснээр тэгж ойлгох шиг боллоо. Энэ бас байгалийн ховор эрэм элемент. Энийг түүхийгээр хэзээ ч гаргаж болохгүй. Яам юу ч гэсэн гартаа авч байгаа юм байна сайддаа баярлалаа. Энийг гүйцэт хийгээд, судалгааг нь сайн хийгээд аль болох өндөр технологиороо хүний эрүүл мэндэд ээлтэй байдлаар худалдаанд гаргавал 400 хэдэн, 496 өвчинд эм болно гээд тайлбар нь тэгж явж байх шиг байсан. Тэгэхээр бид нар гадаадаас маш олон эм тан аваад хэрэглэж байгаа шүү дээ. Энд яамнууд хоорондын уялдаа холбоо жоохон дутмаг байх шиг байна.

Тийм учраас аль болох Эрүүл мэндийн яам, өөр бусад ямар газрууд байна тэд нартай холбоо бариад аль болох энийг хурдан гартаа аваад л ард түмэнд жоохон эрүүл мэндэд нөлөөлөх хэсэг хэмжээний үйлдвэр, шинэ технологи сүүлийн үед тэгж оруулж ирж манай Монгол оронд хөгжүүлэх нь зүйтэй байх гэж би бодож байна. Амжилт хүсье. Баярлалаа.

Б.Бейсен: Чинбүрэн гишүүн үг хэлье.

Ж.Чинбүрэн: Нэмж хэлмээр санагдчихлаа. Түрүүн Одонтуяа сайд бас тонн нь 900 доллар гарч байна гэж байна. Тийм, тэгэхлээр ингээд бодохлоор миний түрүүн хэлдэг тэр фолийн хүчил агуулсан 1000 мг шүү 1гр 20-оос 50 доллар. Хамгийн бага нь 20 доллар гээд бодъё тийм ээ 1гр нь. 1кг нь 20 мянган доллар, 1 тонн нь 20 сая доллар болох гээд байна шүү дээ. Цэвэр бүтээгдэхүүн гаргаж авч чадвал. Тэгэхлээр энэ чинь дэндүү хямд, дэндүү хамаагүй гаргах гэж байгаа асуудал. Дээрээс нь энэ бүрдэх процесс нь өөрөө хагд, хөвд тэгээд чийгшил, дээрээс нь тэр орчных нь ургамал энээ тэрээ аягүй олон зүйл холилдож байж энэ барагшун чинь гарч ирж байгаа. Их цаг хугацаа ордог. Нөхөн сэргээгдэх боломж бага л гэсэн үг шүү дээ. Ердөө л энгийн ойлголтоор. Дээрээс нь монголчууд бидэнд байдаг түгээмэл эрүүл мэндийн том асуудал юу байна гэхлээр одоо та бүхэн монгол эрчүүдэд шинжилгээ сүүлийн үед нэлээн сайн хийдэг болчихлоо энэ хүнд металлын агууламж дандаа өндөр хэмжээтэй байгаа шүү дээ. Тэгээд энэ нойргүйдэл, өвчний гол суурь болоод байгаа энэ бүхэн эмчилдэг юм чинь энэ байхгүй юу.

Тэгэхлээр нөгөө биологийн нэмэлт бүтээгдэхүүн л дээ. Яг шууд эм гэж хэлэхгүй ч гэсэн. Тийм учраас бид яагаад Монгол Алтайн уулсад байгаа барагшун илүү бай гэхлээр дотор нь Эрдэс их баялагтай. Фолвик гээд байгаа тэр хүчлийг байна шүү дээ Хаанаас гаргаж авдаг вэ гээч тусгай бүүр сайн хөрснөөс гаргаж авч байгаа шүү дээ. Бүүр хөрснөөс, шорооноос. Гаргаж авдаг арга нь. Тэгэхлээр барагшунд энэ чинь бүүр зүгээр л хэдэн, бараг 1кг барагшун дотор хэдэн фолийн хүчил л байгаа юм би мэдэхгүй байна. Яг ийм судалгаанууд л хэрэгтэй байхгүй юу. Тэгээд Монгол барагшуны давуу тал нь юу юм? Зүгээр ганцхан фолийн хүчил биш дээрээс нь эрдэс амин хүчлүүд гээд. Энэ болгон чинь өөрийнх нь чанарыг сайжруулж байгаа, чанарыг үнэ цэнтэй болгож байгаа.

Тийм ч учраас Монгол энэ Алтай улс өндөр улсад байгаа энэ барагшуныг авъя гэж түүхий эдийг чинь авах гээд байна шүү дээ. Тийм учраас Одонтуяа сайд яг зөв 26 оноос өмнө ер нь нэлээн олон нотолгоо, энэ салбар хоорондын уялдаагаа бүрэлдүүлээд Эрүүл мэндийн яамтай, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн байж байгаа хамтраад тэдэнд бас мэдээлэл байгаа гэдэгт би итгэлтэй байна. Тэгээд ингээд бүтээгдэхүүн гаргах Монгол Улс өөрөө хөрөнгө оруулалт хийгээд энийг бас хийж болно шүү дээ. Чацарганын тос ямар сайхан “Охь” гээд

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ямар сайхан бүтээгдэхүүнүүд гаргаж чадаж байна тийм ээ? Тэрэнтэй адилхан шүү дээ. Эсвэл хамаагүй хувийн хэвшлийнхэн нь эндээ хөрөнгө оруулалт хийгээд патентаа аваад хийж бас болно шүү дээ.

Тэгэхлээр бид ийм үйлдвэржилтийн үнэ цэнд хүргэдэг энэ барууны энэ технологиудыг бас эх орондоо хэрэгжүүлж чаддаг, хувийн хэвшлийнхэн нь энэ дээр оролцох боломжийг нь гаргаж өгөх, бид нарыг сонсож байгаа энэ нийгэм даяараа энд бас анхаарал тавьж, энэ уламжлалт болон хүний эрүүл мэндэд хэрэгтэй бүтээгдэхүүн гаргадаг компаниуд хүртэл 100 сая, 200 саяын судалгаа гаргаад хийчихэд энэ тийм хэцүү, дааж давшгүй хөрөнгө биш л гэж бодож байна. Энэ хөрөнгө оруулалтыг хийж байж бүтээгдэхүүн патентаа авдаг. Үүгээрээ дамжуулаад үнэ цэнтэй бүтээгдэхүүн гаргаж Монгол Улсыг дэлхийд гаргах, брэндээ гаргах энэ боломж нь энд байна л гэж. Тийм учраас би бас хувийн хэвшлийнхнийг ч гэсэн уриалж байна. Эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа, витамин үйлдвэрлэж байгаа. Гаднаас л юм оруулах гээд л гүйгээд байгаа. Тэгвэл Монголдоо бас хийх боломж үүгээр дамжуулаад байгаа шүү гэдгийг бас олон нийт сонсоосой гэж хүсэж байна.

Б.Бейсен: Энэ барагшуны асуудлаар Байгаль орчны яам Эрүүл мэндийн яамтай хамтраад энэ нөөцийг нь тогтоох шаардлагатай юм байна. Нэгдүгээрт. Нөхөн төлждөг юм байна уу тэрийг нь бас мэдэх хэрэгтэй юм байна. Энэ уг нь гадаадын сайтууд дээр чинь түүхий эдийг нь бас килограмм нь 10-аас 30 доллараар зардаг гээд тийм юм явж байна. Тэгэхдээ энийг нутгийн иргэд бэлдээд бас авдаг улсууд дээр нь зараад дунд нь бас амьдраад залгуулж байсан байна. Тэгэхдээ нууцаар энэ хулгайн аргаар бас их бэлддэг юм байна. Тэгэхээр энийг яаж зохицуулах вэ ер нь? Үнэхээр нөхөн төлждөг байвал квот тогтоох юм уу гэдгийг бас Байгаль орчны яам, сая Бат-Эрдэнэ гишүүний саналтай санал нэг байна. Бас орон нутгийн иргэдийн бас орлогын асуудал, нөгөө талаар үнэхээр нөөц нь бага байвал хориглох асуудлыг, энэ талын асуудлыг бас Байгаль орчны яам ер нь шийдэх нь зөв байх гэж бодож байна.

Нөгөө талаар дотооддоо ингээд нөгөө бэлдэж байгаа, буцалгаад бэлдэж байгаа улсууд дээр биологийн идэвх чанараа бас алдчихдаг гээд би ярьж байна. Тэгээд хулгайн аргаар тэр биологийн идэвхт бодис гэдгээр бас гаргаж байгаа юм байна. Түүхий эдийн гаргахгүй мөртөө. Тэгэхээр энэ асуудал дээр бас судалгаа хийгээд аймаг болгоны Байгаль орчны газартай холбоо бариад нөгөө талаар сая ШУА-ийн Биологийн хүрээлэн эд нартай холбоо барьж байгаад энэ асуудал дээр тодорхой дүгнэлт, дүн шинжилгээ хийгээд ер нь үнэхээр нөөцтэй байна уу, нөхөн төлжиж байна уу, ер нь Монголд хэр их нөөцтэй байна гэдгийг бас тогтоох шаардлагатай байна.

Энэ мэдээлэл танилцуулж, гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

18.48 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ